

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 01-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРОО

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2025 оны 10 дугаар сарын 01-ний өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2 – 7
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	8 – 90

1.	Монгол Улсын 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ./	9 – 13
2.	Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, танилцуулгаа Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./	13 – 56
3.	Гадаад зээл, тусламжийн хэрэгжилт, нөхцөл байдлын талаарх Сангийн сайдын мэдээллийг сонсох	56 – 90

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны
10 дугаар сарын 01-ний өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 29 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 51.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 15 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Л.Энхнасан;

Чөлөөтэй: Л.Оюун-Эрдэнэ, Ж.Энхбаяр;

Эмнэлгийн чөлөөтэй: Л.Гантөмөр, Р.Эрдэнэбүрэн.

Нэг.Монгол Улсын 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ./

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Улсын Их Хурлын гишүүн, Батлах хамгаалахын сайд Д.Батлут, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхтүшиг, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Эдийн засгийн бодлого, төсөөллийн хэлтсийн дарга Ц.Мөнхдэлгэр, Хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн дарга Б.Төгөлдөр, Макро эдийн засгийн бодлогын газрын шинжээч Ж.Өлзийсайхан, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Шадар сайдын ахлах зөвлөх бөгөөд Ажлын албаны дарга Б.Батбямба, Шадар сайдын ажлын албаны референт Х.Сүхбаатар, Гадаад харилцааны яамны Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга Б.Отгонцэцэг, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Л.Гангэрэл, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Л.Отгонтуяа, Зэвсэгт хүчний жанжин штабын дарга С.Ганбямба, Зэвсэгт хүчний жанжин штабын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга П.Эрдэнэбаяр, Батлан хамгаалах яамны Санхүү, хөрөнгө оруулалт хэлтсийн дарга Б.Оюунгэрэл, Онцгой байдлын ерөнхий газрын дэд дарга Я.Гантөмөр, Санхүү, ар талын газрын дарга Т.Мөнхдорж, мөн газрын Санхүү, ар

талын газрын санхүүгийн хэлтсийн дарга Т.Мөнх-Эрдэнэ, Цөмийн энергийн комиссын ахлах нягтлан бодогч П.Номин-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, зөвлөх С.Дунжидмаа, М.Отгон, референт Б.Гандиймаа, Төсвийн байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ё.Энхсайхан, референт С.Тэгшжаргал нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс санал гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс санал гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

Хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 27 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, танилцуулгаа Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Улсын Их Хурлын гишүүн, Батлах хамгаалахын сайд Д.Батлут, Шадар сайдын ахлах зөвлөх бөгөөд Ажлын албаны дарга Б.Батбямба, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхтүшиг, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг, Зэвсэгт хүчний жанжин штабын дарга С.Ганбямба, Онцгой байдлын ерөнхий газрын дэд дарга Я.Гантөмөр, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Эдийн засгийн бодлого, төсөөллийн хэлтсийн дарга Ц.Мөнхдэлгэр, Хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн дарга Б.Төгөлдөр, Макро эдийн засгийн бодлогын газрын шинжээч Ж.Өлзийсайхан, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн, мөн газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав, Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн ахлах шинжээч Н.Уранцэцэг, Д.Отгонжаргал, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн П.Энхманлай, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн мэргэжилтэн Р.Хангал, О.Гантулга, Шадар сайдын ажлын албаны референт Х.Сүхбаатар, Гадаад харилцааны яамны Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга Б.Отгонцэцэг, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Л.Гангэрэл, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Л.Отгонтуяа, Батлан хамгаалах яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Оюунгэрэл, Зэвсэгт хүчний жанжин штабын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга П.Эрдэнэбаяр, Онцгой байдлын ерөнхий газрын Санхүү, ар талын газрын дарга Т.Мөнхдорж, мөн газрын Санхүү, ар талын газрын Санхүүгийн хэлтсийн дарга Т.Мөнх-Эрдэнэ, Цөмийн энергийн комиссын ахлах нягтлан бодогч П.Номин-Эрдэнэ, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын менежер Ю.Энхтуяа, мөн газрын Гүйцэтгэл, нийцлийн аудитор Д.Нямжаргал, Нийслэлийн аудитын газрын менежер Э.Баттогтох, Санхүүгийн аудитын газрын менежер С.Нацагдорж, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүүгийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Баярмаа, мөн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн З.Райымбек нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах

зөвлөх Ш.Хишигсүрэн, зөвлөх С.Дунжидмаа, М.Отгон, референт Б.Гандиймаа, Төсвийн байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ё.Энхсайхан, референт С.Тэгшжаргал, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн ажлын албаны референт Б.Алтан нар байлцав.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлэгтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар, С.Эрдэнэболд, Д.Бум-Очир, Н.Наранбаатар, Ө.Шижир, Ц.Мөнхбат, Д.Ганбат, Г.Хосбаяр, Б.Тулга, Н.Батсүмбэрэл нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Батлах хамгаалахын сайд Д.Батлут, Шадар сайдын ахлах зөвлөх бөгөөд Ажлын албаны дарга Б.Батбямба, Зэвсэгт хүчний жанжин штабын дарга С.Ганбямба, Онцгой байдлын ерөнхий газрын дэд дарга Я.Гантөмөр, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, Э.Болормаа, Ө.Шижир нар үг хэлэв.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 06 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Гадаад зээл, тусламжийн хэрэгжилт, нөхцөл байдлын талаарх Сангийн сайдын мэдээллийг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, зөвлөх С.Дунжидмаа, М.Отгон, референт Б.Гандиймаа нар байлцав.

Гадаад зээл, тусламжийн хэрэгжилт, нөхцөл байдлын талаарх мэдээллийг Сангийн сайд Б.Жавхлан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Тулга, Н.Батсүмбэрэл, Г.Хосбаяр, Д.Ганбат, Х.Жангабыл, Г.Тэмүүлэн нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Гадаад зээл, тусламжийн хэрэгжилт, нөхцөл байдлын талаарх Сангийн сайдын мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 15 цаг 25 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 3 цаг 11 минут үргэлжилж, 29 гишүүнээс 24 гишүүн хүрэлцэн ирж, 82.7 хувийн ирцтэйгээр 15 цаг 26 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 10 дугаар сарын 01-ний өдөр, Лхагва гараг
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхим
12 цаг 15 минут

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн мэндийг хүргэе.

Байнгын хорооны гишүүдийн ирц бүрдсэн байна. Та бүхэнд ирцийг танилцуулъя.

Очирбатын Амгаланбаатар гишүүн, Чинбаатарын Анар гишүүн, Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн, Энхбатын Болормаа гишүүн, Дуламын Бум-Очир гишүүн, Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн, Нанзадын Наранбаатар гишүүн, Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн, Ганбатын Очирбат гишүүн, Буяагийн Тулга гишүүн, Ганбатын Хосбаяр гишүүн, Дамдины Цогтбаатар гишүүн, Өлзийхүүгийн Шижир гишүүн, Сүхбаатарын Эрдэнэболд нарын гишүүд хүрэлцэн ирснээр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2025 оны 10 сарын 01-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Та бүхэнд хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Өнөөдөр манай Байнгын хороо хэд хэдэн хэлэлцэх асуудлууд байгаа. Эхний 12 цагийн хурал маань дангаараа хуралдана.

Ингээд хэлэлцэх асуудал 3 асуудал байна. 3 асуудлын дараагаас Төсвийн байнгын хороонтой хамтарч зээлийн хэлэлцээрийг зөвшилцөх эсэх асуудлыг хэлэлцэх асуудал байгаа.

Нэгдүгээр асуудал. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл байгаа.

Манай Байнгын хорооноос санал, дүгнэлтээ төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлэх товтой байна. Холбогдох сайд, яамдыг дуудаарай.

Хоёр дахь асуудал. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд байна.

Мөн Төсвийн байнгын хороонд танилцуулгаа хүргүүлэхээр байгаа.

Гурав дахь асуудал. Гадаад зээл, тусламжийн хэрэгжилт, нөхцөл байдлын талаарх Сангийн сайдын мэдээллийг сонсохоор байна.

Өмнөх долоо хоногт хэлэлцэхээр байсан. Тодорхой шалтгааны улмаас хойшилсон байгаа. Дангаараа хуралдах гурван асуудал байна.

Үүний дараагаар Төсвийн байнгын хорооны гишүүд орж ирээд хоёр Байнгын хорооны хамтарсан хуралдааны ирц бүрдсэнээр дөрөв дэх асуудал нь Монгол Улс, Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк хооронд байгуулах Зүрх судасны үндэсний төв байгуулах тухай зээлийн хэлэлцээрийн төсөл байгаа.

Засгийн газар 2025 оны 8 сарын 26-ны өдөр ирүүлсэн. Зөвшилцөх асуудал байна.

Даргын зөвлөлөөр хэлэлцэх асуудал дээр 5 дахь асуудал байсан нь Монгол Улс болоод Азийн хөгжлийн банк хооронд байгуулах санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийн төсөл байсан.

Энэ асуудлыг Эдийн засгийн байнгын хороо хуралдаад манайх руу саналаа ирүүлэх байсан учир боловч Эдийн засгийн байнгын хороо хуралдаагүй.

Энэ асуудал ингээд хэлэлцэх асуудлаас хасагдаж байгаа гэдгийг Та бүхэндээ танилцуулъя.

Байнгын хорооны хуралдаанаар өнөөдөр 4 хэлэлцэх асуудал байна. Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүд байна уу? Алга байна. /алх цохив/

Хэлэлцэх асуудалдаа орцгооё.

**Нэг.Монгол Улсын 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл,
2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд
өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
/Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн,
хоёр дахь хэлэлцүүлэг,
Санал, дүгнэлтээ Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ./**

Нэгдүгээр асуудал. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулъя.

Ингээд оролцож байгаа албан тушаалтнуудыг Та бүхэнд танилцуулъя.

Ажлын хэсгийн нэрсийг танилцуулъя.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Л.Гангэрэл, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Л.Отгонтуяа,

Шадар сайдын ахлах зөвлөх бөгөөд Ажлын албаны дарга Б.Батбямба, Шадар сайдын ажлын албаны референт н.Сүхбаатар,

Сангийн яамнаас Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Эдийн засаг, хөгжлийн яамнаас Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү.

Н.Учрал сайд ирж байгаа юу? И.Батхүү дарга. Сайдыгаа дуудаарай. Төсвийн хүрээ учраас Эдийн засаг, хөгжлийн яамтай холбоотой асуудал байна. Н.Учрал сайд.

Эдийн засгийн хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Эдийн засгийн бодлого, төсөөллийн хэлтсийн дарга Ц.Мөнхдэлгэр, Хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн дарга Б.Төгөлдөр, Макро эдийн засгийн бодлогын газрын шинжээч Ж.Өлзийсайхан,

Батлан хамгаалах яамнаас Зэвсэгт хүчний жанжин штабын дарга, дэслэгч генерал С.Ганбямба, тус яамны Санхүү, хөрөнгө оруулалт хэлтсийн дарга, хурандаа Б.Оюунгэрэл, Зэвсэгт хүчний жанжин штабын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, хурандаа П.Эрдэнэбаяр, яамны сайд Д.Батлут байна.

Сангийн яамнаас Б.Жавхлан сайд ирсэн байна. Н.Учрал сайдыг И.Батхүү дарга дуудаарай.

Гадаад харилцааны яамнаас Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхтүшиг.

Л.Мөнхтүшиг дарга ирсэн үү? Гадаад яамнаас Гадаад харилцааны яамны сайд Б.Батцэцэг ирсэн байна. Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга Б.Отгонцэцэг,

Онцгой байдлын ерөнхий газраас дэд дарга Я.Гантөмөр, Санхүү, ар талын газрын дарга Т.Мөнхдорж, Санхүү, ар талын газрын санхүүгийн хэлтсийн дарга, хошууч Т.Мөнх-Эрдэнэ, Цөмийн энергийн комиссын ахлах нягтлан бодогч П.Номин-Эрдэнэ гээд ийм бүрэлдэхүүнтэй оролцож байна.

Шинэ дэгийн дагуу төсөв явна. Гэхдээ төсвийн хүрээ хэлэлцэх эсэх асуудлууд чуулганаар хийгдсэн байгаа. Дэгийн тухай хуулийнхаа дагуу хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэхээр байгаа. Төсвийн хүрээг.

Ингээд хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулаад асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулаад зарчмын зөрүүтэй санал гаргаж байгаа гишүүд байна уу? Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулаад зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу? Алга байна.

Ч.Анар гишүүн байна. Тийм ээ. Ч.Анар гишүүн. 2 дугаар зүйлтэй холбогдуулаад үг хэлж, санал.

Ч.Анар гишүүний микрофоныг өгье.

Ч.Анар: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Г.Тэмүүлэн дарга аа, би гараа өргөж амжсангүй. Төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн хавсралттай холбогдолтой нэг асуудал байгаа юм. Батлан хамгаалахын сайдаас асуух асуулт байна.

Батлан хамгаалахын сайд хавсралт 1 дээр 27.1. “хөгжлийн бодлого баримт бичигт тусгагдсан батлан хамгаалах чиглэлийн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ.” гээд хэмжүүр дээрээ тавьсан байгаа байхгүй юу. 15-аас 30-д хүргэнэ.

Тэгэхээр энэ чинь нөгөө Төсвийн тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль дээрээ ерөөсөө зөрчсөн.

Бүх яамд өөрсдөө хийх, хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрөө задлаад оруулаад ирсэн байхад ганцхан Батлан хамгаалах яам би ажлаа сайн хийнэ гэдэг юм оруулаад ирсэн байх юм.

Энэ чинь өөрөө Төсвийн тухай хуультайгаа нийцэхгүй байна, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуультайгаа нийцэхгүй байна. Үүнийг задалж оруулж ирэх. Дээрээс нь болохгүй бол Эдийн засаг, хөгжлийн яаманд өгсөн саналынх нь дагуу.

Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам энэ саналыг авах ёсгүй шүү дээ. Эсвэл энэ дээрээ зарчмын зөрүүтэй санал гаргах юм уу? Ноднин бас Батлан хамгаалах яаман дээр 11 зарчмын зөрүүтэй санал гаргаж энэ төсвийн тухай хуульд оруулж өгсөн.

Тэгэхээр Д.Батлут сайд энэ 15-аас 30 гэдэг шалгуур чинь ямар төсөл, хөтөлбөр хэрэгжих юм бэ? Энэ ерөөсөө задаргаа нь байхгүй. Энэ чинь болохгүй. Хуульдаа нийцэхгүй байна.

Хоёрдугаарт, та өөрөө үүнийгээ батлуулж авлаа гэхээрээ Үндэсний аудит болон Их Хурал энэ дээрээ ямар төсөл, хөтөлбөр хэрэгжүүлснийг хянаж чадахгүй. 790.0 тэрбум төгрөгөө зарцуулсныг л хянах.

Хоёрдугаарт, Сангийн яам таны төсвийг өгөхгүй болно. Үүнийгээ батлуулаад явлаа гэх юм бол.

Гуравдугаарт, та дотроо Жанжин штабтайгаа яам бодлого дээрээ хэдэн төгрөгөө авах юм? Жанжин штабаасаа төсвөө авах дээр аягүй хүндрэлтэй асуудал үүснэ шүү.

Тэгэхээр энэ дээр яагаад ингэж орж ирсэн юм?

Хоёрдугаарт, үүнийг зарчмын зөрүүтэй санал гаргах юм уу, эсвэл Та өөрөө саналаа оруулах юм уу гэдгийг тодруулъя.

Г.Тэмүүлэн: Ч.Анар гишүүн ээ, энэ төсвийн хүрээний мэдэгдэл явж байгаа. Таны асууж байгаа асуулт төсөвтэй холбоотой хоёр дахь асуудал дээр яригдах асуудал байх шиг байна.

Төсвийн хүрээн дээр үндсэндээ төсвийн төсөөлөл, эдийн засгийн 9 үндсэн үзүүлэлт байгаа. Тэгээд үндсэн үзүүлэлт болох гол дотоодын нийт бүтээгдэхүүн болоод эдийн засгийн өсөлт, зардалтай холбоотой ч гэдэг юм уу энэ 9 асуудлынхаа хүрээнд л яригдахаар байгаа.

Тэгэхээр хоёр дахь асуудал дээр таны асуултад Д.Батлут сайд хариултаа бэлдэж байгаад хариулаад өгье.

Тэгэхээр ингээд үндсэндээ 1, 2 дугаар зүйлтэй холбоотойгоор гишүүдээс гаргаж байгаа санал болоод асуулт байхгүй байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх манай Байнгын хорооны санал, дүгнэлтийг Төсвийн байнгын хороо болон Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ.

Хоёр дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа. /алх цохив/

Н.Учрал сайд хүрэлцэн ирсэн байна. Таныг ирсэнд баярлалаа.

Ингээд Байнгын хорооны санал, дүгнэлтийг Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан хуралдаанд танилцуулах гишүүн. Эдийн засгийн байнгын хороонд байдаг гишүүн Н.Батсүмбэрэл гишүүн байгаа даа. Та танилцуулах уу? Эдийн засгийн байнгын хороонд, Төсвийн байнгын хороонд. Тэгье. Тэгвэл нэг мөр Н.Батсүмбэрэл гишүүн танилцуулаад явъя.

Дараагийн асуудалдаа орцгооё.

**Хоёр.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай,
Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай,
Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай,
Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд
/Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг,
Танилцуулгаа Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./**

Хоёр дахь асуудал байна. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 онд төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 онд төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулъя.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад оролцож байгаа албан тушаалтнууд. Түрүүн ерөнхийд нь дийлэнхийг нь танилцуулсан.

Нэмэгдэж орж ирж байгаа нь Үндэсний аудитын газраас Гүйцэтгэлийн аудитын газрын менежер Ю.Энхтуяа, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл, нийцлийн аудитор Д.Нямжаргал, Нийслэлийн аудитын газрын менежер Э.Баттогтох, Санхүүгийн аудитын газрын менежер С.Нацагдорж гэсэн бүрэлдэхүүн байна.

Сангийн яамнаас түрүүн танилцуулсан. Нэмэлтээр Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн, Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав, Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн ахлах шинжээч Н.Уранцэцэг, Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн ахлах шинжээч Д.Отгонжаргал, Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн

П.Энхманлай, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн мэргэжилтэн н.Хангал, тус хэлтсийн мэргэжилтэн н.Гантулга гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгаа юм байна.

Эдийн засгийн хөгжлийн яамнаас нэмэлтээр орж ирж байгаа Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүүгийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Баярмаа, Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн З.Райымбек, мөн Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхтүшиг дарга ирсэн байна. Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга, бригадын генерал Д.Ганхуяг дарга ирсэн байна. Ингээд ерөнхийдөө ийм бүрэлдэхүүнтэй байна.

Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хууль санаачлагч болоод Монгол Улсын ерөнхий аудитор, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл болоод төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж, үг хэлнэ.

Төсвийн төслүүдийн талаарх асуулт асуух гишүүд байна уу? Гишүүдийн нэрсийг авъя.

Ч.Анар гишүүн орно. Д.Ганбат гишүүнээр тасалъя. Түрүүн Ч.Анар гишүүн дөнгөж сая асуулт асуусан учраас Ч.Анар гишүүний асуултаас эхлээд явъя. Та нэмж хэлэх зүйл байхгүй юу? Шууд хариултаасаа явах уу? Тэгье.

Г.Тэмүүлэн: Д.Батлут сайд асуултад хариулъя. Ч.Анар гишүүний асуулт. Түрүүн асуусан.

Д.Батлут: Та бүхнийхээ энэ өдрийн мэндийг хүргэе. Ч.Анар гишүүний асуултад хариулъя.

Манай батлан хамгаалах салбарын хөрөнгө оруулалтын асуудлууд нууцын зэрэглэлтэй явдаг. Бид бүхэн төсвийн төсөлд Сангийн яам болоод Эдийн засаг, хөгжлийн яаманд жагсаалтаар нь нууцын зэрэглэлтэй хүргүүлж байгаа. Энд бүх л дүнгээр тавигдсан байгаа. Та шаардлагатай гэвэл бид танд тухайлан жагсаалтыг хүргүүлж болно гэдгийг хэлье.

Г.Тэмүүлэн: Ч.Анар гишүүн нэмж тодруулъя.

Ч.Анар: Урьд нь яагаад Батлан хамгаалах яам төсөл, хөтөлбөрүүдээ задаргаатайгаар оруулж ирж байсан юм бол? Нууцын зориулалттай төсөл, хөтөлбөрүүдийг урьд нь төсөв дээр ч гэсэн байсан.

Тэгэхээр тэнд бүхэлдэж орж ирсэн байдаг. төвийн бүсийн, баруун бүсийн барилга, бүтээн байгуулалт гээд орсон байгаа тэр зүйл, заалтыг би сайн мэдэж байгаа.

Тэгэхдээ ингэж орж ирж болохгүй шүү дээ. Тийм ээ. Энэ дотор чинь Батлан хамгаалах их сургуульдаа яах юм, эрдэм шинжилгээндээ яах юм гээд нууцтай хамаарагдахгүй төсөл, хөтөлбөрүүдээ Та заавал ч үгүй задалж оруулж ирэх ёстой шүү дээ.

Г.Тэмүүлэн: Д.Батлут сайд Ч.Анар гишүүний асуултад хариулъя.

Д.Батлут: Асуултад хариулъя.

Урьд нь тоног төхөөрөмжийн зардал гэж бараг батлагдаж байгаагүй юм билээ. Энэ жил бид тоног төхөөрөмжийн зардал гэж оруулж байгаа.

Яг үнэндээ бид бүхэн батлан хамгаалах салбартай холбоотой хөрөнгө оруулалт нэлээн хойрго явж байсан байх. Салбарт асуудал бий. Асуудлыг шийдэх юм манай Монгол Улсын төсөвт бараг хүндхэн тусахаар тийм л нөхцөл байдал байгаа.

Тэгэхдээ бид бүхэн боломж бололцоондоо тулгуурлаад тал талдаа зохион байгуулалт хийгээд ажиллаж байгаагийн хэлбэр энэ юм гэдгийг хэлэх нь зүйтэй байх.

Тийм учраас жагсаалтыг бид бүхэн Сангийн яам болоод Эдийн засгийн яаманд нууцаар хүргүүлээд, тэгээд энд бөөн дүнгээр орж ирсэн явж байгаа юм.

Батлан хамгаалах салбар Үндэсний батлан хамгаалах их сургууль, судалгаа шинжилгээний хүрээлэнгүүдийг бид шинэ түвшинд гаргахын тулд ажиллаж эхэлж байна. Түүнтэй холбоотой тодорхой саналууд ч яваа. Уг нь.

Энэ дотор бүх анги, салбаруудтай холбоотой хөрөнгө оруулалтын жагсаалтууд бүхэлдээ гарсан явж байгаа гэж ойлгож болно гэдгийг хэлье.

Г.Тэмүүлэн: Сангийн яамнаас нэмж тодруулж хэлэх зүйл байгаа юу? Ч.Анар гишүүний асуулттай холбоотойгоор. 8 номер. М.Санжаадорж. Сангийн яам.

М.Санжаадорж: Сангийн яам. Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж.

Гишүүний асуусан асуулт нь 2026 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралт дээр батлагдаж байгаа 26 дугаар зүйл дээр байгаа зэвсэгт хүчний үйл ажиллагаа гээд шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг хэлж байгаа.

- Суурь түвшин 15 байгаа.
- 2026 онд зорилтот түвшин нь 30 байгаа.

Үүнийг жишээ нь цэргийн тоо, хүч хэрэгсэл, барилга байгууламж, байршил нь нууц байдаг учраас бид задлуулж авдаггүй. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, Сангийн яамнаас байгууллагын яг тухайн жилд нь хүрэх зорилтыг хүчээр Та нар ийм юм хийх ёстой гэдэг байдлаар аль болох шахаж авдаггүй.

Зүгээр энэ төсөвтөө Та нар юу хийх юм бэ гэдэг асуулга байдлаар тэрийг илүү төсөлтэй нь уялдуулах гэж хичээж ажилладаг. Тийм. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Ч.Анар гишүүн нэмж тодруулъя.

Ч.Анар: Жишээ нь, оюутан цэргийн хөтөлбөр гээд нийгмийн шинж чанартай олон төсөл, хөтөлбөрүүдийг Батлан хамгаалах яам хэрэгжүүлдэг.

Тэд нар чинь бүгдээрээ ил байгаа төслүүд шүү дээ. Тийм. Хөрөнгө оруулалтын асуудлууд ч байгаа.

790.0 тэрбум төгрөг тэр чигээрээ нууцад орох ямар ч боломжгүй шүү дээ. Энэ талаар би тодруулгуудыг нь холбогдох газруудаасаа авсан. Энэ задалж орж ирээд нууцад хамрагдах юмнууд байх ёстой. Ойлгож байгаа. Тэд нарыгаа ч гэсэн оруулах ёстой.

Төсөв нь бага гэдэг дээр би ч гэсэн санал нэг байдаг.

Зүгээр гол нь энд дараа нь таны үйл ажиллагаа ямар үр дүнд хүрсэн юм бэ гэдгийг бүх юмыг нууцад авч оруулж болохгүй. Төрийн болон албаны нууцын тухай хуулийг гажуудуулж ашигладаг. Дахиад бүхэл бүтэн нэг салбарын юм чинь тэр чигээрээ нууцын ажил хийдэг газар биш шүү дээ.

Нийгмийн, шинжлэх ухааны үйл ажиллагаанууд хийдэг. Задалж оруулж ирэхийг хүсэж байна.

Г.Тэмүүлэн: Д.Батлут сайд аа, Та нэмээд яг тайлбарлаад тодруулаад хэлээч.

Энэ яг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс ч гэсэн задаргааг нь бид гишүүдэд тараагаад өгсөн байгаа шүү дээ. Энэ дотроос чинь 790-ийг чинь үндсэндээ цалин хөлс, нэмэгдэл, урамшуулал ч гэдэг юм уу. Үүнтэй холбоотой зардал нь 490.0 тэрбум төгрөг байгаа ч гэдэг юм уу. Тийм ээ. Ингээд бараа, ажил үйлчилгээ, бусад унаа хоол, нийгмийн даатгал ч гэдэг юм уу, энэ зүйл болгон дээр тайлбар өгөхгүй бол 790-үүлээ бүтэн нууцад байдаг юм шиг тийм буруу ойлголт төрөх гээд байна шүү.

Та яг зөв юугаар ярихгүй бол. Д.Батлут сайд.

Д.Батлут: Яах вэ, 790-үүлээ биш байгаа юм. Манай үндсэн урсгал зардал дээр Зэвсэгт хүчний жанжин штаб дээр байгаа зардлууд жоохон нэмэгдсэн. Бусад нь хасахтай явж байгаа. Дандаа хасахтай явж байгаа.

Үндсэндээ хөрөнгө оруулалтын зардал бол 67.0 тэрбум төгрөг байгаа. Түүнээс 36 орчим тэрбум нь тоног төхөөрөмж худалдан авах. Тэр дотор анги, салбартай холбоотой тоног төхөөрөмжүүд байна.

Мөн дээрээс нь энхийг дэмжих ажиллагаанд дараагийн шатлалд оруулахад шаардлагатай байгаа тоног төхөөрөмжүүд дээр 16 орчим тэрбум төгрөг төсвийн төсөлд явж байна.

Бусад зардлууд нь буюу үлдсэн 31 орчим тэрбум нь анги, байгууллагуудын бүтээн байгуулалтын ажилтай холбоотой зардлууд байгаа.

Тэгээд энэ асуудлыг тэгээд нууцын зэрэглэлтэй л бид бүхэн асуудалд хандаж байгаа. Тагнуулын ерөнхий газартай бид бүхэн ажилласан. Тагнуулын ерөнхий газраас энэ асуудлыг нууцад оруулах тал дээр санал аваад явж байгаа зүйлүүд бий.

Тэгээд энэ болгоныг чинь тэгээд ил яриад байж болохгүй. Тэгээд бид бүхэн тоймлоод асуудлууддаа хандаж байгаа. Хэрвээ Та хүсвэл бүгдийг нь би жагсаалтаар танд хүргүүлэхэд бэлэн байна гэдгээ хэлсэн.

Холбогдох яамдад бид яг нууцын дагуу жагсаалтаар нь хүргүүлж байгаа.

Г.Тэмүүлэн: С.Эрдэнэболд гишүүн асуулт асууя.

С.Эрдэнэболд: Та бүхэнд өглөөний мэнд хүргэе. Бага үдийн мэнд хүргэе.

Гадаад харилцааны яам болон Шадар сайдын онцгой байдлын асуудал эрхэлсэн албан тушаалтнуудаас тодруулах зүйл байна.

Төсөв дээр хилийн чанадад байгаа дипломат үйл ажиллагаа явуулж байгаа газруудын урсгал засвар, байр савны асуудал дээр төсвүүд орсон байна. Яг энэ дээр зүгээр тодорхойлоод асуухад Япон дахь манай Элчин сайдын яаман дээр 2 сард очиход байшин, барилгын асуудал нь цуурсан, хүнд нөхцөл байдалтай. Тэгээд энэ дээр яг шийдэл хэрэгтэй байгаад байна гэсэн.

Яг ийм жишээтэй хэд хэдэн газрууд байгаад байсан. Тэгээд энэ дээр ерөнхийдөө Л.Мөнхтүшиг дарга ирсэн юм шиг байна. Бүтэн ер нь юмнууд нь орж амжсан уу, амжаагүй юу, чадсан уу, чадаагүй юу гэдэг дээр нэг тодруулга авъя.

Тэгээд олон хүн очиж танилцаад л яваад байдаг. Олон жил болсон асуудлууд байгаа. Энэ асуудлууд ер нь нэг жилийн төсөв дээр бүгд орж амжихгүй байх. Тэгэхээр хэдэн жилийн хугацаанд хилийн чанадад байгаа дипломат алба хашиж байгаа хүмүүсийнхээ орчин нөхцөлтэй холбоотой асуудал дээр төсвийг шийдэж чадахаар байгаа вэ? Үүний төсөөллийг сонсмоор байна.

Хоёрдугаарт, сая энэ хавар 4 сараас өгсүүлээд төвийн бүсэд түймэр гарсан. Сэлэнгийн олон суманд түймэр гарлаа. Тэгээд ер нь яг тэнд нөхцөл байдал дээр нь очоод харж байхад маш тоног төхөөрөмж дутуу дулимаг байна лээ.

Их Хурлын гишүүн Ц.Туваан, Далайн Батбаяр бид хэд гал унтраагч төхөөрөмжүүд авч өгөөд. Сангийн сайд тухайн үед ярьж байгаад Б.Жавхлан сайд Засгийн газрын нөөц хөрөнгөөс тодорхой зардлуудыг гаргуулаад энэ түймэртэй тэмцэх ажил дээр нэлээн л явсан. Тийм ээ.

Тэгээд тухайн үед Онцгой байдлын тэргүүн дэд даргаас асууж байхад ер нь улсын хэмжээнд ингээд иж бүрнээр нь энэ асуудлыг шийдэхийн тулд бараг 800 орчим тэрбум төгрөгийн санхүүжилт хэрэгтэй, шаардлагатай гэсэн хариу өгч байсан.

Тэгээд 800 нь ч юу юм. Ер нь үе шаттайгаар энэ асуудлуудыг ер нь яаж шийдэх вэ гэдэг асуудлууд яригдаж байсан. Жишээлбэл, Дархан-Уул аймагт гэхэд, гол устай газар гэхэд иж бүрэн аврагчийн хувцас гэхэд нэгхэн ширхэг л байх жишээтэй. Комоороо 30 сая төгрөгт багтах жишээтэй. Гэтэл тэнд чинь зэрэг зэрэг аюулын дуудлагууд ирсэн тохиолдолд үүрэг гүйцэтгэх боломжгүй. Нэг хувцсыг хэрэглээд гаргахад тэр нь хатаах хугацаа гээд дараагийн бэлэн байдалд бэлэн биш ч гэдэг юм уу. Энэ гал, усны аюул чинь өөрөө хэлж ирдэггүй хийсэж ирдэг аюул. Гэхдээ энд бэлэн байдалтай байх зайлшгүй шаардлагатай юм билээ.

Тэгэхээр энэ дээр жишээлбэл ямар хэмжээний. Яах вэ, энд төсвүүдийг нь харж байгаа юм. Тэгэхээр энэ төсвүүд жишээлбэл дараа жил дахиад аюулын нөхцөл байдал бий боллоо. Гамшиг давтагдлаа гэхэд ер нь ямар түвшинд энэ хангагдаж байгаа вэ? Энэ төсвийн хүрээнд. Төсөвт тусгуулсан асуудлаар.

Хариултаас нь хамаараад тодруулах зүйл байвал асууна. Энэ хоёр асуултыг асууя.

Г.Тэмүүлэн: С.Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя. Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг сайд. Дараа нь Онцгой, Шадар сайдын ажлын алба.

Б.Батцэцэг сайдын микрофоныг өгье.

Б.Батцэцэг: С.Эрдэнэболд гишүүнд баярлалаа.

Манай дипломат төлөөлөгчийн газруудын байшин, барилгад анхаарал хандуулж байгаад.

Японы Элчин сайдын яамны барилгыг нураагаад буулгах нэг хувилбар. Тэгээд төсөвт дарамт учруулахгүйгээр шийдэх хоёр, гурван гарцыг бид хоёр, гурван жил ярьж байгаа юм.

Тэгээд одоо ерөнхийдөө шийдлийг нь олох гээд ажиллаж байна.

Хэрвээ буулгаж нураахаар бол доор хаяж 30.0 сая долларын зардал гарахаар байгаа. Үүнийг төсөвт суулгаагүй байгаа.

Манайх нийтдээ 50 дипломат төлөөлөгчийн газар ажиллаж байгаа. Эндээс өөрийн байртай газрууд арай цөөхөн. Гэхдээ бид засвар хийх зайлшгүй шаардлагатай маш олон барилга, байшинтай болсон. Тэгээд өнгөрсөн жил яах вэ бид 2 том дипломат төлөөлөгчийн газарт засвар хийж чадсан. Энэ жил хэд хэдэн газар засвар хийхээр зардлуудаа л тавиулсан байгаа.

Тэгээд жилд ядаж нэгээс хоёр байшин, барилгыг засаад явъя гэдэг ийм төлөвлөгөөтэйгөөр ажиллаж байгаа.

Г.Тэмүүлэн: Онцгой асуудлаар хэн байна? Онцгой байдлын ерөнхий газраас Я.Гантөмөр дарга. 2 номер дээр. Я.Гантөмөр дарга. Онцгой байдлын ерөнхий газрын дэд дарга. 2. Номер.

Я.Гантөмөр: Эрхэм гишүүдийн амрыг эрье.

Миний бие Онцгой байдлын ерөнхий газрын дэд дарга, хурандаа Я.Гантөмөр илтгэж байна.

С.Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя.

Өнөөдөр Монгол Улсад

- 171 гал унтраах анги байхаас 69 анги үүрэг гүйцэтгэж байна.
- 66 эрэн хайх, аврах нэгж байхаас 51 анги, салбар үүргээ гүйцэтгэж байгаа.

Өөрөөр хэлбэл үйлчлэх хүрээ нь 77.0 хувьтай байгаа.

Өнөөдрийн байдлаар Онцгой байдлын ерөнхий газрын хангалт, хувцас хэрэглэл, тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмжийн хангалт 57.0 хувьтай байгаа.

Энэ бол сүүлийн жилүүдэд өсөн нэмэгдэж байгаа боловч хангалттай үзүүлэлт биш байгаа юм.

Ийм учраас сая түймэр гарах... /минут дуусав/

Г.Тэмүүлэн: 2 номер хариултыг гүйцээе.

Я.Гантөмөр: Түймэр гарах үед Засгийн газрын 2 удаагийн тогтоолоор 11 тэрбум төгрөгийн техник, тоног төхөөрөмж, хувцас хэрэглэлийн хангалтыг нэмэн шийдвэрлэж өгсөн.

Ирэх онд 29.0 тэрбум төгрөг суусан байгаа. Үүнээс гадна Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжих төслийн 100.0 сая долларын төслийн хүрээнд бид саналаа боловсруулаад Сангийн яаманд хүргүүлсэн байгаа.

Энэ төсөл хэрэгжсэний дараа хангалтын хувь хэмжээ 80.0 хувьд хүрнэ гэсэн тооцоололтой байгаа. Илтгэж дууслаа.

Г.Тэмүүлэн: С.Эрдэнэболд гишүүн нэмж тодруулъя.

С.Эрдэнэболд: Гадаад хэргийн сайдын хариулт дээр хэлэхэд ер нь хэдүүлээ бас бодож байхгүй бол шүү дээ.

Тэр Японд байгаа Элчин сайдын яамны байр, газар хөдлөлтийн чичирхийллээс болоод цав гарсан байгаа байхгүй юу. Цав гараад тэгээд тэндээс нь тодорхой хэмжээгээр барилгын материалууд унасан. Явган хүний зам дээр. Яг хажууд нь хүүхдийн цэцэрлэг байх жишээтэй.

Тэгээд тэр хүүхдийн цэцэрлэгийн ямар нэгэн байдлаар ямар нэгэн аюулын зэрэг нь нэмэгдээд хүүхэд дээр унаад. Яагаад гэхээр дипломат хуулиараа Элчин сайдын яамны газар нутаг чинь манай улсын юу байгаа шүү дээ.

Тэгэхээр манай улсын нутаг дэвсгэр дээр гэж тооцогдох юм бол тэндээс нь ямар нэгэн барилгын материал унаад, ямар нэгэн хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой аюул учруулах нөхцөл байдал үүссэн байгаа юм. Бүр онцгой. Тэгээд хажуу талынх нь тэр цэцэрлэгээс нь манай Элчин сайдын яам руу удаа дараа ханддаг байдалтай. Гэх мэт асуудал дээр бид жоохон анзаарч онцгой түвшинд авч үзэхгүй бол бусдын амь нас, эрүүл мэндэд аюул учирсан нөхцөл байдлын дараагаар улам том асуудал гарах вий дээ. Зүгээр үүнийг анхааруулж хэлж байгаа юм.

Г.Тэмүүлэн: Санал, үг хэллээ. Д.Бум-Очир гишүүн асуулт асууя.

Д.Бум-Очир: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе.

Гадаад харилцааны сайдаас асуулт асуух гэсэн юм. Юуны өмнө Гадаад харилцааны сайд болон Гадаад харилцааны яамны хамт олонд талархаж байгаагаа илэрхийлмээр байна.

Би чуулган дээр хэлж байсан. Хилийн чанад дахь Монгол иргэдийн эрх ашгийг хамгаалах лобби бүлэг буюу дэмжих бүлэг энэ оны эхээр байгуулагдсан.

Гадаад харилцааны яам маань энэ асуудал дээр бидэнтэй нягт байнга хамтран ажиллаж байгаа. Бас олон ажлын ард гараад явж байгаа гэдгийг би Та бүхэндээ дуулгаад, гадаадад байгаа иргэд болон лобби бүлэгт байгаа гишүүдийнхээ өмнөөс тусгайлан талархаж байгаагаа илэрхийлэх гэсэн юм.

Тэгээд үүнтэй холбоотой хэд хэдэн зүйлийг тодруулаад асуумаар байна. Гадаад харилцааны сайдын нийт зардал дээр хөтөлбөрөөр гэдэг дээр “Гадаад улс оронд байгаа Монгол иргэдэд туслах” гэсэн нэг ийм заалт байна.

Энэ дээр ямар ямар ажлууд хийгддэг юм бол гэдгийг тодруулж өгөөч ээ.

Дараагийн нэг зүйл. Энэ байгууллагаар гэдэг дээр “Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сан” гэж байгаа юм байна. Энэ сангийн үйл ажиллагаа болоод сан дээр тавигдсан мөнгө төгрөг юунд зарцуулагдаж байгаа талаар тодруулж өгнө үү?

Түүнчлэн бас нэг зүйлийг би хайгаад яваад байгаа. Нөгөө ЮНЕСКО дээр манайхан нүүдэлчдийн соёлын ном бичнэ гэсэн гээд. Тэгээд Боловсролын яаман дээр байж байгаад дараа нь Эдийн засаг, хөгжлийн яам руу нөгөө хүрээлэнгүүд явахад тийшээ явсан юм шиг болоод. Тэгээд хайгаад яваад байсан. Миний ойлгосноор энэ ЮНЕСКО-ын Үндэсний комисс руу тэр үүрэг нь явсан юм болов уу гэж. Би буруу мэдээлэл авсан байж магадгүй шүү. Тэгээд энэ нэг ном би байсан мөнгө маань хаана ч сууж чадахгүй хэдэн яамны дунд алга болоод байгаа юм.

Тэгэхээр ЮНЕСКО-ын Үндэсний комисс дээр тэр мөнгөнд суусан юм байгаа юу гэдгийг тодруулах гэсэн юм. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Д.Бум-Очир гишүүний асуултад хариулья. Б.Батцэцэг сайд.

Б.Батцэцэг: Д.Бум-Очир гишүүнд баярлалаа.

Хилийн чанад дахь иргэдэд бид олон жил тусалж чадаагүй байсан. Өнгөрсөн 2 жилийн хугацаанд бага сага мөнгө гадаадад сурталчлах зардлынхаа хүрээнд хилийн чанад дахь иргэдийн санаачилгаар зохион байгуулж байгаа олон нийтийн арга хэмжээ, спорт, урлагийн арга хэмжээнүүдэд тодорхой хэмжээгээр дэмжлэг үзүүлж байгаа.

Тэгээд Монгол судлал, Монгол хэлний сургалтын төвүүдийг нь дэмжлэг үзүүлэх байдлаар ажиллаж байгаа.

Хоёрдугаарт нь, иргэдэд туслах сан гэж жижиг зардал байдаг. Энэ 200, 300 саяас эхлээд, энэ жил харин 715.0 сая төгрөгөөр төсөвлөсөн байгаа. Энэ иргэдэд туслах сан голдуу хилийн чанадад асуудал, бэрхшээлд орсон иргэддээ тусалдаг. Үүний бараг 80 орчим хувийг нь дандаа амь эрсэдсэн иргэдийн шарилыг зөөх, тэгээд эх орондоо буцаж чадахгүй байгаа янз бүрийн нөхцөл байдалд орсон иргэдийн зорчих онгоцны билет, тэгээд хэрэг төвөгт холбогдоод шоронд хоригдож байгаа иргэдийг эргэх ийм зардалд зарцуулагддаг.

ЮНЕСКО-гийн хувьд Монголын үндэсний комисс маш бага төсөвтэй. 10 орон тоотой ийм байгууллага байгаа. Энэ дээр энэ жил харин бид 981.0 сая төгрөгийн төсөв тавьсан. Таны дурдсан номын зардал энд ороогүй байгаа. Үүний ихэнх нь урсгал зардал байгаа.

Г.Тэмүүлэн: Д.Бум-Очир гишүүн нэмж тодруулъя.

Д.Бум-Очир: Баярлалаа. Саяын миний асуусантай холбоотойгоор бичгээр юм уу, ямар ямар зардал яаж яасан юм бол. Надад хүргүүлэх боломж байна уу?

Яагаад гэхээр иргэд их асуудаг. Мэдээлэл авъя гэдэг.

Тэгэхээр тэр мэдээлэл манай энэ дэмжих бүлэгт байж байвал бидний ажилд бас дэм болох гээд байгаа юм. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Д.Бум-Очир гишүүнд тэр нэмэлт мэдээллүүдийг гаргаад өгөөрэй гэдгийг хэлэх байна. Гадаад яамныханд.

Н.Наранбаатар гишүүн асуулт асууна.

Н.Наранбаатар: Бүгдэд нь энэ өдрийн мэнд хүргэе.

Саяхан тойрогтоо ажилласан. Бовийн бүс. Тэгээд цэргийн анги, нэгтгэлүүдээр орлоо, танилцлаа. Ялангуяа суманд. Улаанбадрах сум, Хатанбулаг сум гээд. Тэгээд зэвсэгт хүчний анги, салбарууд, хилийн цэрэг, онцгой.

Яах вэ, хилийн цэрэг гайгүй юм. Ер нь зэвсэгт хүчнээ бодвол хөрөнгө оруулалтууд нэлээн сүүлийн жилүүдэд хийгдээд, шинэ байшин барилга, зарим нь. Ялангуяа Сулинхээрийн отряд хувцас хунар, хангалт гайгүй юм.

Манай Зэвсэгт хүчний анги, салбарууд юмнууд нь хуучирсан байна шүү. 70-аад, 80-аад оны барилга, байшинтай. Тэгээд гар хүрээгүй, засвар хийгээгүй.

Суманд байгаа төрийн албан хаагчид ер нь байр, орон сууц л их ярьж байна. Харьцангуй цалин мөнгө одоо нөгөө Сангийн яам, орон нутгийн нэмэгдэл гээд төрийн албаны хуульд 40 хувийн нэмэгдэл өгдөг болсон учраас бас учиртай. Зарим аймгууд бүр 40 хувийг нь 80 хувь болгож нэмж өгөөд. Дээрээс нь “нутгийн дэм” гээд 400-аас 600 мянган төгрөг өгөөд. Ингээд цалин хөлсний хувьд учиртай болж, суманд.

Учиргүй цалин яриад өөдөөс ингэж байгаа газар ховорхон байна. Орон сууцын асуудал. Тухайлбал, Хатанбулаг дээр байгаа Зэвсэгт хүчний анги, салбарт 8 айлын 2 орон сууц байна. Нэгийг нь засаад 8 айл оруулсан юм байна. Одоо нөгөөхийг нь засах юм бол бас 8 айл анги, салбараасаа оруулах боломж бас байгаа юм байна шүү. Тэр дээр танай урсгал засвар юмнууд энэ жилийнх нь хэр бололцоотой байгаа юм? Ирэх жилийн урсгал засвар дээр нэмэгдэж байна уу, хасагдаж байна уу? Ямар боломж байна?

Бид заавал шинэ хөрөнгө оруулалт, шинэ барилга байшин гэхээсээ илүү одоо байгаагаа бага төсөв зардал гаргаад. Миний ойлгосноор 180-аад сая төгрөг байвал 8 айлд 8 албан хаагчид нь гэр бүлээр орох бололцоо байгаа юм билээ. Тэр дээр Та бүхэн мэдэж байгаа юу, үгүй юу? Хүсэлт юмнууд анги, салбараас чинь ирсэн юм байна уу, үгүй юу? Боломж байгаа юу, үгүй юу? Ирэх жилийн төсөвт нь оруулах боломж байгаа юу гэж.

Нөгөө талаар Хатанбулаг сум, Ханги, Мандалын боомт гээд хүн ам ихтэй газар галын аюул, байгалийн гамшиг гарах бүрэн нөхцөл бүрдсэн. Барилга, байшингууд баригдаад байдаг. Ганц галын машин байхгүй л байж байна шүү дээ.

Тийм учраас үүнийг Та бүхэн мэдэж байгаа юу? Анхаарч байгаа юу? Хуучин нойтон ч хамаа байхгүй тийш нь галын машин явуулахгүй бол болохгүй.

Тэгээд хүний хөдөлгөөн, түүнийгээ дагаад барилга, үл хөдлөх хөрөнгүүд нэлээн баригдаж байгаа. Байшин, барилга их баригдаж байгаа учраас энэ дээр онцгой анхаарах хэрэгтэй.

Хатанбулаг сумын удирдлагууд ярьж л байна. Манайхыг биеэ даасан, аймагтаа, улсдаа орлого төвлөрүүлсэн гэж байгаа мөртлөө ганц галын машин авч чадахгүй. хажууд байгаа анги, салбартаа 8 айлын орон сууцыг нь засаад өгөх мөнгө байхгүй. Бүгдийг нь дээшээ татаад авах юм. Энэ төсөв чинь ер нь

яаж хуваарилагдаж, яаж төлөвлөгдөөд байгаа юм бэ гэдэг ийм зүйлийг сумын удирдлагууд яриад сууж байх. Тэгээд хариултаас тодруулъя.

Г.Тэмүүлэн: Н.Наранбаатар гишүүний асуултад хариулъя. 1 номер. Жанжин штабын дарга С.Ганбямба дарга.

С.Ганбямба: Эрхэм гишүүдийн амрыг эрье. Зэвсэгт хүчний жанжин штабын дарга, дэслэгч генерал С.Ганбямба.

Н.Наранбаатар гишүүний асуултад хариулъя.

Яг Н.Наранбаатар гишүүний ярьж байгаагаар ер нь Зэвсэгт хүчний жанжин штаб бие даасан хөрөнгө оруулалтын төсөвтэй байгаагүй. Тэгээд Батлан хамгаалах яам, Сангийн яамны дэмжлэгтэйгээр 2024 оноос бие даасан хөрөнгө оруулалтын төсөвтэй болсон.

Мөн урсгал засварын төсвөөрөө байшин барилгыг сайжруулах ажил хийгдэж байгаа. Монгол Улсын Зэвсэгт хүчин өөрөө том айл. 3200 барилга, байгууламжтай. Түүний 80 орчим хувь нь 40-өөс дээш жилийн насжилттай.

Тэгээд бид сүүлийн 3 жилийн хугацаанд алба хаагчдынхаа ажиллаж амьдрах орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр ялангуяа хуучин барилга, байгууламжуудаа их засвар хийх, урсгал засвар хийх, сайжруулах талаар нэлээдгүй ажил хийгдэж байна.

2024 онд бид ялангуяа хугацаат цэргийн алба хаагч амьдардаг цэргийн байруудыг бүрэн хэмжээгээр гадна фасад, дээврийн засварын ажлыг бүрэн хийж хэрэгжүүлсэн.

➤ Ноднин 50 гаруй байшинд хүрсэн.

➤ Энэ жил 2025 онд 120 орчим байшингийн засварын ажлуудыг хийж хэрэгжүүлж байна.

Н.Наранбаатар гишүүний хэлж байгаа яг үнэн. Манай зэвсэгт хүчний байшин, барилга үнэхээр хуучирсан муудсан юмнууд байгаа.

Тэгэхдээ би зүгээр байгаагүй. Яг саяын миний хэлснээр засвар, тохижилтын ажлуудыг хийж байна.

Дээр нь алба хаагчдын албан тушаалын орон сууцын асуудлыг яг таны хэлж байгаагаар тэр жижиг салбарууд дээр, агаарын цэргийн болон бусад жижиг салбарууд дээр сумдад байгаа жижиг салбарууд дээр 8 айлын албан тушаалын орон сууцыг барих чиглэлээр шийдэж байна. Тухайлах юм бол энэ жил гэхэд бид Говь-Алтай аймгийн Алтай сумд байрлах агаарын цэргийн салбартаа 8 айлын байшин барьж өгч байна.

Өнгөрсөн жил 2 газар 8 айлын албан тушаалын байрыг барьсан байгаа. Хэнтий аймгийн Дэлгэрхаанд байдаг 232 дугаар анги, мөн Баян-Өлгий Улаанхус суманд байдаг салбар гэх мэтчилэн сүүлийн жилүүдэд төсөв, хөрөнгө тодорхой хувиар ахисантай холбогдуулаад байшин, барилгыг сайжруулах ажил хийгдэж байгаа гэдгийг Та бүхэнд илтгэе. Дууслаа.

Г.Тэмүүлэн: Онцгойгоос Н.Наранбаатар гишүүний асуултад хариулъя. Я.Гантөмөр Онцгой байдлын ерөнхий газрын дэд дарга. 2 номер.

Я.Гантөмөр: Н.Наранбаатар гишүүний асуултад хариулъя. Дэд дарга, хурандаа Я.Гантөмөр.

Дорноговь аймгийн Хатанбулаг сум буюу Ханги, Мандалын боомт дээр гал түймэр унтраах, аврах гуравдугаар зэрэглэлийн анги байгуулагдах Засгийн газрын тогтоолоор шийдвэр гарсан.

Энэ хүрээнд орон нутгаас орон байрыг нь бэлдэж өгөөд, тэгээд онцгой байдлын байгууллагаас томилгоо болоод техник, тоног төхөөрөмжийн хангалтыг хийх ёстой.

Одоогийн байдлаар дөнгөж байрны асуудал шийдэгдээд явж байна. Бид 2026 онд байр байшинг нь засах, засварлах, орон тооны томилгоо болоод техник, тоног төхөөрөмжийн хангалтыг 2026 ондоо багтааж хийнэ. Илтгэж дууслаа.

Г.Тэмүүлэн: Болсон уу? Н.Наранбаатар гишүүн. Нэмж тодруулах уу? Н.Наранбаатар гишүүн.

Н.Наранбаатар: Сангийн яамнаас тодруулъя.

Энэ орон нутгаа, сумдаа, аймгуудаа өөрсдийгөө санхүүжүүлдэг болсон гээд байх юм. Тэгээд энэ сум, тэр аймгууд нь юу ч мөнгөгүй байх юм байна шүү дээ.

- ▶ 8 айлын орон сууц засах 100 хэдэн сая төгрөг ч байхгүй.
- ▶ Сумдаа боловсон жорлон хийх мөнгө ч байхгүй.
- ▶ Гал унтраах нэг машин авах мөнгө ч байхгүй.

Тэгсэн мөртлөө Хатанбулаг сум чинь өөрийгөө санхүүжүүлдэг гээд байх юм. Үгүй, тэгээд үүнийг ерөөсөө ойлгомжгүй юм. Өөрт нь тэгвэл сумынхаа жижиг сажиг, энэ чинь улсын төсвийг бүрдүүлж байгаа, аймгийн төсөв бүрдүүлж байгаа юм бол жижиг сажиг наад захынхаа юмыг, сургуулийн анги, танхимийнхаа ядаж паарыг солих, хагархай цонхоо солих хэмжээний мөнгө төгрөг үлдээж болдоггүй юм уу?

Тэгээд энэ чиглэлээр өөрчлөлт хийх юм уу, үгүй юм уу? Бүсчилсэн хөгжил, орон нутгаа хөгжүүлнэ гээд байх юм. Бүгдийг нь Та бүхэн энд татаж авчхаад нэг жоохон дусаагаад суугаад байх юм уу? Энэ дээр ямар бодлого Та бүхэн барьж байгаа юм?

Г.Тэмүүлэн: Сангийн яамнаас хариулъя. 8 номер. М.Санжаадорж.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж. Н.Наранбаатар гишүүний асуултад хариулъя.

Ирэх жилийн хувьд 32 их наяд 980.0 тэрбум төгрөгийг төсөвлөсөн байгаа. Энэ нь нэгдсэн төсвөөрөө буюу бүх шатны төсөв нийлээд гэсэн үг. Үүнээс

- ▶ Нийгмийн даатгалын сан 6.3 их наяд төгрөгийг зарцуулна.
- ▶ Эрүүл мэндийн сан 2.2 их наяд төгрөгийг зарцуулна.

Ингээд орон нутгийн төсөв 7.4 их наяд төгрөгийг зарцуулахаар байгаа.

Үлдсэн 15, 16 их наяд төгрөг нь улсын төсөв дээрээс зарцуулагдаад явна гэсэн үг.

Тэгэхээр харьцааны хувьд нэг ийм харьцаатай байгаа. Ер нь төсвийн харилцааны хувьд ямар юм явдаг вэ гэхээр суманд үлдэх мөнгийг үлдээх, үгүйг аймаг хариуцаж явдаг.

2022 оноос бид суманд цалингийн орлого буюу хувь хүний орлогын албан татварыг бүхэлд нь үлдээдэг болсон байгаа. Мөн газрын төлбөр, үл хөдлөх хөрөнгийн төлбөрийг үлдээсэн байгаа. Хэр их орлого олно тэр хэмжээгээр зарцуулалт нь гарах боломжтой гэсэн үг.

Хатанбулаг сумын хувьд хүн ам болон бизнесийн идэвхжил энэ бүгдээсээ шалтгаалаад олж байгаа орлого нь хязгаарлагдаж байгаа болов уу гэж бодож байна.

Г.Тэмүүлэн: Н.Наранбаатар гишүүн нэмж тодруулъя.

Н.Наранбаатар: Тэгээд юу гэж хэлэх гээд байна вэ гэхээр зэрэг энэ улсын төсөвт том хувь нэмэр болж байгаа сумууд, аймгуудаа эргээд төсөв, хөрөнгө оруулалт юмыг нь тавьж өгөхгүй бол наадах чинь уул уурхайгаас ганц орлого олж байгаа энэ уул уурхайг чинь дэмжих газар байхгүй болж байна шүү.

Тэр Хатанбулаг, Мандах, Хөвсгөл сумын заагаар 6 нүүрсний уурхай өдөр шөнөгүй 24 цаг үйл ажиллагаа явуулж, тэр газар нутгийг нь талхалж, шороон замаар хааш хаа хамаагүй хэрж давхиж байна шүү дээ.

Тэгээд суманд нь хэдэн төгрөг хуваарилаад төсөвт нь ороод ирэхээр зэрэг тэгээд хуу хамаад авах юм. Тэгээд иргэд нь бөөн эсэргүүцэл, бөөн уур, бухимдал. Өөрсдөд нь наалдаж байгаа юм юу ч байхгүй. Сум нь 100 жилийн өмнө яаж байгуулагдаж байсан яг хэвээрээ өнөөдөр байхаар чинь дараагийн энэ төслүүдийг чинь, энэ уул уурхайг чинь хаана дэмжих юм бэ? Эхнээс нь харж байгаа биз дээ.

Халзанбүргэдэйг ашиглуулахгүй гээд ингээд л эхэлж байна шүү дээ. Тэр чинь тэр Хатанбулаг, Цогтцэций сумыг хараад л тэр иргэд чинь тэгж хэлж байгаа шүү дээ.

Өнөөдөр энэ уул уурхай чинь тэр байгаа, тэнд амьдарч байгаа ард түмэндээ, тэнд байгаа баг, сумд нь үр өгөөжөө өгдөг, асуудлаа шийддэг таван цаастай үлддэг болбол хэн хэнийг эсэргүүцэх юм бэ? Юу ч байхгүй байгаа нөхцөлд л үүнийг чинь эсэргүүцээд байна шүү дээ.

Бид чухал ашигт малтмалаа, газрын ховроо цаашаагаа ашиглая л гээд энд сайхан яриад л байдаг. Тэгээд орон нутагт чинь байдал ийм байгаа шүү дээ.

Ер нь хөрөнгө оруулалтыг аймагт нь тодорхой, танайх ийм хэмжээнд хөрөнгө оруулалтаа хий гээд өгвөл яадаг юм. Сангийн яамны хэдэн мэргэжилтэн, Сангийн яамныхан л тэр Хатанбулаг суманд цэцэрлэг барина, барихгүй гээд л яриад сууж байж ер нь болж байгаа юм уу? Тэр чинь тэндээс сонгогдсон иргэдийн Хурлын гишүүд, нутгийн өөрөө удирдах байгууллага нь хэлэлцээд яриад эндээс мөнгө төсвийг нь үлдээх юм бол хийх ажлуудаа хамгийн сайн та биднээс илүү мэдэж байгаа шүү дээ. Төсвийн хөрөнгө оруулалтын энэ тогтолцоо чинь... /минут дуусав/

Г.Тэмүүлэн: Санал хэллээ. Ө.Шижир гишүүн асуулт асууя.

Ө.Шижир: Өдрийн мэнд. Шадар сайдаас, Онцгой байдлын ерөнхий газраас асуулт байна.

2016-2025 оны хооронд Гамшгаас хамгаалах онцгой байдлын газарт 25 төсөл дээр 70.5 тэрбум төгрөгийн л хөрөнгө оруулалт хийсэн юм билээ.

Улаанбаатар хотод 50 тэрбумын гал унтраах аврах баг барьсан. Бусад нь 11 аймагт 20 тэрбум төгрөгөөр.

Гэтэл энэ хугацаанд:

- 220 ширхэг соёлын төвийг 695.0 тэрбум төгрөгөөр,
- төрийн үйлчилгээний барилга, байгууламж 216 ширхэг төслийг 765.0 тэрбум төгрөгөөр.

→ Ингээд нийтдээ 400 орчим төслийг 1.5 их наяд төгрөгийг санхүүжүүлсэн байгаа юм.

Гэтэл Онцгой байдлын ерөнхий газарт 10 жилийн хугацаанд 70.5-хан тэрбум төгрөг.

Хамгийн их хээрийн гал түймэр гардаг Сүхбаатар, Дорнод аймагт 10 жилийн хугацаанд 2025 он хүртэл нэг ч төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдээгүй.

Хэнтий аймагт л 868.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн. Энэ 3 аймгийг бүсчилж үзэх юм бол.

Саяхандаа, 5 сард Сэлэнгэ аймагт гал түймэр гараад Дархан, Орхон, Булган гээд ойр хавийнхаа аймгуудаас нь аврагч нар нь дуудагдаад, хүч хүн хүрэхгүй фургон машинаар хоног алдаад очиж байхад сайд нар нь нисдэг тэргийг нь унаж яваад Булганд байж байсан тохиолдол ч гарсан. Бүсийн уулзалт хийсэн гээд.

Уг нь энэ нисдэг тэрэг чинь Францаас онцгой байдлын албандаа хэрэглээрэй гээд өгсөн юм байна лээ шүү дээ. Сайд нар нисэж байхын оронд фургоноор явж байгаа аврагч нараа нисдэг тэргээрээ зөөх боломж байсан. Энэ бол сэтгэл дутсан ажил.

Ингээд нэг хэдэн асуулт байгаа юм.

Ер нь яг эрэн хайхад зориулсан. Хүн төөрлөө гэхэд. Сая бага насны хүүхэд төөрлөө. Одоо ч нэг эмэгтэй төөрсөн байна. Эрэн хайхад зориулсан ер нь дулаан мэдэрдэг дуран, дрон Онцгой байдлын ерөнхий газарт хэчнээн ширхэг байгаа вэ? Хамгийн сүүлд хэдийг авсан, хөрөнгө оруулалт хийсэн. Шинээр авах төсөв байгаа юу?

Монгол Улсын Ерөнхийлөгч 1 тэрбум мод гээд сайхан санаачилга гаргадаг. Эргээд одоо байгаа ойн сан нь гал түймэрт өртдөг, хортон шавжид идэгддэг. Ингээд нийт ой савын чинь хэдэн хувь нь идэгдээд байгаа юм.

Гэтэл агаараас гал унтраах, агаараас хор цацах дрон, нисдэг тэрэг бид нарт байгаа юу? Авах уу? Хэрвээ байгаа бол энэ нийт хүчин чадлынхаа хэдэн хувийг хангаж байгаа юм гэдэг нэг ийм товчхон асуулт байна.

Г.Тэмүүлэн: Асуултад хариулъя. 2 номер. Я.Гантөмөр дарга.

Я.Гантөмөр: Хурандаа Я.Гантөмөр илтгэж байна. Онцгой байдлын ерөнхий газар. Ө.Шижир гишүүний асуултад хариулъя.

Сая ой хээрийн түймэр гараад хүндрэлтэй нөхцөл байдал үүссэн. Үүнтэй холбоотойгоор Засгийн газрын 2 удаагийн тогтоолоор тоног төхөөрөмжийн хангалтын нэмэгдэл хөрөнгө 11.0 тэрбум төгрөгийг шийдэж өгсөн. Засгийн газрын нөөц сангаас.

Энэ жилийн хөрөнгө оруулалтаар бид дулаан мэдэрдэг эрэн хайх аврах ажиллагаанд ашиглах өндөр хүчин чадалтай, нарийвчлал өндөртэй зураглал хийх боломжтой 38 ширхэг дроныг худалдан авч байгаа.

Одоо яг бэлэн байгаа дрон нь 8 дрон ашиглалтад байна. Нэмээд 38 ширхгийг энэ жилийн хөрөнгө оруулалт болоод Засгийн газрын нөөц сангаас шийдэж өгсөн хөрөнгөөр худалдаж авч байгаа. Ингээд ашиглалтад оруулна.

Энэ ой хээрийн түймрийн дрон болоод нисдэг тэрэгтэй холбоотой асуултыг Та асуулаа. Францын Засгийн газартай хэрэгжиж байгаа төслийн хүрээнд үргэлжлүүлэх саналыг хүргүүлсэн байгаа. Энэ хүрээнд ой хээрийн түймэртэй тэмцэх нисдэг тэргийг нэмэлтээр авах саналыг хүргүүлээд ажиллаж байгаа.

Дроны хувьд ой хээрийн түймэртэй тэмцэх дрон нь төдийлөн практик ач холбогдол багатай гэж Онцгой байдлын ерөнхий газрын зүгээс үздэг. Яагаад гэвэл нисэх хугацаа маш богинотой, цэнэглэх хугацаа нэлээн шаарддаг. Ер нь дэлхийн түвшинд туршилтын шатандаа яваа ийм зүйл байгаа юм. Илтгэж дууслаа.

Г.Тэмүүлэн: Ойд хор цацдаг нисдэг тэрэгтэй холбоотой асуудлаар хэн тайлбар өгөх вэ? 2 номер өгөх үү.

Я.Гантөмөр: Ойд хор цацах асуудал ойн ардчилалд хамгаалалттай асуудлыг Байгаль орчны яам хариулт өгөх болов уу гэж би хувьдаа бодож байна. Бид ой хээрийн түймэртэйгээ тэмцэх асуудлаар ажилладаг байгууллага байгаа.

Г.Тэмүүлэн: Ө.Шижир гишүүнийг нэмж тодруулъя.

Ө.Шижир: Тийм. Тэгэхээр сая таны С.Эрдэнэболд гишүүний асуусан хариултад манай хангамж 57.0 хувьтай байгаа гэж байна шүү дээ.

Тэгээд юу гэх юм дээ, нэг талаасаа ичмээр л юм даа.

▷ Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламжаар асуудлаа шийднэ гээд сууж байдаг.

▷ Францын Засгийн газартай хэлэлцээрээ үргэлжлүүлнэ гээд сууж байдаг.

Тэгээд бид мөнгөгүй биш мөнгөтэй улс байгаад байдаг.

2015-2025 оны хооронд ашиглалтад орсон болон ашиглалтад орох гэж байгаа 1600 дээр нэмэх нь 530, 2100 төсөл чинь анхны төсөвт өртгөөсөө 2.4 их наядаар нэмэгдсэн байна лээ шүү дээ.

Тэгэхээр бид мөнгөгүй биш мөнгөтэй улс байгаа байхгүй юу. Тэгээд юм ярихаар мөнгөгүйн зовлон яриад л байдаг. Орлогогүй биш орлоготой айл байгаа байхгүй юу.

Тэгээд анхан шатны хэрэгцээг хайж чаддаггүй. Одоо ингээд сая техник технологи өндөр хөгжсөн энэ үед авран хайх ажил чинь олон улсад аягүй хурдан болсон юм байна лээ шүү дээ.

Тэгээд бид уламжлалт аргаараа яваад байдаг. Онцгой байдлын ерөнхий газраа бүр хойш нь хаясан. Зөвхөн боловсролын салбар, эрүүл мэндийн салбарыг ярихгүйгээр төрийн үйлчилгээний барилга, байгууламжийг ярихад л бид нэг цэгийн үйлчилгээ нь чухал юм уу, онцгой байдлын аварга хаях чухал нь юм уу гэдгээ л бид эрэмбэлж чадахгүй болсон юм байна лээ шүү дээ.

Сүүлийн 10 жил. Сүүлийн 5 жилд 135 тэрбум төгрөг үрчхээд Онцгой байдал дээр 70-хан тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байгаа байхгүй юу.

Тэрний 50 нь Улаанбаатарт. Ингээд буруу эрэмбэлж байна. Онцгой байдлын албаны буруу биш л дээ. Ер нь Засгийн газрын буруу шүү дээ. Сангийн яамны буруу шүү дээ. Эрэмбэ нь дандаа буруу.

Тэгээд буцалтгүй зээлээр авна гээд, Францын Засгийн газрын тусламжаар авна гээд ингээд сууж байдаг ичмээр л юм даа. Одоо яамаар ч юм.

Г.Тэмүүлэн: Сангийн сайд хариулъя. 7 номер.

Б.Жавхлан: Ө.Шижир гишүүний асуултад хариулъя.

Ө.Шижир гишүүн ээ, буцалтгүй зээл гэж юм байхгүй. Буцалтгүй зээл гэж байдаггүй юм. Буцалтгүй тусламж гэж байдаг юм. Буцалтгүй тусламж биш. Наад цаасаа сайн унш. Наадах дээр чинь зээл гэж байгаа. Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээл. Материалаа наадхаа унш за юу.

Г.Тэмүүлэн: Ц.Мөнхбат гишүүн асуулт асууя.

Ц.Мөнхбат: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе.

Би гадаад харилцааны сайдаас нэг асуулт байгаа. Түрүүний С.Эрдэнэболд гишүүний асуусан асуулттай ойролцоо. Гадаад харилцааны сайдын багц дээр Дипломат төлөөлөгчийн газарт гээд 183.0 тэрбум төгрөг байдаг юм байна. Энэ дотроос бид өнгөрсөн хавар Узбекистан Улсад айлчлал хийгээд явж байхад Узбекистан улсад манай Элчин сайдын яам шинээр байгуулагдаад тэгээд нэг байр, Элчин сайдын яамны барилга авах гээд мөнгийг нь тусгуулах гээд яваад байгаа гэсэн. Тэгээд энэ туссан уу? Үүнийг нэгдүгээрт асуугаад дараа нь тодруулъя.

Хоёрдугаарт, Америкийн Нэгдсэн Улсын Нью-Йорк хотод Нэгдсэн Үндэстний Байгууллагын төлөөлөгчийн газар гэж байдаг. Тийм ээ? Энэ дотор цэргийн атташе гэдэг үү, юу гэдэг вэ? Нэг орон тоо байгаа. Нөгөө манай ганц эмэгтэй генерал Г.Болор генералын ажилладаг.

Энэ хүн удаа дараа төлөөлөгчийн газар дээр цэргийн орон тоог 2 болгомоор байна гэдэг саналыг очсон албан тушаалтан болгонд л хүргүүлдэг юм гэсэн.

Ирэх оны төсөв дээр энэ суусан уу гэдгийг нэг асуумаар байна. Бусад орнууд нь 2-оос 3, 3-аас 4 орон тоотой ажилладаг юм гэсэн зүйл хэлж байсан. Үүнийг Батлан хамгаалахын сайд хариулах уу, Гадаад харилцааны сайд хариулах уу? Нэг ийм асуулт байгаа юм.

Батлан хамгаалахын сайдаас нэг ийм асуулт байгаа юм. Энэ хөрөнгө оруулалт дээр тусгай зориулалтын барилга, байгууламж, дэд бүтэц гээд л баруун бүс, төвийн бүс. Төвийн бүсэд Зэвсэгт хүчний анги, тусгай сургалт бэлтгэлийн төв гээд л байна. Төвийн бүс дээр нэлээн их байна. Хөрөнгө оруулалтууд нь.

Говийн бүсийн хөрөнгө оруулалт гэж байна уу? Батлан хамгаалахын яаманд. Ялангуяа Дундговь аймагт миний мэдэхийн сүүлийн бараг 5, 6 жил байх. Ажлын хэсгүүд гараад л баахан хурандаа нар очоод говийн бүсийн сургалтын төв байгуулна. Нэг цэргийн анги, нэгтгэл байгуулна гээд л үзээд л яваад байдаг юм. Дундговь аймгийн төвөөс жоохон зайтай. Орос цэргийн ангийн хуучин суурин дээр.

Энэ ер нь ажил болох эд үү, болохгүй эд үү? Их л олон ажлын хэсэг жил болгон л очоод байдаг юм даа. 2, 3 жил. Бодвол тэдгээр хүмүүс улсын төсвөөр л өөрсдийн зардлаа гаргалгүй л явдаг байх гэж бодож байна. Үүнийг асууя.

Гуравдугаарт, Онцгой байдлын ерөнхий газрын хөрөнгө оруулалтууд улсын төсвөөс 360, 370-аад тэрбум юм байна. Гаднын... /минут дуусав/

Г.Тэмүүлэн: Эхний хоёр асуулт дээр нь хариултаа авч байх уу? Тэгээд дараа залгаад явъя.

Ц.Мөнхбат гишүүний асуултад хариулъя. Эхний 2 асуулт дээр нь хэн хариулах вэ? Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг.

Б.Батцэцэг: Ц.Мөнхбат гишүүний асуултад хариулъя.

Узбекстанд бид байр авах гээд судлаад, одоо нэг байр түрээсэлж байгаа. Тэрийгээ авах гэхээр сая батлагдаж чадаагүй. Саналаа хүргүүлсэн. Тэгээд ирэх жил авахаар төлөвлөж байгаа.

Хоёрдугаар асуултад Батлан хамгаалахын атташе ер нь 1 хүний орон тоотой байдаг. Тэгээд манай Нью-Йоркт байгаа байр амьдрах болон оффисын байрны багтаамж их муутай байгаа.

Хоёрдугаарт нь, туслах ажилтан авах цэргийн атташед төсөв нь байхгүй. Батлан хамгаалах яамтай ярьж байгаад ирэх жилээс бид энэ асуудлыг ярьж гэсэн төлөвлөгөөтэй байгаа. Батлан хамгаалах яаман дээр хилийн чанадад суух дипломат төлөөлөгчийн газруудад тодорхой хэмжээгээр орон тоо нэмэгдүүлэх санал яригдаж байгаа.

Тэгэхээр энэ хүрээндээ шийдвэрлэх. Мөн төрийн тэргүүнээс энэ асуудлыг анхаарч орон тоог нь 2 болго гэдэг үүрэг өгөгдсөн байгаа.

Тэгэхээр яг өнөөдөр бидний төсөв дээр суугаагүй. Тэгэхээр үүнийг Батлан хамгаалах яамтай ярьж байгаад ирэх жилээс шийдэгдэнэ. Тэгээд дипломат албаны томилгоо жил болгоны хавар хийгддэг.

Тэгэхээр одоо энэ жилийн томилгоо хийгдээд хүмүүс нь явсан, байршсан байгаа. Тэгэхээр энэ ирэх жил яригдах асуудал болно.

Г.Тэмүүлэн: С.Ганбямба дарга. 1 номер.

С.Ганбямба: Ц.Мөнхбат гишүүний асуултад хариулъя.

Бид бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулаад бүсийн цэргийн сургалтын төвийн асуудлыг хөндөж байгаа. Тэгээд тухайн аймаг орон нутгаас газар орных нь зөвшөөрлүүдийг авсан. Энэ дээр аймаг, орон нутаг дэмжиж байгаа.

Тэгээд бүтээн байгуулалтын хувьд төсөвтэй л холбоотой. Мөнгө шийдэхгүй байгаа учраас л бид үүнийг хэрэгжүүлж чадахгүй байгаа юм.

Түрүүн би дурдсан Зэвсэгт хүчин өөрөө том айл. Хийх ажил их байгаа

Тийм учраас эрэмбэлэхээр тэр бүсийн сургалтын төвүүдийн асуудлууд хойшлоод байгаа учраас л шийдэгдэхгүй байгаа шүү. Тэгээд хэрвээ төсөв хөрөнгө шийдэгдээд, хөрөнгө оруулалтын төсөв нэмэгдээд явах юм энэ их чухал ажил байгаа юм. Ялангуяа дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн, орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн бэлтгэл жигдрэлтийг хангахад чиглэсэн сургалтын төвүүд бүсчилсэн хэлбэрээр байгуулагдах юм.

Тэгээд ер нь энэ хаягдаагүй. Цаашдаа хэрэгжих байх гэсэн бодолтой байна.

Г.Тэмүүлэн: Ц.Мөнхбат гишүүн нэмж тодруулъя.

Ц.Мөнхбат: Тэр Нью-Йоркийн төлөөлөгчийн газар дээр тэр ганц генералаа бүх юманд гүйлгээд баймааргүй юм билээ. Ганц эмэгтэй генералаа. Манай Батлан хамгаалах яамныхан тэр нэг орон тоог нь нэмэх асуудал дээр анхаараад шийдээд өгөөр юм байна лээ шүү.

Бид газар дээр нь очоод уулзаж, танилцаад байж байхад бусад орныхонтой харьцуулсан тийм зүйлүүдийг ярьж байсан. Өчнөөн тийм асуудал байдаг юм билээ.

Түүн дээр мэдээж анхаарч ажиллах юм байна гээд ойлголоо. Онцгой байдлын газраас нийтдээ гаднын зээл, тусламж улсын төсвийн хөрөнгө оруулалт гээд үндсэндээ 700 гаруй тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт энэ салбарт хийгдэх нь.

Гаднын зээл, тусламжаар баахан тоног төхөөрөмж авах юм байна лээ гэж ойлгоод байгаа. Энэ дээр ялангуяа бүсүүд дээр, аймаг дотор чинь дахиад сумдын дундах бүс гээд байгаа. Тэр бүсүүд дээр анги, нэгтгэлүүд барих, нөгөө анги, салбарууд барих нэг ийм ажлууд. Энэ ер нь хэр хийгдэж байгаа вэ? Ирэх 2026 оны төсөв дээр суусан уу? Би бүсийнхээ аймгуудаас л ярих гээд л байна л даа.

Түрүүч Н.Наранбаатар гишүүн хэллээ. Гол орлогын эх үүсвэрийг бүрдүүлж байгаа аймгуудын хөрөнгө оруулалтууд үнэхээрийн чамлалттай, учир дутагдалтай байна. Олон хүний өргөдөл, гомдол, санал хүсэлтүүд ирдэг. Үүнийг нь хэлэхээр тэгээд нэг аргацаагаад өнгөрдөг.

Манай Сангийн яамныхан их аргалаад сурчхаад байгаа шүү дээ. Хариу тайлбар дээрээ. Тухайн үеийг нэг аргалаад л өнгөрөөдөг. Энэ байдал чинь үргэлжлээд явах уу? Энэ дээр ямар хөрөнгө оруулалтууд хийгдэх вэ гэдэг ийм зүйлийг онцгой байдлын газраас асууя даа.

Г.Тэмүүлэн: 2 номер. Я.Гантөмөр дарга.

Я.Гантөмөр: Онцгой байдлын ерөнхий газар, хурандаа Я.Гантөмөр илтгэж байна. Гишүүний асуултад хариулъя.

Онцгой байдлын ерөнхий газрын урсгал зардал болоод хөрөнгө оруулалтын зардал нийтдээ 300.0 тэрбум төгрөгөөр Улсын Их Хуралд өргөн баригдсан байгаа. Үүний 38.0 тэрбум нь хөрөнгө оруулалт. Үүн дотроосоо 29.0 тэрбум нь техник, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт байгаа юм.

Ирэх жил Онцгой байдлын ерөнхий газар 2 төслийг шинээр эхлүүлнэ. Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн 2 төслийг хэрэгжүүлнэ гэсэн хүлээлттэй байгаа. Үүний нэг нь зарлан мэдээллийн нэгдсэн тогтолцоог бэхжүүлэх төсөл. Нөгөөдөх нь Монгол Улсын гамшгийн сөрөн тэсвэрлэх чадавхыг сайжруулах төсөл. Ингээд нийтдээ 523.0 тэрбум төгрөг болж байгаа. Үүн дээр Францын гал түймэртэй тэмцэх болоод эрэн хайх, аврах салбарын чадавхыг сайжруулах төсөл үргэлжилж хэрэгжинэ.

Ингээд таны ярьсан тоо тэр хавьд хүрэх байх гэсэн ийм хүлээлттэй байна. Мөн ирэх онд хэдэн анги, салбарыг шинээр байгуулах гэж байна вэ гэдэг ийм асуултыг асууж байна.

Ирэх 2026 онд нийтдээ 10 салбар нэгжийг шинээр байгуулахаар төлөвлөсөн байгаа. Засгийн газрын тогтоол, шийдвэр нь гарсан. Үүн дээр байгууллагын бэлтгэл бэлэн байдлыг хангах зардалд 14.7 тэрбум төгрөг суусан байгаа. Тэгээд энэ нь шинээр эхлэх 10 ангийн үйл ажиллагааг явуулах хангалттай төсөв биш боловч бид ямар ч байсан боломжийнхоо хэмжээнд үйл ажиллагааг нь эхлүүлнэ гэсэн төлөвлөгөөтэй байна.

Г.Тэмүүлэн: Ц.Мөнхбат гишүүн нэмж тодруулъя.

Ц.Мөнхбат: Тэр 10 анги, нэгтгэл байгуулах, анги, салбар байгуулахад чинь манай говийн бүсээс хамрагдаж байгаа сум байна уу?

Г.Тэмүүлэн: Ц.Мөнхбат гишүүний асуултад хариулъя. Я.Гантөмөр дарга. 2 номер.

Я.Гантөмөр: Говийн бүсийн 2 гал түймэртэй тэмцэх, гал түймэр унтраах, аврах нэгж байгаа юм байна. Үүнд, Дорноговь аймгийн Хатанбулаг сум буюу Ханги, Мандал боомт дээр. Нөгөөдөх нь Өмнөговь аймгийн Ханбогд суман дахь Гал түймэр унтраах аврах анги.

Г.Тэмүүлэн: Д.Ганбат гишүүн асуулт асууя.

Д.Ганбат: Улсын төсөв.

→ Батлан хамгаалах яам 790.0 тэрбум төгрөг зарцуулах юм байна.

- Шадар сайд, Онцгой байдал оруулаад 367.0 тэрбум юм байна.
- Гадаад харилцааны яам 240.0 тэрбумыг зарцуулах юм байна.

→ Энэ 2026 онд.

2021 онд гэхэд бид чинь бараг 3 дахин бага төсөвтэй байсан шүү дээ.

Тэгээд би Та бүхнээс үр дүн нэхэх гээд байгаа юм. Энэ татвар төлөгчдийн мөнгийг зарцуулаад яваад байдаг. Мэдээж бүгд л бага байна. Өшөө их байвал бид их сайн ажил хийх ёстой байсан гээд ярьдаг л даа.

Гэвч энэ өгч байгаа мөнгө төгрөгийг Та бүхэн яг үр дүнтэй зарцуулж чадаж байна уу гэдгийг яримаар байгаа юм.

Сая хэдхэн долоо хоногийн өмнө байна уу, тэр Хөвсгөл аймагт. Манай гишүүд ярьж байх шиг байна. Тэр 2 настай хүүхэд алга болоход Батлан хамгаалах яам нь, Онцгой байдал нь бүгд л очиж байх шиг байна лээ. Тэгээд Та бүхний үүрэг гүйцэтгэх чадвар нь үнэхээр хэцүү байна л гэж дүгнэж байгаа шүү дээ. Бүхэл бүтэн 2 настай хүүхдийг долоо хоног хайж хайж нас барсан байдалтай болж байгаа байхгүй юу.

Энэ чинь юу гэсэн үг вэ? Та бүхний үүрэг гүйцэтгэх чадвар, хэрэгтэй тоног төхөөрөмж нэг иймэрхүү байдал л байна уу? Үүнийгээ Та бүхэн юу гэж тайлбарлах юм бэ?

Би Гадаад харилцааны яамнаас зүгээр тодруулаад асууъя гэж бодож байгаа юм.

Манай Монгол паспортын хүчин чадал ямар байна вэ? Иргэдийн гадаад паспортын. Бид аль хавьцаа явж байна вэ? Ер нь хэчнээн оронд визгүй зорчиж чадахаар байна вэ?

Гэтэл манай хөрш тэрбум 400 сая хүнтэй Хятад Улс маань манай иргэдийн аль болохоор айлчилдаг Өмнөд Солонгост визгүй боллоо шүү дээ. Энэ талаар ямар ажил хийж байна вэ гэсэн ийм асуултыг асуумаар байгаа юм.

Энэ байтугай ядуу байхад бид Элчин сайдын яамдынхаа байрыг үнэхээр алсын бодлоготой 20, 30 жилийн өмнө авч чадаад байдаг байсан юм байна. Сая тэр Токиод хар, Нью-Йоркт хар. Би сүүлийн үед гадагшаа нэг их явахгүй байна л даа. Швейцарт энэ тэр. Үл хөдлөх хөрөнгийг авсан шиг авдаг байсан байна. Сүүлийн үед авч чадаж байна уу? Энэ дээр судалгаатай ажилладаг уу? Энэ Засгийн газар гэсэн ийм хэдэн асуултуудыг асууя.

Тэгээд иргэддээ хүрсэн ийм үр дүнтэй ажлууд байх ёстой л доо.

Г.Тэмүүлэн: Хэд хэдэн асуулт асуулаа. Д.Батлут сайд эхлээд хариулъя.

Д.Батлут: Д.Ганбат гишүүний асуултад хариулъя.

Батлан хамгаалах салбарын бие бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэх чадамж сайн байгаа. Энд эргэлзэх хэрэггүй. Харин хөрөнгө санхүүтэй холбоотой хөрөнгө оруулалтын асуудлууд үнэндээ хоцорсон. Нийт барилга, байгууламжийн 10 орчим хувь нь баригдаад 20 жил орчим болж байгаа барилга, байгууламжтай. Үлдсэн 90 хувь нь 20-иос дээш жил жилийн насжилттай.

Техник, тоног төхөөрөмжийн хувьд зэвсэглэлийн хувьд ямар байгааг Та надаар хэлүүлэлтгүй сайн мэдэж байгаа.

Тийм учраас бид хөрөнгө оруулалтын асуудал дээр л асуудал байдаг гэдгийг онцолж хэлэхийг хүсэж байна.

Хоёрдугаарт нь, Хөвсгөл аймагт болсон тэр 2 настай хүүхэд алга болсон асуудал дээр манай анги, салбараас тэнд ажиллаж байгаа бие бүрэлдэхүүнд хүнсний хангалт хийх үүргийг гүйцэтгэсэн байгаа гэдгийг хэлье. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Дараагийнх нь, Б.Батцэцэг сайд. Тэгээд Онцгойгоос нэмж хариулахгүй байгаа байх.

Б.Батцэцэг сайдын микрофоныг өгье.

Б.Батцэцэг: Д.Ганбат гишүүний асуултад хариулъя.

Өнөөдрийн байдлаар манай улсын

- ▶ бүх төрлийн паспорттой иргэд 29 улсад,
- ▶ дипломат албан паспорттой иргэд 65 улсад визгүй зорчиж байгаа.

2024 онд нийт бүх төрлийн паспорттой иргэдийг визийн шаардлагаас харилцан чөлөөлөх тухай хэлэлцээрийг Вьетнам, Мальдив, Парагвай Улстай тус тус байгуулсан.

- Катар, Доминикан, Гүрж, Армени Улстай бүх төрлийн паспорттой иргэдийг,
- Португал, Бельги, Люксембург, Нидерланд, Египет, Сербии зэрэг улстай дипломат болон албан паспорттой иргэдийг визийн шаардлагаас чөлөөлөх хэлэлцээрүүдийг тус тус байгуулаад байна.

Монгол паспортын чанар жилээс жилд нэмэгдэж байгаа. Энд тодруулаад саяынхыг хэлэх юм бол:

- 2020 онд 1,
- 2021 онд 2,
- 2022 онд 2,
- 2023 онд 1,
- 2024 онд онд 4 улстай

харилцан визээс чөлөөлөх хэлэлцээрийг байгуулсан байна.

Хоёрдугаарт, бид одоо дипломат төлөөлөгчийн газруудынхаа байрыг жилд 2-оос 3 байр. Мэдээж төлөвлөгөөтэй ажиллаж байгаа. Сүүлийн жилүүдэд дандаа хөрөнгө оруулалтын зардлууд бараг тусгагдахгүй бага зарцуулж байгаа учраас бид үл хөдлөх хөрөнгө худалдаж авч чадахгүй байгаа.

Жилд 2-оос 3 байрыг л бид засварлаж амжиж байгаа.

Одоо яг худалдаад авахаар байр 2-ыг бид төлөвлөсөн. Зайлшгүй авах шаардлагатай, авах боломжтой гэж үзэж байгаа. Зарим газар түрээс нь илүү бага зардалтай. Тэгээд ашиглалт. Цөөхөн хүнтэй дипломат төлөөлөгчийн газарт бид түрээслэх нь илүү юм байна гэсэн ийм тооцоо судалгаатай байгаа. Дэлгэрэнгүй мэдээллийг Танд жич хүргүүлж болно.

Г.Тэмүүлэн: Онцгой хариулах байсан уу? 2 номер.

Я.Гантөмөр: Хурандаа Я.Гантөмөр илтгэж байна. Д.Ганбат гишүүний асуултад хариулъя.

Сая Хөвсгөл аймгийн Тариалан суманд 2 настай хүүхэд алга болох явцад онцгой байдлын байгууллагын хойд бүсийн алба хаагчид бие бүрэлдэхүүн оролцсон байгаа.

Энэ ажиллагаанд оролцохдоо онцгой байдлын байгууллага төдийгүй зэвсэгт хүчин, хилийн цэргийн алба хаагчид оролцож өөрсдийнхөө албандаа ашигладаг эрэн хайх аврах ажиллагааны дроныг ашигласан байгаа.

Хүүхэд алга болсон газар өмнө нь эрэн хайх, аврах, самнах ажиллагаа явуулсаны дараа хүүхэд олдсон. Тэгээд энэ асуудлаар цагдаагийн байгууллага шалгаж байгаа гэж ойлгож байгаа. Илтгэж дууслаа.

Г.Тэмүүлэн: Д.Ганбат гишүүн нэмж тодруулъя.

Д.Ганбат: Та бүхэн чинь одоо тэгээд тэр 2 настай хүүхдийг хайхад өөрийнхөө бүх л байгаа тоног төхөөрөмжийг бүгдийг нь ашиглаж оролцсон юм

уу, Эсвэл тэр тоног төхөөрөмжөө ашиглахгүй байж байгаад ийм байдалд хүргэж байгаа юм уу гэж асуугаад байна л даа.

Долоо хоног хайсан байна шүү дээ. Хэрвээ үнэхээр хэрэгтэй, зөв зүйтэй тэр тоног төхөөрөмж нь байгаад, тэгээд нэг, хоёр хоногийн дотор хайгаад олсон бол ганц хоёр километр л байна шүү дээ. Тэр чинь. Амийг нь аварч болох байлаа шүү дээ.

Тэгэхээр Та нарын авч байгаа тоног төхөөрөмж ийм түвшинд байна уу, эсвэл байгаа тоног төхөөрөмжөө ашиглаагүй юм уу л гэж тодруулаад байна л даа. Би.

Тэгээд үүнээс чинь дүгнээд Та бүхний үүрэг гүйцэтгэх чадвар хангалттай хэмжээнд байхгүй байна л гэж дүгнэлт гарах гээд байна шүү дээ. Бид хараад байдаг. Нэг сүрхий л олон дарга нар байгаад байдаг. Тэгээд улсын төсөв, мөнгийг ингэж зарцуулаад байдаг. Хэрэгтэй юмаа авдаггүй. Хэрэгтэй ажлаа хийж чаддаггүй ийм болох гээд байна шүү дээ. Үүнийг л би лавлаж тодруулаад байна.

Г.Тэмүүлэн: Нэмж тодруулъя. 2 номер. Я.Гантөмөр дарга.

Я.Гантөмөр: Байгаа тоног төхөөрөмжөө ашигласан. Гишүүн ээ. Илтгэж дууслаа.

Г.Тэмүүлэн: Г.Хосбаяр гишүүн асуулт асууя.

Г.Хосбаяр: Шадар сайдын харьяа нөгөө Бүсчилсэн хөгжлийн газраас хүмүүс байгаа юм болов уу?

Бид чинь бүсчилж хөгжих тухай, бүсийн хөгжлийн тухай ярьж байгаа. Тэгээд яг одоо энэ 2026 оны төсөв дээр Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яамтайгаа ярьдаг, энэ бүсчилсэн хөгжлийнхөө бичиг баримт юмыг ярьдаг, бодлогоо ярьдаг юм байдаг юм болов уу? Энэ бүсчилсэн хөгжлийн газарт. Одоо яг ер нь ямар ажил хийгээд, ямар бичиг баримт боловсруулаад явж байна аа?

2024 оны улсын төсөвт бүсийн хөгжлийг дэмжих, бүсийн бүтээн байгуулалт ТЭЗҮ боловсруулахад 60.0 тэрбум төгрөг буюу 6 бүс дээр 10, 10 тэрбум төгрөг тавигдсан.

Энэ ажлыг ерөөсөө хийхгүй хойшлуулж явсаар байгаад сая 2025 оны 05 сарын 31-нд энэ зураг төсвийн мөнгөнүүд татагдсан гэсэн ийм мэдээллийг авсан.

Манай хангайн бүс дээр 10 тэрбум төгрөгийн зураг төсөл, ТЭЗҮ боловсруулах мөнгө тавигдсан байсан. Тэгээд тэр мөнгөөр бүсийнхээ

хэмжээний бүтээн байгуулалт, ТЭЗҮ, зураг төслийг хийлгээ гээд бүгд саналаа өгөөд явсан.

Тэгээд тэндээс хийгдсэн ажил ерөөсөө байхгүй байгаа. Тэгээд Сангийн яамнаас асуухаар Сангийн яам дундын дансанд мөнгийг нь байршуулсан. Одоо нэг гарц гаргалгаа хайж байгаа гэсэн зүйл ярьсан.

Тэгэхээр ер нь цаашдаа бид бүсийн хөгжил ярих юм уу? Бүсчилж хөгжих маань ер нь хэвээрээ юу? Энэ бүсчилсэн хөгжлийн газар ер нь яг ямар байр суурьтай, ямар ажил хийгээд байж байна аа?

Ер нь ирэх жилүүдийн ч бай, энэ жилийн ч бай төсөв дээр бас энэ бүсчилсэн хөгжлийнхөө бодлогыг ярьж байгаа, оруулж байгаа ийм зүйл байна уу?

Бид ер нь цаашдаа бүсчилсэн хөгжил ярих юм уу? Гол нь хөрөнгө оруулалт юман дээр л бэлтгэл ажлаа хангаж, ирээдүйд магадгүй гэнэт эдийн засаг сайхан болоод ч юм уу, нэг нар гарсан өдөр улсын эдийн засаг, төсөв сайжирвал бас энэ том бүтээн байгуулалт юм хийх гэдэг. Зураг төсөл байхгүй гээд суух юм биш биз дээ?

Тэгэхээр ер нь Бүсчилсэн хөгжлийн газар жоохон ажилламаар байна. Тэр 2024 оны төсөв дээр байгаа 10.0 тэрбум төгрөгийн зарцуулалт хэр үр дүнтэй байгаа юм, хэдэн хувийн биелэлттэй байгаа юм? Энэ дээр тодорхой хариулт авмаар байна. Сангийн яам нэмэлтээр мэдээлэл өгвөл сайн байна.

Мөн Стандарт, хэмжил зүйн газраас хүн байгаа байх. Одоо бид чинь нөгөө стандарт, техникийн зохицуулалтын шинэ хууль өргөн барьсан байгаа. Энэ хууль хэрэг батлагдаж хэрэгжсэнээр төрийн захиргааны байгууллагын төсөв, санхүү өсөх, төсөв нэмэгдэх зохицуулалтууд байгаа юу? Ер нь нэг шинэ хууль гарахаар л дагаад л энэ төсөв хөрөнгө нэмэгддэг. Энэ дээр Стандарт, хэмжил зүйн газрынхан нэг байр суурь хэлээрэй.

Г.Тэмүүлэн: Асуултад хариулъя. 2 номер.

Б.Батбямба: Б.Батбямба Шадар сайдын ахлах зөвлөх.

Өнөөдрийн хуралдаанд Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн, Стандарт, хэмжил зүйн газрын удирдлагуудыг оролцох шаардлагагүй гээд Байнгын хорооноос хэлсэн учраас миний бие төлөөлөөс сууж байна.

Гишүүний асуултад товчхон хариулъя.

Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэнгийн зүгээс энэ 6 бүс, нийслэлийнхээ бүсийн зөвлөлийн хуралдааныг зохион байгуулах бэлтгэх ажлыг аль алинд нь бүрэн хангасан байгаа.

3 бүсийнхээ зөвлөлийн хурлыг хийсэн.

3 бүс дээрээ Засгийн газрын өргөтгөсөн хуралдаанаа хийж, бүсийн өмнө тулгамдаад байгаа нэн хэрэгжүүлэх шаардлагатай төсөл, хөтөлбөрүүдийн жагсаалтуудыг холбогдох төлөөллүүдийн хүрээнд боловсруулж, санал авч, үе шаттайгаар төсөл, хөтөлбөрүүдээ эрэмбэлээд гаргасан байгаа.

Үүний дагуу Засгийн газрын холбогдох гол шийдвэрүүд гарсан.

Яг Засгийн газрын шийдвэрт туссан асуудлууд ямар нэгэн хэмжээгээр улсын төсөвт бүрэн суусан байгаа. 3 шийдвэр гарсан бүсийн тухайд.

Зураг, төсвийн тухайд хүндрэл үүссэн. Ямар хүндрэл үүссэн бэ гэхээр 60.0 тэрбум төгрөгийн хүрээнд нийтдээ 90 гаруй зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл боловсруулахаар зарласан.

Ер нь энэ томоохон хэмжээний зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажил доор хаяж 6 сараас дээш хугацаагаар хийгдэж явдаг ажил юм билээ. Тендер зарласан. Зарласан юманд нь компаниуд шалгарч чаддаггүй. Хугацаандаа материалаа өгч чаддаггүйгээс болж хүндрэл үүсээд сая энэ 06 сарын 31-нээс өмнө гэрээ хийгдээгүй гэдэг хуулийн заалтынхаа хүрээнд аль аль нь хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд түр хойшилсон байдалтай байж байгаа.

Энэ жилийн тухайд Эдийн засаг, хөгжлийн яаман дээр төвлөрөөд зохион байгуулахаар Сангийн яамтайгаа зөвшилцсөний хүрээнд 40 орчим тэрбум төгрөгийг дахиад. Өөрөөр хэлбэл тэр хөрөнгийн үлдэгдэлтэй тэнцэх хэмжээний хөрөнгийг төсвийн төсөлд суулгасан явж байгаа.

Өөрөөр хэлбэл 60.0 тэрбум төгрөгөөс 23.0 тэрбум төгрөгийн гэрээ хийгдээд. 23 байх аа. Би бас зарим нэг тоог нь жоохон буруу хэлж байж магадгүй. Уучлаарай. Ингээд хийгдээд явж байгаа.

Үлдсэн 3 бүс дээрээ бид бас яг саяын хэмжээнд төсөл, хөтөлбөрүүдээ эрэмбэлээд, шаардлагатай бүсийн зөвлөлийн хуралдаанаар энэ асуудлаа хэлэлцээд аль аль талаасаа хүлээн зөвшөөрсөн тохиолдолд Засгийн газрын холбогдох шийдвэрүүдийн дагуу асуудлаа шийдвэрлүүлэхээр ажиллаад явж байгаа.

Үүнийгээ Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, бусад “Шинэ хоршоо” хөдөлгөөн, бусад Засгийн газрын бодлоготойгоо аль болох уялдуулж явж байгаа гэдгийг хэлье.

Ер нь бүсчилсэн хөгжлийн хүрээнд Та бүхэн сайн мэдэж байгаа. 21 аймгийн төв дээр 330 сумаасаа 70 сумыг сонгож хөгжлийн төв байдлаар 91 хөгжлийн төв дээр бүх гол бодлогууд, дунд хугацааны бодлогын баримт бичгүүд, хөгжлийн хөтөлбөрүүдээ чиглүүлж ажиллаж байгаа гэдгийг хэлье. Товчхон байдлаар. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Сангийн яам. Ж.Дэлгэржаргал. 6 номер.

Ж.Дэлгэржаргал: Г.Хосбаяр гишүүний асуултад хариулъя. Сангийн яам. Ж.Дэлгэржаргал.

2024 оны төсвийн тодотголоор яг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх, бүсчилсэн хөгжлийн томоохон төслүүдийг хэрэгжүүлэхтэй холбоотой ТЭЗҮ, зураг төсөв гээд 60.0 тэрбум төгрөгийг С.Амарсайхан Шадар сайдын багцад батлагдсан.

Оны төгсгөлд бид худалдан авах ажиллагааны процессууд явж байсан учраас Засгийн газрын тогтоол гаргаад барьцаа хөрөнгийн дансанд бүхэл дүнгээр нь байршуулсан.

Ингээд худалдан авах ажиллагааны процесс маань яваад Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 05 сарын 31-ний дотор гэрээ хийсэн байх гэдэг заалт энэ оны 01 сарын 01-нээс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан 60.0 тэрбумаас 47.5 тэрбум нь гэрээ хийж чадаагүй. Одоогоор 12.5 тэрбумын ТЭЗҮ, зураг төсвийн ажил дээр гэрээ хийсэн. Үүний гүйцэтгэлүүд нь гараад явж байгаа.

Г.Тэмүүлэн: Г.Хосбаяр гишүүн нэмж тодруулъя.

Г.Хосбаяр: Энэ Бүсчилсэн хөгжлийн газар л ажлаа хиймээр юм байна л даа.

Тэгээд одоо 60.0 тэрбум төгрөгийн төсөв аль 2024 онд тавьж өгөөд байхад 12-хон тэрбум төгрөгийг нь ашиглаад.

Сая зөвлөхийн хэлж байгаа тэр ТЭЗҮ хийхэд 6 сар гээд танд буруу мэдээлэл байна л даа. Энэ бүсчилсэн хөгжил дээр чинь тэгж аймаар том төсөв, айхтар ТЭЗҮ хийгээд байх юмнууд байхгүй шүү дээ.

Энэ чинь сумдыг, аймгийн төвүүдийг бас нэг бүсийн хэмжээний шугам сүлжээтэй болгох, тээвэр ложистикийн төв байгуулах энэ тэр гээд дандаа л тодорхой олон жил ярьсан ажлууд байгаа шүү дээ. Энд бид ямар нэгэн цоо

шинэ юм гаргаж ирээд л 6 сар ТЭЗҮ-г нь хийх, зургийг нь хэдэн жил хийх ийм юм ерөөсөө байхгүй.

Тэгэхээр Та энэ доод талынхаа хүмүүст хэлээд тэр Бүсчилсэн хөгжлийн газрынхныг ажлыг нь хийлгэмээр байна. Тэгээд Сангийн яам сая мөнгө нь байгаа гэж хэлж байх шиг байна. Тэгээд одоо цаашдаа үнэхээр бүсчилж хөгжих гэж байгаа бол энэ зураг төслөө хийж ажлаа хийцгээмээр байна хүмүүс.

Тэгэхгүй бол одоо эдийн засаг сайжраад арай нэг мөнгөтэй болоод юм хийх гэдэг, бүсийн хөгжлийнхөө юмыг хийх гэдэг. Дахиад л зураг, төсөв байхгүй гээд л сууцгааж байх болоод байгаа байхгүй юу.

Тийм учраас энэ дунд шатанд байгаа тэр ажил хариуцаж байгаа хүмүүсийг ажлаа хиймээр байна гэж шаардаж байна. Зарим дарга нар чинь энэ гишүүдийн үгийг ч тоодоггүй. Худлаа үнэн яриад худлаа мэдээлэл өгөөд ингээд байдаг юм байна лээ шүү.

Тэгэхээр энэ дээрээ онцгой анхаарч ажиллаарай гэж хэлье.

Г.Тэмүүлэн: Үг хэллээ. Б.Тулга гишүүн асуулт асууя.

Б.Тулга: Та бүгдийн энэ өдрийн амрыг эрье.

Онцгой байдлын ерөнхий газраас асуух гэсэн юм. Сая зарим гишүүдийн асуултад дурдагдаж байх шиг байна. Өмнөговь аймгийн Ханбогд сум, Хайрхан 5 дугаар баг, Гашуунсухайт боомт, Цагаанхадны суурьшлын бүс Монгол Улсын эдийн засгийн гол нуруундаа үүрч явж байгаа ийм газар байгаа. Маш олон тээврийн жолооч нар, уул уурхайн үйл ажиллагаа тэнд байгаа.

Тэгэхээр өнгөрсөн онд, 2024 онд шиг санаж байна. Засгийн газраар энд анги нээхээр шийдвэр гарсан.

Тэгэхээр 2026 оны төсөвт энэ анги маань байгуулагдахаар бүрэн сууж чадсан уу? Нэгдүгээрт, зураг төслийн ажил дууссан уу? Үүний дагуу ТЭЗҮ батлагдаж, барилгын төсөв суусан уу? Тэнд ажиллах баг, бие бүрэлдэхүүний цалин, орон тоо багтаж 2026 оны төсөвт суусан уу гэдгийг тодруулмаар байна.

Гашуунсухайт боомтын хувьд бүтээн байгуулалтын ажил хийгдээд дууссан байгаа. Инженерийн байгууламж, дулааны хангамж. Энэ асуудлууд шийдэгдсэн байгаа учраас Та бүгдийн ажилд дэм болох ёстой.

Мөн Гашуунсухайт боомтын ерөнхий төлөвлөлт энэ онд багтаад дуусаж байгаа.

Тэгэхээр энэ ерөнхий төлөвлөлттэй уялдуулж Та бүхэн энэ ажлуудыг төлөвлөж чадсан болов уу гэдгийг тодруулж хэлж өгөөч ээ.

Мөн Ханги боомт дээр нөхцөл байдал ялгаагүй байгаа. Ханги боомт дээр ерөнхий төлөвлөлтийн зураг гарч байгаа. Мөн энэ тээврийн үйл ажиллагаа, уул уурхайн үйл ажиллагаа идэвхтэй явагдаж байгаа ийм боомт байгаа.

Тэгэхээр энэ дээр Та бүхэн хариулт өгөөрэй гэдгийг хэлмээр байна. Н.Наранбаатар даргатай санал нэг байгаа юм. Н.Наранбаатар гишүүнтэй.

Орлого олж байгаа хэсэг дээрээ энэ олдсон цөөн, бага хэмжээний ч гэсэн хөрөнгө оруулалтаа арай илүү түлхүү тавих замаар тухайн орлого олох сувгаа өшөө тэлэх энэ тал дээр манай энэ Онцгой байдлын ерөнхий газар, бусад байгууллагууд ч гэсэн анхаарч байгаа байлгүй дээ. Эрэмбээ тодруулж байгаа байлгүй гэж бодож байна. Тэгэхээр энэ дээр цаашид анхаараад явахыг хүсэж байна.

Үүнтэй уялдуулаад Сүхбаатар аймгийн Бичигт боомт, Дорнод аймгийн Хавирга, Ховд аймгийн Булган, Баян-Өлгий аймгийн Цагааннуур боомтууд дээр тодорхой төлөвлөлтүүд явж байгаа. Энэ дотор онцгой байдлын анги нэгж байгуулах ажлууд, Та бүгдийн дараа дараа жилийн төсөвт суугаад явж байх ёстой шүү гэдгийг энэ ташрамд хэлье.

Хоёрдугаарт нь, энэ уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор гал түймрийн аюул жилээс жилд нэмэгдэж байгаа. Энд ялангуяа хамгийн их бүрддэг бүс нутаг бол ой, тал хээрийн бүсүүд байгаа.

Тийм учраас хойд бүс, төвийн бүсийн энэ ойтой аймгууд дээр 2026 оны төсөвт ямар анги, нэгтгэл нэмж хэрхэн хүч, ажиллах бололцоогоо нэмэгдүүлж байгаа вэ гэдэг дээр хариулт өгөөч ээ гэж хүсэж байна. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Асуултад хариулъя. 2 номер.

Б.Батбямба: Б.Батбямба Шадар сайдын ахлах зөвлөх.

Яг энэ хөрөнгө оруулалтын бодлогын шинжтэй юман дээр мэдээлэл байгаа учраас би таны асуултад шууд хариулъя.

Өмнөговь аймгийн Хатанбулаг сум дээр онцгой байдлын салбар нэгж 4 дүгээр зэрэглэлийн анги байгуулах шийдвэр нь гараад, холбогдох Засгийн газрын шийдвэрүүд гарсан.

Улсын төсвийн урсгал зардал дээр 2.4 тэрбум төгрөг тавьж байгаа.

Ер нь түрүүн хэлсэн сумдад байгуулагдаж байгаа 10 анги дээр алин дээр нь ч онцгой байдлын байгууллагын зүгээс орон байрны байшин сав барих хөрөнгө, санхүүгийн асуудал шийдэх боломжгүй байгаа.

Тийм учраас орон нутгаас энэ асуудлыг шийдвэрлээд,

- Дорноговь аймгийн Хатанбулаг суманд 4 дүгээр зэрэглэлийн анги 2.5 тэрбум төгрөг суусан байгаа.
- Өмнөговь аймгийн Ханбогд суманд 3 дугаар зэрэглэлийн анги байгуулахаар шийдвэр нь гарсан. Нийтдээ 5.7 тэрбум төгрөг суусан байгаа.

Ер нь онцгой байдлын байгууллага дээр нэн шаардлагатай, түрүүн ярьсан стандартын дагуу байх ёстой анги, аврах бүлгүүдээ байгуулахад, тэдгээрийг тоног төхөөрөмжөөр хангахад 1.5-аас 2 их наяд төгрөгийн төсөв шаардлагатай. /минут дуусав/

Г.Тэмүүлэн: Нэмж.

Б.Батбямба: Үүнийг ойрын 2-оос 3 жилийн дотор шийдье гэсэн бодлогын шийдвэрээ гаргаад, шийдлээ хайгаад Засгийн газар дээр Сангийн яамтайгаа зөвшилцөөд явж байгаа.

Улсын төсөв дээр 40-хөн тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт тавигдаж байна.

Азийн хөгжлийн банкны зээлийн эх үүсвэрээр 320.0 тэрбум төгрөгийн асуудлыг. Өмнө нь хэрэгжиж байгаа төслийн үлдэгдэл бас нэг бага хэмжээний хөрөнгө оруулалтын ажил нэмэгдэнэ.

Дээрээс нь Францын Засгийн газартай дахиад 100.0 сая доллар буюу бас 320.0 тэрбум төгрөг, нийтдээ 800 орчим тэрбум төгрөгийг 2026 онд шийдэж чадвал 2027 онд үлдсэн 800 тэрбумыг нь шийдье гэсэн бодлоготойгоор үйл ажиллагаагаа төлөвлөж, холбогдох яриа, хэлцлүүдийг хийж байгаа гэдгийг хэлье. Хариулж дууслаа.

Г.Тэмүүлэн: Б.Тулга сайд.

Б.Тулга: Тийм. Ерөнхий Та бүгдийн хөрөнгө оруулалт, хэрэгжүүлж байгаа төслийг мэдэж байна.

Зүгээр, би бол яг тодорхой асуулаа. Яг ямар бүрэлдэхүүнтэй, ямар ангийг. Бүтнээр нь. Би зураг асуугаад байгаа нь зураг, төсөл чинь одоо тэр албан хаагчдын байх орон байрнаас өгсүүлээд яг цогцоор нь шийдэж чадаж

байгаа юу? Тэгэхгүй бол анги барилаа гээд нэг анги барьдаг. Яг залгаад анхнаас нь цогцоор нь төлөвлөж бодоогүйгээс болоод тэнд ажиллаж амьдарч байгаа хүмүүсийн нөхцөл, ажиллаж амьдрах нөхцөл нь маш хүнд болбол үйл ажиллагаа нь жигдэрч өгөхгүй. Тэр утгаар нь би асуугаад байгаа юм.

Тэгэхээр яг тодорхой хариулаад өгөөч ээ гэдэг хүсэлт байна.

Хоёрт нь, тэр түймрийн эрсдэлтэй аймгууд дээрх онцгой байдлын анги, тэдний хүчин чадлыг нэмэгдүүлэх тал дээр 2026 оны төсөвт юу суусан бэ?

Г.Тэмүүлэн: Б.Тулга гишүүний асуултад хариулъя. 2 номер. Онцгой байдлын ерөнхий газар.

Я.Гантөмөр: Б.Тулга гишүүний асуултад хариулъя. Хурандаа Я.Гантөмөр. Онцгой байдлын ерөнхий газар.

Өмнөговь аймгийн Ханбогд суманд гал түймэр унтраах, аврах анги орон нутгийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа. Энэ жил ашиглалтад ороод, ирэх жил томилгоог нь хийгээд, техник, тоног төхөөрөмжийнх нь хангалтыг онцгой байдлын байгууллагаас зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Тэгээд энэ асуудал бид зохицуулаад болгоно л гэж үзэж байгаа.

Өнгөрсөн жил нөгөө төсвийн тодотголын. Одоо энэ жил гэх юм уу даа. Төсвийн тодотголын явцад 9 хувийн буюу 448 орон тоо манай нийт бие бүрэлдэхүүний орон тооноос хасагдсан байгаа.

Бид Сангийн яаманд саналаа хүргүүлсэн. Тэгээд тодорхой бэлтгэл, бэлэн байдлыг хангах зардлыг шийдэж өгсөн байгаа. Ингээд улсын эдийн засгийн нөхцөл байдлыг бид сайн ойлгож байгаа.

Нөгөө талаар... /минут дуусав/

Г.Тэмүүлэн: Нэмээд хариулъя. 2 номер.

Я.Гантөмөр: Дорноговь аймгийн Хатанбулаг сум буюу Ханги, Мандалын боомт дээр нөхцөл байдал арай өөр байгаа.

Орон нутгийн зүгээс боомтоос 10 километрийн зайд байх Хатанбулаг суманд сургуулийн дотуур байрыг ашиглуулахаар. Дээрээс нь засвар үйлчилгээг нь хийж өгнө гэсэн амлалттайгаар явж байгаа.

Бид бие бүрэлдэхүүнийхээ бэлтгэл, бэлэн байдлыг хангах, сургалт дадлагадаа хамруулах, техник, тоног төхөөрөмжийн хангалтыг зохион байгуулахаар ажиллаж байна.

Та бас мөн ирэх жил ямар хөрөнгө оруулалт, ямар анги, нэгтгэлүүд байгуулагдаж байгаа талаар л асуулаа.

- Сэлэнгэ аймгийн Мандал суманд 4 дүгээр зэрэглэлийн гал түймэр унтраах, аврах анги байгуулагдана.
- Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Бугант тосгонд 4 дүгээр зэрэглэлийн анги байгуулагдана.
- Хөвсгөл аймгийн Тариалан суманд эрэн хайх, аврах нэгжийн барилга, объект ирэх оны төсөвт суусан явж байна.

Илтгэж дууслаа.

Г.Тэмүүлэн: Б.Тулга гишүүн нэмж тодруулъя.

Б.Тулга: Тэгэхээр ингэж ойлгож болох уу? Өмнөговь аймгийн Ханбогд сумын Цагаанхадны аврах ангийг хөрөнгө оруулалтыг нь орон нутгаас нь шийдэж байгаа. 2026 оны улсын төсөвт суугаагүй гэж ойлгож болох уу? Нэг.

Орон нутаг шийдэхэд 2025 оны төсөв дээр зөвхөн ТЭЗҮ суусан байсан. Орон нутгийн төсвөөр гэж ТЭЗҮ-гийн зардал суусан байсан.

Тэгэхээр яг баригдах, бүтээн байгуулалт хийгдэх зардал маань суугдсан юм уу гэдгийг тодруулмаар байна.

Г.Тэмүүлэн: Нэмж хариулъя. 2 номер. Онцгой байдлын ерөнхий газар.

Я.Гантөмөр: Өмнөговь аймаг маань өөрөө санхүүгийн бололцоо өндөр чадавхтай аймаг учраас Ханбогд сум дээр баригдах гал түймэр унтраах, аврах ангийн барилгыг өөрийнхөө төсвөөс санхүүжүүлээд, одоо ашиглалтад орох шатандаа явж байна. Тийм.

Бидний зүгээс юу хийх вэ гэвэл томилгоо, техник, тоног төхөөрөмжийн хангалтыг нь хийхээр бид төлөвлөөд ажиллаж байна. Үүнийг 2026 ондоо багтаагаад зохион байгуулах боломжтой гэж үзэж байгаа юм.

Итгэж дууслаа.

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Н.Батсүмбэрэл гишүүн асуулт асууя.

Н.Батсүмбэрэл: Хоёр салбараас асуулт байна.

▷ **Нэгдүгээрт,** онцгой байдлын салбараас.

Орон нутаг, тодруулаад хэлбэл Чингэлтэй дүүрэг өөрийнхөө төсвийн хөрөнгөөс мөнгө гаргаад шинэ анги байгуулж байгаа. Үүний цаашдын үйл ажиллагааны зардал, тоног төхөөрөмж, хөрөнгө оруулалтыг төсөв дээр оруулж байгаа юу? Энэ дээр онцгой байдлын байгууллага яаж хандаж байгаа вэ? Дүүрэг хөрөнгө оруулалтаа шийдээд анги байгуулсан. Энэ асуудал дээр тодорхой дэмжлэгүүдийг яаж өгөх гэж байна?

► **Хоёрдугаарт**, Батлан хамгаалах сайдаас асууя.

Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх гээд бид яриад байгаа. Үүн дээр бидний хамгийн чухал зүйл бол боловсон хүчний асуудал. Боловсролын салбар үүний хамгийн том өнгө төрх нь. Боловсрол гэрэл гэгээтэй байх уу, итгэлтэй байх уу, боловсон хүчин бэлдэж байгаа багш нар маань цалин хангамж нь сайн байх уу гэдгээс хамаарч энэ асуудал яригдана.

Танай харьяаны Үндэсний батлан хамгаалах их сургууль гэж байгаа. Энэ Үндэсний батлан хамгаалах сургууль дээр ажиллаж байгаа багш, ажилтан, албан хаагчдын цалин бусад энгийн багш нараас зөрүүтэй байдаг гэж ийм мэдээлэл байгаа.

Тэгээд энэ багш нарынхаа цалинг нэмэгдүүлэх. Тодруулаад хэлбэл Үндэсний батлан хамгаалах их сургуулиа чадавхжуулах чиглэлээр Та бүхэн хөрөнгө мөнгө тавьж чадаж байна уу?

Нөгөө яриад байгаа үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхын чинь гол цөм хэсэг нь хүнээ бэлтгэх, боловсон хүчнээ бэлтгэх энэ боловсролын салбарын асуудал байгаа.

- Тэгээд энэ дээр Боловсролын яамтай уялддаг юм байдаг юм уу?
- Танайх дангаараа явдаг юм уу?
- Энэ дээр хөрөнгө оруулалтаа яаж тавьсан бэ?
- Хамгийн багадаа л тэр багш нарын цалингийн зөрүүг шийдэж чадаж байгаа юу?

Ингэж байж Үндэсний батлан хамгаалах сургуульд чадавхтай, чадалтай, мэргэжлийн боловсон хүчин удаан хугацаанд ажиллана. Энэ дээр яам ямар бодлого барьж байна вэ?

Г.Тэмүүлэн: Н.Батсүмбэрэл гишүүний асуултад хариулъя. Хэн хариулах вэ? Асуултад. Д.Батлут сайд. Дараа нь Онцгой байдал.

Д.Батлут: Батлан хамгаалах бодлогын бичиг баримтын гол үндсэн суурь Үндэсний сөрөн тэсвэрлэх чадамжийг нэмэгдүүлэхтэй холбоотой асуудал.

Энэ утгаараа бид бүхэн тодорхой ажлуудыг Боловсролын яам болон бусад холбогдох байгууллагатайгаа хамтарч хийхээр зохион байгуулалт хийж байна.

Бид бүхэн Үндэсний сөрөн тэсвэрлэх чадамжийг нэмэгдүүлэхтэй холбоотой олон асуудлуудыг бодлогын бичиг баримтыг боловсруулаад Засгийн газраар хэлэлцүүлэх гээд хүргүүлсэн байгаа гэдгийг тодотгож хэлье.

Ер нь Үндэсний сөрөн тэсвэрлэх чадамжийг нэмэгдүүлье гэвэл монгол хүн бүрийн толгойд үндэсний сөрөн тэсвэрлэх чадамж, “өв соёл, цэрэг, эх оронч” хүмүүжлийг төлөвшүүлэх ажил орно гэж ойлгож байгаа.

Тэр утгаараа 2023 оны 7 дугаар сард Боловсролын тухай хуульд өөрчлөлт орохдоо “өв соёл, цэрэг, эх оронч хүмүүжлийг төлөвшүүлэх, хичээл сургалт оруулах энэ зүйл, заалтыг авч хаясан. Тэгээд үүнийг бид бүхэн Боловсролын яамны дэргэдэх болон манай яамны дэргэдэх судалгаа, шинжилгээний хүрээлэнгүүдтэй хамтран ажиллаж ахин хуулийн өөрчлөлтийг хийхээр зохион байгуулалтыг хийгээд явж байгаа.

Хоёрдугаарт нь, хүний нөөцтэй холбоотой. Маш чухал. Ер нь аль ч салбар дээр. Батлан хамгаалах салбарын хүний нөөцийн асуудлыг бэлтгээд Үндэсний батлан хамгаалах сургуулийн багш, тэнд ямар чадварлаг багш байхаас шалтгаална гэж би хардаг. Тэр утгаараа бид бүхэн энэ асуудал дээр цол, цалингийн асуудлуудыг шинэ шатанд гаргаж байж сайн багш нарыг авахгүй бол яг үндсэндээ бусад хувийн болоод төрийн хэвшлийн их, дээд сургуулиудад багш нараа алдах ийм нөхцөл байдлууд үүссэн. Яг хүний нөөцийн бэлтгэл дээр маш их тулгамдаж байгаа асуудлууд бий болсон байгаа.

Энэ утгаараа ажлын хэсэг гарч ажиллаж байна. Энэ дээр манай ажлын хэсгийнхэн Үндэсний батлан хамгаалах сургуульд ирж байгаа багш, албан тушаалтнуудын цол, цалингийн зэрэглэлийг нэг шат дээш нь ахиулах энэ нөхцөлийг судалж байгаа.

Бидний тооцоолж үзсэнээр ойролцоогоор 1.5 орчим тэрбум төгрөг хэрэгтэй шаардлагатай байгаа гэсэн тооцооллыг гаргасан явж байна.

Ингэж байж бид бүхэн батлан хамгаалах салбарынхаа хүний нөөцийг чадварлаг сайн хүний нөөцөөр хангах боломжууд үүсэж байгаа. Тэгэхгүй бол одоо яг эцэст нь Үндэсний Батлан хамгаалах сургууль дээр багшлах хүнгүй, тэгээд чанартай, чадварлаг хүний нөөц бэлтгэх тал дээр хомсдол үүсэх нөхцөл байдлууд үүсэж байгаа гэдгийг хэлье. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: 2 номер. Онцгой байдлын ерөнхий газар.

Я.Гантөмөр: Н.Батсүмбэрэл гишүүний асуултад хариулъя. Хурандаа Я.Гантөмөр илтгэж байна.

Н.Батсүмбэрэл гишүүн өөрөө Чингэлтэй дүүргийн Засаг дарга байхдаа дүүргийн хөрөнгөөс гал түймэр унтраах, аврах ангийг барих шийдвэрийг гаргасан байдаг.

Тэгээд одоо энэ барилга угсралтын ажил нь дуусаад, үндсэндээ улсын комисс хүлээж авах шатдаа орсон байна.

Эрхэм гишүүнд талархлаа илэрхийлье.

Бид үйл ажиллагааг нь 11 сард эхлүүлэхээр ажиллаж байна. 40 албан хаагчийг сургаад, дадлагажуулаад, батлагдсан орон тооныхоо хүрээнд зохицуулалт хийх замаар 11 сард үйл ажиллагааг нь эхлүүлэхээр төлөвлөөд ажиллаж байна.

Тоног төхөөрөмжийн асуудлыг бид дотроо зохицуулалт хийх замаар шийдвэрлэнэ.

Одоо нэг үүсээд байгаа хүндрэл бэрхшээл нь мэдээж бүхэл бүтэн анги байгуулагдаад үйл ажиллагаа нь эхэлж байхад тавилга, эд хогшилгүй, компьютер худалдан авах асуудал Төрийн хэмнэлтийн тухай хуулиар жоохон хүндрэлтэй байгаа. Энэ асуудлыг бид гэхдээ дотооддоо зохицуулаад 11 сард бүрэн хэмжээгээр үйл ажиллагааг нь эхлүүлнэ гээд төлөвлөөд ажиллаж байна.

Илтгэж дууслаа.

Г.Тэмүүлэн: Нэмж тодруулъя. Н.Батсүмбэрэл гишүүний микрофон өгье.

Н.Батсүмбэрэл: Онцгой байдлынхандаа амжилт хүсье.

Батлан хамгаалах сайд болон Сангийн яамнаас тодруулъя.

Үндэсний батлан хамгаалах сургууль гээд чухал сургууль байдаг. Энэ сургуулийн боловсон хүчин тогтвортой ажиллахад цалингийн зэрэглэлийг дээшлүүлэх шаардлага байна. 1.5 тэрбум төгрөгийн санхүүжилт хэрэгтэй юм байна. Үүнийг Батлан хамгаалах яам дотроо зардлаа шилжүүлж шийдэх юм уу, аль эсвэл төсөв дотор өөр байдлаар зарчмын зөрүүтэй санал гаргаад явбал шийдэх бололцоо байгаа юу? Энэ дээр ямар хувилбар байж болох вэ? Үүнийг хойш нь тавьж боломгүй байгаа.

Ялангуяа олон чиглэлийн боловсон хүчин үндэсний аюулгүй байдлын чиглэлээр энгийн хүмүүсийг хүртэл сургалтад хамруулж байгаа энэ үед чухал

хөтөлбөр. Тэгээд энэ зардлыг яаж шийдэх вэ? Салбарын сайд, Сангийн сайд хоёр энэ дээр ямар байр суурьтай байна вэ?

Г.Тэмүүлэн: Д.Батлут сайд асуултад хариулъя.

Д.Батлут: Манайх урсгал зардал дээрээ зохицуулалт хийх ямар ч боломжгүй байгаа.

Үндсэндээ урсгал зардлууд ихэнх нь хасагдсан. Манай анги, салбаруудтай холбоотой, нөхөн хангалттай холбоотой асуудлууд байдаг учраас түүнтэй холбоотой зардал тодорхой хэмжээгээр нэмэгдсэн ийм л дүр төрхтэй байгаа учраас бид бүхэн дотооддоо зохицуулалт хийх боломж байхгүй байгаа гэдгийг хэлье.

Г.Тэмүүлэн: 8 номер. Сангийн яам.

М.Санжаадорж: Сангийн яам. М.Санжаадорж. Гишүүний асуултад хариулъя.

Цалинтай холбоотой асуудлыг энэ жилийн хувьд нэгэнт батлагдсан төсвийн хэмжээнд зөвхөн төсөвтөө зохицуулалт хийх байдлаар зохицуулах боломжтой.

2026 оны төсвийн төслийн хувьд Засгийн газраас төсвийн төслийг парламентад, Их Хуралд өргөн мэдүүлсэн байгаа. Одоо зөвхөн Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу гишүүдийн гаргасан саналын дагуу шийдвэрлэх боломжтой болно.

Ер нь цалингийн асуудлыг бүхэлд нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам цалингийн бодлогыг мэддэг. Бидний хувьд ямар зарчим барьдаг вэ гэхээр аль нэг салбарыг, аль нэг мэргэжлийг тусгайлан сугалж шийдэх нь өөрөө өрөөсгөл байж болзошгүй гэж үздэг.

Төрийн албаны тухай хууль дээр угаасаа заасан байдаг. Тухайн ажил, мэргэжлийн үүрч байгаа хариуцлага, хийж байгаа ажлыг заавал ажлын байрны зураг авалт дээр үндэслэж шийдэх ёстой гэдэг хуулийн заалт байдаг.

Хамгийн гол асуудал нь аль нэг салбарыг түрүүлээд бид онцгойлоод өөр байдлаар шийдэхээр энэ маань өөрөө дараачийн салбарууд нь хойноос нь өрсөлдөөн болж яваад, үүнээсээ болоод асуудал үүсдэг.

Мөн салбар болгон өөрсдийнхөө хуулиараа цалингийн асуудал, нэмэглийн асуудлаа шийдэхээр нэгдсэн цалингийн бодлого алдагдаад байдаг асуудал байдаг.

Г.Тэмүүлэн: Н.Батсүмбэрэл гишүүн нэмж тодруулъя.

Н.Батсүмбэрэл: Тэгэхээр энэ чинь Байнгын хороон дарга, зарчмын зөрүүтэй санал чинь дараа гарна. Тийм ээ. Энэ дээр шийдэх ёстой юм байгаа. Энэ багш нар тогтвортой ажиллаж байж сургуулийн, үндэсний батлан хамгаалах чиглэлийн эрдэм мэдлэг дэлгэрүүлэх ажлууд хийгдэнэ.

Тэгээд энэ ажлыг салбарын яам надад мэдээллийг нь гаргаж өгөөч ээ гэж хүсье.

Манай С.Эрдэнэболд гишүүнээс эхлээд үндэсний аюулгүй байдлын асуудал ярьдаг гишүүд байж байна. Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга ажиллаж байсан Ө.Шижир байж байна. Энэ гишүүд дэмжих байх. Энэ үндэсний аюулгүй байдлын асуудал, сөрөн тэсвэрлэх асуудал, багш болсон хүчнүүдийг дэмждэг асуудал гээд маш олон хүмүүс байгаа учраас энэ асуудлыг дэмжих хэрэгтэй.

Тэгээд энэ дээр нарийн мэдээллийг, ямар зардлыг яаж санхүүжүүлж шийдэж болох вэ гэдэг дээр Батлан хамгаалахын сайд мэдээлэл нарийсгаж өгөөч ээ гэж хэлье.

Г.Тэмүүлэн: Санал хэллээ гэж ойлголоо.

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Ингээд 26 төсвийн төслүүдтэй холбогдуулаад үг хэлэх гишүүд байна уу? Ө.Шижир гишүүнээр тасалъя. Э.Болормаа гишүүн. С.Эрдэнэболд гишүүн байна. Уучлаарай.

С.Эрдэнэболд: Одоогоос 20-иод жилийн өмнө 2004 оноос яг Иракийн ажиллагаа, байлдааны ажиллагаа, НАТО-гийн мандатын ажиллагаан дээр манайх оролцож байсан.

Ингээд ер нь хоёр арван жил буюу 20 жилийн хугацаанд манай улсын батлан хамгаалах салбар нэлээн олон улсын түвшинд туршлага судалсан, ерөнхийдөө жишээлбэл юугаар бодоход, энхийг дэмжих ажиллагаа, Африкийн орнуудаар бодоход ч гэсэн хүртэл манай залуучууд маш их чадавхажсан, шинэ үеийн цагийн технологийн мэдлэг хэрэглэх чадвартай болсон.

Тэгэхээр сүүлийн 20 жил манай батлан хамгаалах салбар хувь хүний хүний нөөцийн хувьд ч тэр, зэвсэг техникийн хувьд ч тэр нэлээн орчин үеийн болж чадсан. Олон залуучууд англи, герман, франц хэлтэй болсон. Олон мянган залуучууд энхийг дэмжих ажиллагаа болон НАТО-гийн байлдааны статустай ажиллагаанд оролцсон.

Эндээс манай батлан хамгаалах салбар шинэ үеийн дэлхийтэй хөл нийлүүлэх, зэрэгцээ явах боломжтой болсон.

Нөгөө талаасаа сүүлийн үеийн дэлхий нийтийн тогтворгүй байдал, дайн бүхий байдал, цагийн байдал үүссэн байгаа үе дэх нөхцөл байдлыг харж байхад технологи маш үсрэнгүй хөгжлөө. Ялангуяа ковидын цар тахлын үед шинжлэх ухаан 12 жилийн хурдаар багадаа хөгжлөө.

Тэгэхээр энэ орчин үеийн дайн байлдааны ажиллагаа маш технологижсон боллоо л доо.

Тэгэхээр энэ дээр цаашдаа батлан хамгаалах саяын Н.Батсүмбэрэл гишүүний яриад байгаа “үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх” гэдэг энэ асуудал маань илүү хиймэл оюун ухаан болон дэвшилтэт технологитой холбоотой зүйл болж байгаа.

Тэгэхээр цаашдаа дэвшилтэт технологи, хүний нөөц, дээрээс нь болзошгүй аюул заналд бид бэлэн байх асуудлаа Их Хурал дээр “процессын дахин инженерчлэл” гэж яриад байгаа. Үүнтэйгээ илүү уялдуулсан байдлаар сургалтын орчин, энэ гуравласан орчинг сайн хийх зайлшгүй шаардлагатай болоод байгаа.

Хоёрдугаарт нь, яг одоо энэ гамшгийн нөхцөл байдал, гал, усны аюул, цаашлаад газар хөдлөлт ч гэсэн том аюул занал хэвээрээ байгаа. Энэ үед зөвхөн батлан хамгаалах салбар ч гэдэг юм уу, цэрэг гэдэг юм уу, онцгой гэдэг юм уу онцгой байдал гэхээсээ илүүтэйгээр тэр аюулын зэрэг үүсэж болзошгүй газар нутаг байгаа хүмүүсийг чадавхжуулах, нөгөө хуучнаар иргэний батлан хамгаалах тийм үү, иргэний тэр мэдлэг чадавх, зарим тохиолдолд сүүлийн үед хүмүүс NATIONAL GUARD буюу “Үндэсний гвард” гэж яриад байгаа энэ зүйлүүдтэй хамтарч хоршиж ажиллах чадавхыг нэмэгдүүлмээр байгаа юм.

Тэгэхгүй бол тодорхой эрсдэлтэй нөхцөл байдалд иргэд өөрсдөө давхар эрсдэлийн зэргийг нэмэгдүүлэх хэмжээнд, нөгөө “зуд дээр зуд” гэдэг шиг нөхцөл байдал үүсэх гээд байгаа.

Тэгэхээр жишээлбэл сая манай манай Сэлэнгийн бүсэд байгаа хүмүүс ч гэсэн айлууд ямар ч байсан хот айл дундаа нэг гал үлээгч төхөөрөмжтэй байх ёстой юм байна гээд авч байх жишээтэй байгаа юм.

Тэгэхээр юмыг олон талаас нь зөв EFFICIENT буюу “үр ашигтай” хөгжүүлэх тал дээр нь бид нэлээн бодлого бодох ёстой юм байна гэж харагдаж байгаа.

Хоёрдугаарт, сая хэлж байна. 171 байхаас 69 байгаад байна гэж. Тэр 66 эрэн хайх STATION байх ёстойгоос 51 байгаад байна гээд. Одоогоор хангалт 57 хувьтай гэдэг чинь хангалтгүй байна л даа.

Тэгээд энэ зээл, тусламж, гаднын орны болон энэ юмнуудыг нэмээд нэмээд 80 хувьтай л байна гэж байгаа юм.

Тэгэхээр энэ бол эргээд нөгөө зөвхөн нэг салбарын асуудал гэхээсээ илүүтэйгээр энэ бол

- Үндсэн хуулийн асуудал,
- Монгол хүний амьд явах эрхтэй холбоотой асуудал,
- Эрүүл, аюулгүй орчинтой холбоотой асуудал,
- ➔ Тэрийг хангах стандартын тухай асуудал. Тэр нь төр өөрөө баталгаа гаргаж өгч байх ёстой асуудал.

Тэгэхээр дараа дараагийнхаа төсвийн хэлэлцүүлэг дээр энэ зүйлүүдээ салбарын хүмүүс яг үндэслэлтэй, зоригтой, тодорхой хэлээд яваасай гэж хүсэж байна.

Зүгээр одоо бид нарт байгаа нэг түгээмэл нэг зүй тогтлын алдаа байгаа юм. Яаж байна гэхээр аливаа асуудлыг хооронд нь төр, засаг шийдвэр гаргахдаа ч юм уу, аливаа нэг хөрөнгө оруулалтын зүйлийг ярихдаа уялдаа, харилцан хамааралтай, түүний цаана байгаа ач холбогдол, логикийг нь харж байж судалгаатай шийдэх ёстой байгаа юм.

Би Сангийн сайдыг буруутгаж чадахгүй байгаа юм.

Яагаад гэхээр нэг талаас иргэд тэдэн хувиар төсвөө танахаас одоо ингээд 9 хувь гээд төрийн албан хаагчдыг бууруулна гээд өгдөг. Түүгээр нь хөрөнгө оруулалтын зардлыг Ерөнхийлөгчийн хоригийн араас 20 хувь гээд тэгшитгээд хасдаг. Тэгэнгүүт тэнд нь дахиад л алдаанууд гараад байгаа юм.

Аливаа асуудлыг шийдвэрлэхдээ их амьдралтай, судалгаатай, үр дүн нь чиглэсэн зорилгодоо хангахуйц, эцсийн дүндээ хууль хэрэгждэг, хүний эрхийг дээдэлдэг зүйл дээр л бид хаана хаанаа анхаарч анзаарах ёстой юм болов уу гэж бодож байгаа юм. Тэгээд энэ үгийг онцолж хэлэх гэсэн юм.

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Э.Болормаа гишүүн үг хэлнэ.

Э.Болормаа: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе.

Манай Байнгын хороо үндсэндээ Гадаад харилцааны сайд, Батлан хамгаалахын сайд, тэгээд Онцгой байдлын асуудал эрхэлсэн энэ асуудлуудын төсөв нь орж ирж байгаа юм.

Тэгээд би онцлоод Гадаад харилцааны яам аягүй сайн ажиллаж байгааг онцлон дурдмаар байна. Манай эмэгтэй сайд ер нь сүүлийн жилүүдэд Монгол Улсын гадаад бодлогыг ямар түвшинд хүргэж ирж байна. Бусад бүх салбарууд үүнийг анзаарах ёстой. Ер нь заавал барилга, байшин, хөрөнгө оруулалт гэлгүйгээр ажлын үр дүн яаж гаргаж болдог юм бэ гэдэг манай гадаад харилцааны салбарт маш тод харагдаж байна.

Гадаад харилцааны салбар болон батлан хамгаалахын салбар хоёрын нэг зүйлийг би онцлон Та бүхэн хараасай гэж хүсээд байгаа юм. Танай салбаруудын хамгийн үнэт зүйлс яахын аргагүй боловсон хүчин.

Тэгэхээр барилга, байшин гэхээсээ илүүтэйгээр ямар нэгэн хөрөнгө мөнгөний нэмэгдэл, хөрөнгө оруулалт гэхээсээ илүүтэйгээр боловсон хүчнийхээ цалин хангамж гэдэг дээр анхаарах нь зүйтэй юм болов уу.

Дотоод зардлуудаа шилжүүлэх аргаар яаж илүү энэ салбарын боловсон хүчин бол Монгол Улсын аюулгүй байдлыг хангах ийм боловсон хүчиндээ сайн анхаараарай гэж хүсмээр байна.

Өнгөрсөн жил мөн Байнгын хорооны хурал дээр би хэлж байсан. Батлан хамгаалахын сайдад. Одоо шинэ сайд байна. Дахиад нэг зүйлийг хэлье.

Монгол Улсын хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд 4 дүгээр зүйлд юу гэж заасан бэ гэхээр төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглоно гэсэн байдаг.

Батлан хамгаалахын салбар өөрөө дотроо нэг сонинтой байгаа юм. Энэ өөрөө хуулийн зөрчил болоод байгаа юм.

Үнэхээр батлан хамгаалахын салбарт нэн шаардлагатай зүйл гэж үзвэл Та бүхэн хуулийн өөрчлөлтөө оруулаад, хуулийн зөрчлөө арилгамаар байгаа юм.

Сая Н.Батсүмбэрэл гишүүний хэлээд байгаа магадгүй энэ 1 тэрбум төгрөгийн зардал хаанаас гаргах вэ гэвэл энэ сонины чинь л зардал байна л даа. Тэгээд өөр газруудтай бөөн хэвлэл мэдээлэлтэй гэрээ хийх асуудал ороод ирдэг. Шаардлагатай ч юм уу, үгүй ч юм уу. Өмнөх сайд нь тэгээд бөөн хувийн PR энэ төрийн мөнгөөр хийсээр байгаад таарсан юм шиг л надад харагдсан.

Жилийн өмнө би яг Байнгын хороон дээр энэ асуудлыг хэлж байсан. Дахиад шинэ сайдад нь давтаж хэлье.

Энэ эсвэл хуулийн зөрчлөө арилга. Эсвэл хуульдаа нийцүүлээд төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхаа боль гэж хэлмээр байна.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны эдгээр зүйлдийг би зүйл, заалт бүрээр төсөв, мөнгийг нь нарийн ярих нь дэмий гэж үзэж.

Яагаад гэвэл энэ хоёр салбар харьцангуй 50 төгрөгийн зардалтай юмыг бараг 100 төгрөгийн өгөөжтэй дотроосоо салбар өөрөө өөрийн дотоод хүчээ зарцуулаад хийдэг учир ингээд зүйл, заалт бүрээр нь ярихаас илүүтэйгээр ийм зарчмын юман дээрээ Та бүхэн онцгойлон анхаараасай гэж хүсье.

Харин онцгой байдлын хувьд жоохон өөрөө. Онцгой байдлын салбар жоохон улс төржих гээд байгаа шүү.

Би хөдөө орон нутагт ажиллаж байсан аймгийн Засаг даргын хувьд хэлэхэд аймаг, орон нутагт байгаа удирдлагууд нь хэдэн хотоос ирсэн дарга нарт үйлчилж байгаа мэт л ажилладаг. Яг аймаг, орон нутгийнхаа ажил гэхээсээ илүүтэйгээр хотоос энэ дарга ирж байна, одоо ингэж амруулах ёстой, зугаалуулах ёстой байдлаар ханддаг байдлаа онцгой байдлын салбар анхаармаар байгаа шүү.

Үүнийг одоо би жилийн өмнө ч мөн адил хэлж байсан. Жилийн дараа дахиж адилхан хэлж байгаадаа ер нь харамсаж байна. Энэ байдлууд ялангуяа одоо энэ өвөлжилт хүнд болох гээд байна.

Тэгэхээр улс төрөөс аймаг, орон нутгийг тэр гишүүний, энэ гишүүний гэж ялгалгүйгээр наад өвөлжилт дээрээ илүү шинжлэх ухаанчаар, илүү улстөрч байлгүйгээр хандаж нарийн ороосой гэж хүсмээр байна.

Г.Тэмүүлэн: Э.Болормаа гишүүнд баярлалаа. Үг хэллээ. Ө.Шижир гишүүн үг хэлнэ.

Ө.Шижир: Би зарим зүйлийг давтаж хэлнэ.

2016 оноос хойш 2025 оны хооронд Онцгой байдлын ерөнхий газарт 25 төсөлд 70 тэрбум төгрөг л зарцуулсан. Хамгийн их ой түймэр гардаг Дорнод, Сүхбаатар аймагт хөрөнгө оруулалт нь “0”. Гэтэл энэ хугацаанд:

- 220 соёлын төвд 695 тэрбум төгрөг;
- төрийн үйлчилгээний барилга, байгууламж 216 төсөлд 765 төгрөг тэрбум төгрөг зарцуулсан байна.

→ Нийлээд 1.5 их наяд.

Яагаад давтаж хэлээд байна вэ гэхээр Онцгой байдлын ерөнхий газрынхан хажууд чинь сууж байгаа Сангийн сайд Та нарт ингэж хүйтэн хандаж байгаа байхгүй юу.

Тэгээд Сангийн сайд үг түүж байхаар тоо түү. Төсөвт өртөгүүд чинь яагаад нэмэгдээд. Тэр тал дээрээ тоо түү.

Сүүлийн 5 жилд таны зарцуулсан 135.0 их наяд төгрөг байгаа. 2026 оны төсвийг оруулах юм бол 165 их наяд 143 тэрбум 800 сая төгрөг.

Өнөөдөр асуудал нь шийдэгдсэн нэг салбар ч алга. Төсвийг гарын салаагаар урсгаж байна. Татвар төлөгчдийн мөнгийг хэн араас нь нэхэх юм бэ гэсэн байдалтайгаар асуудалд хандаж байна.

Таны зарцуулах гээд байгаа 165 их наяд 143 тэрбум 800 сая төгрөг чинь Монголын үе үеийн Сангийн сайд нарын нийт төсвөөс хэд дахин өндөр шүү. Би үүнийг хэлэх гэсэн юм.

Г.Тэмүүлэн: Гишүүд үг хэлж дууслаа.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд 2026 онд төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Хэлэлцүүлэг хийсэн талаарх танилцуулгаа Төсвийн байнгын хороонд хүргүүлэх байгаа.

Дараагийн асуудалдаа орцгооё. Ажлын хэсгийнхэнд баярлалаа.

**Гурав.Гадаад зээл, тусламжийн хэрэгжилт, нөхцөл байдлын талаарх
Сангийн сайдын мэдээллийг сонсох**

Гурав дахь асуудал. Мэдээлэл сонсох байгаа.

Гадаад зээл, тусламжийн хэрэгжилт нөхцөл байдлын талаарх Сангийн сайдын мэдээллийг сонсох байна.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнууд Сангийн яамныхныг түрүүн танилцуулсан байгаа.

Ингээд мэдээллийг Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Сангийн сайд Болдын Жавхлан хийнэ.

Таныг микрофонд урьж байна. 7 номер.

Б.Жавхлан: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны холбогдох хурлаас өгсөн чиглэлийн дагуу Засгийн газрын өрийн удирдлага, гадаад зээл, тусламжийн хэрэгжилт, нөхцөл байдлын талаар танилцуулж байна.

Юуны өмнө Засгийн газрын өрийн удирдлагын өнөөгийн байдлыг товч танилцуулъя.

Гишүүддээ зориулаад PPT бэлдсэн байгаа. Дэлгэцээр гарч байгаа. Тийшээгээ анхаараарай.

Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдэл 2025 оны хагас жилийн байдлаар 35.5 их наяд төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 39.5 хувьтай тэнцэж байна.

Засгийн газрын өрийн дотоодын нийт бүтээгдэхүүнд харьцуулсан харьцаа сүүлийн жилүүдэд тогтмол буурч байгаа бөгөөд Олон Улсын Валютын Сангийн өрийн тогтвортой байдлын шинжилгээгээр манай улс 2023 оны өндөр эрсдэлтэй гэж үнэлэгдэж байсан бол 2025 оны 6 дугаар сард хэвийн эрсдэлтэй гэж үнэлэгдсэн.

Засгийн газрын зүгээс авч хэрэгжүүлж байгаа өрийн удирдлагын арга хэмжээ амжилттай хэрэгжиж байгаа нь Улсын Их Хурлаас баталсан Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн баримт бичгийг чанд мөрдөн, хэрэгжилтийг ханган ажиллаж байгаатай холбоотой.

Өрийн удирдлагын тухай хууль 2015 онд батлагдсанаас хойш Улсын Их Хурлаас нийт 4 удаагийн стратегийн баримт бичгийг батлаад байгаа бөгөөд хамгийн сүүлд 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдөр Засгийн газрын Өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичгийг нийт 4 зорилт, 9 арга хэмжээтэйгээр баталсан.

Энэхүү стратегийн баримт бичгийн зорилт, шалгуур үзүүлэлтийг мөрдөж ажиллан өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлснээр дунд хугацааны Засгийн газрын өрийн дотоодын нийт бүтээгдэхүүний 40 орчим хувьд тогтворжиж, гадаад үнэт цаасны төлбөрийн дарамт буурах, өрийн багцын зардал, эрсдэлийн үзүүлэлтүүд сайжрах төсөөлөлтэй байна.

Засгийн газрын өрийн хүүгийн төлбөрийн хувьд 2025-2028 онд дунджаар жил бүр 1.3 их наяд төгрөг төлөгдөхөөр байгаа бөгөөд хүүгийн зардал 2017 онд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын 14.5 хувьтай тэнцэж байсан бол 2025 онд 4.3, 2026 онд 4.1, дунд хугацаанд 3.5 хувьтай тус тус буурахаар байна.

Ийнхүү өрийн зардал буурсан нь 2017 оноос дотоод үнэт цаас гаргахыг хязгаарлаж, арилжааны нөхцөлтэй гадаад үнэт цаасны үлдэгдлийг бууруулж, хөнгөлөлттэй гадаад зээлийн эх үүсвэрийг түлхүү ашиглаж ирсэнтэй холбоотой юм.

Тодруулбал, өндөр хүүтэй, богино хугацаатай гадаад үнэт цаасыг зөвхөн дахин санхүүжилтийн зорилгоор арилжаалж, үлдэгдлийг бууруулах бодлого баримталсны үр дүнд Засгийн газрын гадаад өрд эзлэх арилжааны нөхцөлтэй гадаад үнэт цаасны хэмжээ 2017 онд 45.7 хувь байсан бол 2024 онд 28.6 хувь болж буураад байна.

Ийнхүү Засгийн газрын өрийн дотоодын нийт бүтээгдэхүүн эзлэх хэмжээ тогтмол буурч, богино болон дунд хугацааны төлбөрийн хуваарийг жигдлэн, өрийн удирдлагын стратегийн баримт бичгийг тууштай мөрдөж байгааг олон улсын байгууллагууд онцгойлон авч үзэж байна.

Тухайлбал, олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч Fitch, S&P, Moody's байгууллагууд Монгол Улсын зээлжих зэрэглэлийг 10 жилийн дараа буюу 2024 онд “B+” тогтвортой түвшинд буцаан нэмэгдүүлсэн бол Fitch агентлагаас 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдөр Монгол Улсын зээлжих зэрэглэлийг “B+” тогтвортой түвшинд хэвээр хадгалах шийдвэр гаргаснаа зарласан.

Мөн Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас 2025 оны 6 дугаар сард Монгол Улсын зээлийн эрсдэлийн үнэлгээг 7 дугаар түвшнээс 6 дугаар түвшин болгон сайжруулсан.

Эдгээр олон улсын байгууллагууд Монгол Улсын зээлжих зэрэглэлийг сайжруулсан гол шалтгаануудын нэг нь Засгийн газрын өрийн удирдлагыг оновчтой хэрэгжүүлсэн, гадаад өрийн дарамтыг бууруулсан болохыг тайландаа цохон онцгойлон тэмдэглэсэн.

Хоёр.Засгийн газрын гадаад зээл, тусламжийн хэрэгжилт.

Монгол Улсын Засгийн газар 1991 оноос хойш нийт 348 төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор 9.1 тэрбум ам.доллартой тэнцэх хэмжээний зээлийн хөрөнгийг авч ашигласан бөгөөд үүнээс 6 тэрбум ам.доллартой тэнцэх хэмжээний хөрөнгийг төслийн зээлд буюу 308 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхэд зарцуулсан бол төсвийн дэмжлэгийн зориулалтаар нийт 3.1 тэрбум ам.долларын 40 хөтөлбөрийн зээлийн хөрөнгийг авч ашигласан байдаг.

Сүүлийн 30 гаруй жилийн авч ашигласан зээлийг бүтцээр нь харвал Монгол Улс 1991-1999 онуудад нийт 1.3 тэрбум долларын эдийн засгийн шилжилтийн үеийн хүндрэлийг даван туулах зорилготой зээл авч байв.

Харин 2000-2009 онуудад дэд бүтэц бий болгох дулааны цахилгаан станцыг шинэчлэх, автозам болон төмөр зам барих нийтийн аж ахуй болон агаарын тээврийн дэд бүтцийг бий болгох чиглэлээр нийт 1.5 тэрбум долларын зээлийг авч ашигласан байна.

Сүүлийн 15 жилийн хугацаанд Улаанбаатар хотын суурьшлын бүсийг тэлэх, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийх боломжгүй өндөр өртөг бүхий томоохон дэд бүтэц, бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр гадаад төслийн зээл авч ашигласан бөгөөд тухайлбал Япон Улсын зээлээр шинэ олон улсын нисэх онгоцны буудал барих төсөл, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын зээлээр Төв цэвэрлэх байгууламж барих төсөл, Улаанбаатар, Хөшигийн хөндий нисэх онгоцны буудлын хурдны авто зам барих төсөл, Яармагийн болон замын цагдаагийн гүүр барих төслүүд, Гацуурт, Налайхын авто замын төсөл, Азийн хөгжлийн банкны зээлээр Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр, Дэлхийн банкны зээлээр эрчим хүчний алдагдал бууруулах шинэчлэл хийсэн “Эрчим хүч-I, II” төсөл зэрэг томоохон төслүүдийг амжилттай хэрэгжүүлээд байна.

Өнөөдрийн байдлаар 2014 оноос эхлэн гэрээ хэлэлцээр нь байгуулагдсан Монгол Улсын Их Хурлаар соёрхон батлагдсан нийт 19.9 их наяд төгрөгийн амлалтын дүн бүхий гадаад зээл, тусламжийн 96 төсөл хэрэгжиж байгаа бөгөөд үүнээс 6.3 их наяд төгрөг буюу 31.6 хувийг өнгөрсөн хугацаанд ашигласан. Үлдсэн 13.6 их наяд төгрөг буюу 68.4 хувь нь ашиглагдаагүй байна.

Улсын Их Хурлаас 2025 онд нийт 1.9 их наяд төгрөгийн зээл, тусламжийн ашиглалтыг 2025 оны төсвийн тухай хуулиар баталсан.

Улсын Их Хурлаар баталсан хэлэлцээрүүдийг хэрэгжүүлэхэд гадаад зээлийн ашиглалтаа нэмэгдүүлэх асуудал хамгийн тулгамдаж байгаа асуудал болоод байна. Тухайлбал, нийт хэрэгжиж буй зөвхөн зээлийн төслүүдийг авч үзвэл 500 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй 5 төсөл байгаа бөгөөд 2025 онд батлагдсан нийт гадаад зээлийн ашиглалтын 57 хувийг төслүүд дангаараа эзэлж байна.

Төслийн зээлүүдийн амлалтын дүнгээс 70.4 хувь нь ашиглагдаагүй буюу 12.6 их наяд төгрөг ашиглахаар хүлээгдэж байгаа бөгөөд 82 хувь нь 2025-2028 онд хэрэгжиж дуусах гэрээ хэлэлцээртэй тул энэ хугацаанд гадаад зээлийн ашиглалтыг зайлшгүй нэмэгдүүлж, төслүүдийг үр дүнтэй, цаг хугацаанд нь хэрэгжүүлж дуусгах шаардлага тулгарч байна.

Хэрэв 2025 онд батлагдсан түвшнээр тооцож үзвэл эдгээр төслүүдийг дуусгахад 10 гаруй жилийн хугацаа шаардлагатай болохоор байна.

Улсын төсвийн зарлагын хязгаарлалт Төсвийн тогтвортой байдлын хуулийн тусгай шаардлагын дагуу гадаад эх үүсвэртэй зардлыг төсөвт

тусгахдаа хязгаарлаж байгаагаас үүдэлтэй гадаад зээл, тусламжийн төслүүдийн гэрээ хэлэлцээрийн дагуу санхүүжих дүнгийн 24 орчим хувийг л төсөвт тусган баталж байна.

Мөн 2020 оноос хойших нөхцөл байдлыг харвал гадаад зээлийн ашиглалтын батлагдаж буй нийт хэмжээ ашиглаагүй үлдэгдлийн 12 орчим хувьд байгаа нь цаашдын гадаад зээлийн ашиглалтын талаар бодлогын шинэчлэл хийх зайлшгүй шаардлага байгааг харуулж байна.

Дээрх бодлогын арга хэмжээ авахгүй бол нэг төслийн хэрэгжих хугацаа дунджаар 5-аас 10 жил хойшлох, зардал нэмэгдэх хүүгийн төлбөр болон зээлийн үнэлгээний төлбөр өсөх, төслүүдийн үр өгөөж, эдийн засгийн үр ашгийг хүртэх хугацаа хойшлох бодит эрсдэлтэй байна.

Иймд Улсын Их Хурлын 2024 оны 81, 54 дүгээр тогтоолын дагуу зээлийн хөрөнгийн зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлэх, зээлийн хөрөнгийг зөвхөн бодит эдийн засгийн салбарт чиглүүлэх, үр ашиггүй зөвлөх үйлчилгээ, урсгал зардлыг бууруулах, төслүүдийг эрэмбэлэх талаар дараах арга хэмжээнд авч хэрэгжүүлж байна. Үүнд:

1. Санхүүжилтийг шилжүүлэх зээлүүдийн төслийн үр ашиг, ач холбогдлоор нь эрэмбэлж нийт 173.8 тэрбум төгрөгийн санхүүжилт гаргах боломжгүй 33 төслийн 101 арга хэмжээний санхүүжилтийг Засгийн газрын урд, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт туссан үндэсний томоохон дэд бүтэц, бүтээн байгуулалтын мега төслүүдийн зээлийн ашиглалтын дүнд шилжүүлэн нэмэгдүүлсэн.

2. Хэмнэлтийн зарчим буюу нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжид шилжүүлэх төсөл бүрд байгуулагдсан тусгайлсан төсөл хэрэгжүүлэх нэгжтэй байх бүтцээс тогтолцооны хувьд шилжилт хийж, салбар бүрд нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж байгуулах тухай Засгийн газрын 2025 оны 24 дүгээр тогтоол гаргаж, 200 орчим орон тоог бууруулж, нэгжийн төсөл, зардлыг 40 орчим хувиар хэмнэх арга хэмжээг эхлүүлээд байна.

3. Цахим шилжилт төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системд гадаад зээл, тусламжийн болон бусад эх үүсвэрийг нэгтгэх, их өгөгдөл, хиймэл оюун ухаанд суурилсан шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх, гадаад зээл, тусламжийн бүхий л үе шатыг олон нийтэд нээлттэй, ил тод болгох, дэд системийг үе шаттайгаар нэвтрүүлэх, хөрөнгө оруулалтын их өгөгдөлд суурилсан мэдээллийн сан үүсгэж, уялдаа холбоотой, үр ашигтай хөрөнгө оруулалтын нэгдсэн платформ хөгжүүлэх ажлууд хийгдэж байна.

Үүнээсээ мөн дуусаж байгаа.

Бодлогын шинэчлэл.

Олон улсын практикт Сингапур, Вьетнам, Энэтхэг, Филиппин, Чили, Герман зэрэг улс орнууд томоохон дэд бүтцийн болон хөгжлийн өндөр өртөг бүхий мега төслүүдийн санхүүжилтийг ихэвчлэн гадаадын тусламжаар санхүүжүүлдэг ч төсвийн тусгай шаардлагаас тодорхой төсөл, зардлыг хасаж тооцох, эсвэл хөрөнгө оруулалтын тусгай зориулалтын санхүүгийн механизм болох сан, агентлаг байгуулах, эсвэл ACCRUAL сууриар бүртгэл хийх зэрэг байдлаар асуудлыг шийдвэрлэж ирсэн туршлагауд байна.

Эдгээр зохицуулалт нь ерөнхийдөө хөгжлийн төслүүдийг Засгийн газрын гадаад нийт өрөнд багтааж, харин өндөр өртөгтэй, олон жил үргэлжлэх бүтээн байгуулалтыг үр дүнтэй, хугацаанд нь хэрэгжүүлэхэд шаардлагатай урт хугацааны санхүүжилтийн тусгай механизмыг бий болгох, өөрөөр хэл бэл Засгийн газрын нийт өрөнд багтааж, харин төсвийн алдагдалд тооцохгүйгээр эрх зүйн орчныг бүрдүүлэхэд чиглэсэн байдаг.

Бидний хувьд ч гэсэн олон улсын сайн туршлага руу шилжих замаар мега төслүүдээ санхүүжүүлж, төлөвлөсөн хугацаанд нь ашиглалтад оруулах зайлшгүй хэрэгцээ шаардлага тулгараад байгаа. Жишээ нь, Сингапурын Засгийн газар 2021 онд баталсан Томоохон дэд бүтцийн Засгийн газрын зээлийн хүрээнд олон жилийн үр өгөөжтэй, үндэсний хөгжилд стратегийн ач холбогдол бүхий дэд бүтцийн төслүүдийг тусгай санхүүгийн механизмаар санхүүжүүлж байна.

Энэхүү хууль нь төсвийн үндсэн зарлага алдагдлын дүрмийг шууд зөрчихгүйгээр тодорхой шалгуур хангасан төслүүдэд эх үүсвэртэй санхүүжилт татах эрх зүйн үндсийг бий болгосон байдаг.

Байнгын хороон дарга, эрхэм гишүүд ээ,

Засгийн газрын өрийн удирдлага гадаад зээл, тусламжийн хэрэгжилт, нөхцөл байдалтай холбоотойгоор бид төсөв, санхүүгийн сахилга, хариуцлага хөрөнгө оруулалтын эх үүсвэрийн уялдаа холбоо, гадаад зээл, тусламжийн үр ашиг, бүтээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр бид үргэлжлүүлэн ажиллах болно.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Тэмүүлэн: Сангийн сайдад баярлалаа.

Гадаад зээл, тусламжийн өнөөгийн нөхцөл байдалтай холбоотойгоор танилцуулга, мэдээлэлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу? Гишүүдийн нэрсийг авъя. Х.Жангабыл гишүүнээр тасалъя. Б.Тулга гишүүн асуулт асууна.

Б.Тулга: Сангийн сайдын танилцуулгатай танилцлаа.

Тэгээд Монгол Улсын гадаад зээл, тусламжийн ашиглалт, Монгол Улсын өнөөдрийг хүртэл авч явж байгаа байдал дээр Сангийн яамныхан танай багийнханд талархал илэрхийлмээр байна.

Ер нь өнөөдөр Монгол Улс зээлийн хүү, тэгээд олон улсын банк, санхүүгийн байгууллага дээр үнэлэгдэж байгаа үнэлгээ тийм муугүй байгаа. Энэ нь Та бүгдийн үйл ажиллагаатай холбоотой гэдгийг энэ ташрамд хэлье.

Тэгээд миний асуух гэсэн асуулт бол сая гарч байна. Улаанбаатар хотын шинэ нисэх онгоцны буудлын зээл байгаа. Япон Улсын.

Тэгэхээр энэ зээлийн менежментийг төр, хувийн хэвшлийн гэдэг юм уу, ялангуяа гадаадын хөрөнгө оруулалттай компани менежментийг 100 хувь дааж авч явж байгаа.

Тэгэхээр энэ бол юу гэдэг юм манай төрөөс хамаараад менежмент дээр алдаа гаргах гэдэг юм уу ийм эрсдэл байхгүй. Дээр нь энэ дээр ажиллаж байгаа аж ахуйн нэгж маань өөрөө улсын төсөвт орлого оруулдаг. Орлого оруулахдаа 3 бүтэцтэйгээр. Тийм ээ. Дотроо задаргаатайгаар орлого оруулж байгаа. Нэг нь концессын үйл ажиллагааны төлбөр, хувь компанийн хувийн ногдол ашиг, тэгээд татварын орлого гэсэн ийм орлого оруулж байгаа сайн төслийн нэг.

Тэгэхээр нэмж ийм төсөл хэрэгжүүлэх боломжтой. Тухайлбал, манай энэ боомтын байдаг юм уу, авто замын төслүүд дээр ийм маягаар зээл авахад боломжтой юу? Аль эсвэл одоогийн таны дурдаж байгаагаар улсын зээлийн таазтай холбоотойгоор ч юм уу, ингээд хязгаарлалтад орж байгаа зүйлүүд бий юу гэдэг дээр Та бүхэн нэг тайлбар хэлээч ээ гэж хүсэж байна.

Г.Тэмүүлэн: Б.Тулга гишүүний асуултад хариулъя. 7 номер. Сангийн сайд.

Б.Жавхлан: Б.Тулга гишүүнд баярлалаа.

Тийм ээ. Бид ер нь сүүлийн жилүүдэд буюу 2017 онд Олон Улсын Валютын Сангийн хөтөлбөрт орсноос хойш манай гадаад зээлийн өрийн менежмент эрс сайжирсан байгаа. Тэндээс гэрийн даалгавар авч үлдсэн гурав, гурван жилээр Улсын Их Хурлаар гадаад өрийнхөө дунд хугацааны стратегиа батлуулж яваад яг энэ дагуу явна шүү гэдэг ийм дүрэмтэй болсон.

Үүнийгээ ч яс барьсан. Тэгсний үр дүнд бид 2012 оноос хойш 12 жилийн дараа алдсан байсан, уруудсан байсан зээлжих зэрэглэлээ 2024 онд эргүүлэн олж авч, улмаар энэ жил Америкийн Нэгдсэн Улсын зээлжих зэрэглэл DOWNGRADE болсон. Манайх Хятадаас бүрэн хамааралтай байгаад байна.

Гадаад нөхцөл байдал. Тэгтэл Хятадууд маань бас DOWNGRADE болсон. Зээлжих зэрэглэл нь буурсан.

Харин манайх одоо энэ жил бид хэвээр нь хадгалж чадаж байгаа нь гадаад өрийн менежмент гадна талдаа хэрхэн яаж үнэлэгдэж байгааг харуулж байгаа юм. Үүнийг Та тодруулж хэллээ. Баярлалаа.

Тэгэхээр цаашдаа ийм байна. Цаашдаа бид гадаад өрийнхөө хэмжээг нөгөө дотоодын нийт бүтээгдэхүүн тэлэхийн хэрээр тэр орон зайгаар нэмээгүй, нэмэхгүй яваад байгаа, бариад яваад байгаа.

Хэдхэн жилийн өмнө нөгөө 80 хувьд хүрч байсан энэ харьцаа маань одоо ингээд үндсэндээ 40 хувь дээр тогтворжлоо. Яах вэ, одоо энэ чинь нөгөө мөчлөг сөрөөд энэ нөөцөлсөн орон зайгаа бид уг нь ашиглаж байвал зүгээр байгаа юм. Гэтэл нөгөө хязгаарууд дотроо багтаад бид үүнийгээ ашиглаж чадахгүй. Яг төсвийнхөө хязгаар дотроо.

Тийм учраас эсвэл төсвийнхөө хязгаарыг үүнийгээ шинэчилсэн байдлаар зохицуулалтаа хийх, эсвэл бүр нэмж дахиж ерөөсөө ийм зээл авахгүй байх л ийм л хоёр арга зам болоод байгаа юм.

Тийм учраас яах вэ олон улсын практик жишээнүүд байна. Ийм ACCRUAL суурьтай ийм хэлбэр лүү шилжиж байна. Эсвэл Улсын Их Хурал дээр үнэхээр үр өгөөжтэй, ирээдүйд энэ зээл нь төсөвт эрсдэл авчрахгүй юм байна, өөрөө өөрийгөө нөхөөд төлөх юм байна гэдэг ийм олон шалгууруудаа тавиад, үүнийхээ ашиглалтыг төсвийнхөө өөр дүрмээр зохицуулалт хийгээд явдаг ч юм уу. Ер нь ийм боломж, гаргалгаанууд байна гэдгийг Засгийн газрын зүгээс удаа дараа ярьж хэлж байгаа. Тэгээд цаашдаа яг үүнийгээ л бид салаа замынхаа л ийм үзүүр дээр ирсэн байна.

Тийм учраас үүнийгээ л нэг тийш нь болгох ийм шаардлагатай болж ирж байгаа. Тэгээд яг цаг хугацаа цаг үеийн байдал маань. /минут дуусав/

Г.Тэмүүлэн: Н.Батсүмбэрэл гишүүн асуулт асууя.

Н.Батсүмбэрэл: Энэ их чухал асуудал байгаа юм. Засгийн газрын гадаад өр зээл, тусламжийн асуудал гээд.

Энд энэ танилцуулга дотор яагаад Оюу Толгойн материал, Оюу Толгойтой холбоотой мэдээлэл байхгүй байгаа юм бэ? Би хайгаад олсонгүй. Нэг. Энэ чинь Засгийн газартай хийсэн хэлэлцээр энэ тэр гээд яваад байдаг. Тийм ээ.

Тэгээд өгч байгаа мэдээллээр бид 11 орчим хувийн хүүтэй зээл Рио Тинто авсан юм шиг байгаа юм. Тэгээд үүнийг хүүд нь өдөрт 10 тэрбум төгрөгийг

Монголчууд төлж байна гэсэн мэдээллийг хэвлэл мэдээллээр өгч байгаа. Оюу Толгой болон ENTRÉE холбоотой асуудлыг шалгах түр хороо байгуулагдсан ажиллаж байгаа. Тэгээд энэ мэдээлэл яагаад энд тараагдсангүй вэ? Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, 90 орчим хоног үлдээд байгаа энэ хугацаанд өндөр хүүтэй Риогийн зээлийн хүүг бууруулж болохгүй юу? Энэ дээр Сангийн яам ажиллаж байгаа юм бий юу? Авч байгаа мэдээллээр бондууд 6-аас 7 хувийн хүүтэй байдаг юм байна. Харамсалтай нь саяын яриад байгаа тэр Оюу Толгойн зээл 4-өөс 5 хувийн өндөр хүүтэй байгаа. Тэгээд үүнд монголчууд өдөрт 10 тэрбум төгрөг төлнө гэдэг чинь юу гэсэн үг юм бэ? Сургууль, цэцэрлэгээ барьж чадахгүй, багш, эмч нарынхаа цалинг нэмэгдүүлж чадахгүй байж ийм байдалтай байгаа нь харамсалтай.

Тэгэхээр энэ хоёр асуултад хариулж өгөөч.

Нэгдүгээрт, Оюу Толгойтой холбоотой мэдээлэл яагаад энэ дотор байсангүй.

Хоёрдугаарт, энэ хамааралгүй байлаа. Гэхдээ Оюу Толгойн зээлийн хүүг бууруулах боломж байгаа талаар Их Хурлын туршлагатай гишүүд, мөн түр хорооны гишүүд ярьж байгаа. Үүн дээр Сангийн яам ажиллаж байна уу?

Та бидний мөрдөж ажиллаж байгаа Улсын Их Хурлын 2022 оны 26 дугаар тогтоолоор батлагдсан 2023-2025 оны стратегийн баримт бичиг дотор олон зорилт байгаагийн нэг нь төсөвт учруулах болзошгүй өр төлбөрийн эрсдэлийг бууруулах зорилтыг тавина гэсэн байгаа. Тэгээд энэ авч байгаа бидэнд өгч байгаа мэдээллээр энэ өр зээл чинь төсөвт дарамт учруулах байтугай асуудалтай болчихоод байгаа юм биш үү. Энэ дээр нэг хариулт аваадахъя.

Г.Тэмүүлэн: Н.Батсүмбэрэл гишүүний асуултад хариулъя. 7 номер Сангийн сайд.

Б.Жавхлан: Н.Батсүмбэрэл гишүүний асуултад хариулъя.

Ёстой юу гэсэн үг юм бэ? Яахаараа Монгол Улсын зээлжих зэрэглэл “В+” тогтвортой болоод байхад Оюу Толгойн хувь нийлүүлэгчдийн зээлийн хүү SOFR + 6.5% буюу 11-ээс дээш байна гэдэг чинь энэ бол бүр хамгийн дампуу шүү. Хамгийн дампуу.

2018 онд хийсэн зохицуулалт юм билээ. Харамсалтай нь тэр үед 3 юмаар түгжээд хаясан байгаа юм.

- ➔ Хүү нь ийм өндөр суурьтай.
- ➔ Тэгээд 7 жилийн дараа эргэж харна. Тэр болтол эргэж харж болохгүй.

→ Дээрээс нь энэ хугацаанд нийлмэл хүүгээр тооцно гээд.

Ингээд энэ хооронд чинь ийм 3 түгжээсээр нөгөө 6 тэрбум долларын өр чинь 12 болоод байгаа юм. Үүнийг сая 9 сараас эхлээд Сангийн сайд ахлаад энэ ажлын хэсэг байгуулагдаад, хэлэлцээр хийгээд, бид үүрэг аваад яг ажиллаад явж байна.

Хэт оройтоогүй байна. Хугацаа байна. Тэгэхдээ давчуу. Одоо манай зээлжих зэрэглэл нэгэнт бид сайжирсан байгаа учраас бидэнд давуу тал үүссэн.

Тийм учраас гэрээ хийхэд бид 7 жилийн өмнөхөөс 12 жилийн өмнөхөөс хамаагүй өөр нөхцөл байдалтай бид хэлцлийн ширээний ард сууна.

Тийм учраас тодорхой хэмжээнд зээлийн хүүг бууруулна гэдэг дээр итгэлтэй байгаа. Харин энэ 3 зүйл. 3 зүйлийг өөрчлөх хэрэгтэй.

→ Зээлийн хүүгээ буулгана.

→ 7 жил гэдгийг болиулах хэрэгтэй. Ядаж 3 жилээр.

Өөрөөр хэлбэл өрийн удирдлагын менежментээ бид 3, 3 жилээр тооцож явж байгаа.

Тэгэхээр энэ хугацаа руу ядаж буулгах ёстой.

→ Дээрээс нь тэр нийлмэл хүүг болиулах хэрэгтэй.

Ийм бүдүүлэг тооцоолол дэлхийн хаана ч ийм том төслүүд дээр байхгүй. Ийм 3 зорилттой ажиллана.

Нарийн хэлэлцээрийн тактик юмнуудыг энд нээлттэй задгай ярих нь зохимжгүй. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, Оюу Толгойн яригдаад байгаа компанийн хувь нийлүүлэгчдийн өр зээлийн асуудлууд нь Засгийн газрын өрөнд тооцогддоггүй юм.

2012 онд ийм зохицуулалт орсон. Түүнээс хойш үүнийг оруулж тооцдоггүй дүрэмтэй. Зөвхөн Засгийн газрын өр, баталгаа, нийслэл, аймгийн өр баталгаанууд л Засгийн газрын өрөнд тооцогддог.

Тэр битгий хэл Хөгжлийн банкны өр хүртэл Засгийн газрын өрөнд тооцогдохгүй шүү дээ. Бүр ГОК-ын Эрдэнэт үйлдвэрийн өр ч бас ордоггүй. Ийм тооцоололтын хувьд.

Харин бид Засгийн газрынхаа өрийн менежментийнхээ эрсдэлээ тооцохдоо эдгээрийг бүгдийг нь оруулж тооцож явдаг. Олон Улсын Валютын Сантай эрсдэлийн тооцоо хийхдээ мөн эдгээр өрүүдийг Монгол Улсын өрөнд тооцуулж, эрсдэлээ байнга тооцож явж байгаа. Тийм.

Г.Тэмүүлэн: Н.Батсүмбэрэл гишүүн нэмж тодруулъя.

Н.Батсүмбэрэл: Баярлалаа. Би санхүүгийн чиглэлийн мэргэжлийн хүн биш учраас нарийн ширийн юм сайн мэдэхгүй юм.

Сангийн Яамны энэ өр, зээл, төлбөртэй холбоотой газар хэлтсийн дарга нараасаа Та уулзуулаад нарийн мэдээллүүд өгч болох уу? Тэгээд би энэ талаар нэлээн дэлгэрэнгүй мэдээлэлтэй болъё гэж бодож байна.

Тэгээд Монголын ард түмэн бүгдээрээ Оюу Толгой, ENTRÉE_[фр.Антрэ], Рио Тинто гэдэг компанийн үйл явдалтай холбоотой асуудлыг ёстой нүд чавчихгүй харж хүлээж байгаа. Энд ямар шийдвэр гарах нь вэ, Монголын эрх ашигт яаж нийцүүлж шийдвэр гарах нь вэ гэдгийг харж байгаа учраас бид энэ дээр анхааралтай байх ёстой.

Сая тэгээд хэлж байна. Тэр Хөгжлийн банкны асуудал. Хөгжлийн банк дээр байгаа тэр зээлтэй холбоотой асуудлыг дэлгэрэнгүй мэдээллийг авъя.

Ер нь бид чинь нэг хамтарсан засаг байж байгаад больсон. Тэр Хөгжлийн банкн дээр нэг өөр намын нөхөр байгаа юм билээ. Тэрийг хэзээ солих юм? Тэнд чинь бас дунд чөмгөөрөө жиргэж, дураараа далжганаж байгаа сураг дуулдаад байгаа.

Г.Тэмүүлэн: 7 номер. Сангийн сайд.

Б.Жавхлан: Н.Батсүмбэрэл гишүүн ээ. Тэгье тэгье. Бид Засгийн газрын өрийн мэдээллүүд дээр нууж хаах юм байхгүй. Бүгд мэдээллүүдийг танд хүргүүлъя.

Хоёрдугаарт, харин тэр Хөгжлийн банктай холбоотой асуудал бол Эдийн засаг, хөгжлийн яам хариуцаж байгаа.

Тэгэхээр тэндээс тодруулбал танд мэдээллүүд очих байх аа. Тийм. Би бас дамжуулъя.

Г.Тэмүүлэн: Г.Хосбаяр гишүүн асуулт асууя.

Г.Хосбаяр: Дэлхийн бүх л улс зээл, тусламж авч бүтээн байгуулалт хийж хөгждөг юм билээ.

Тэгэхээр энэ авсан зээл, тусламжаа зөв зүйтэй ашиглах, зарцуулах тал дээр онцгой анхаарч явах ёстой байх гэж бодож байна. Тэгээд авна гээд авдаггүй нөгөө гадаадын зээл, тусламжаа хурдхан шиг аваад, зээлийн ашиглалтаа сайжруулах тал дээр Сангийн сайдыг санал бодлогоо оруулж ирэх байх гэж бодож байгаа. Тэгээд энэ дээр 100 хувь дэмжээд явна. Тэгэхгүй бол баахан гэрээ хэлцэл хийхчээд энд Монголд баахан хийх ажил байдаг. Тэгтэл тэр мөнгөө авч ашигладаггүй ийм байж болохгүй байх.

Тэгэхээр гэрээ хэлцлээ хийсэн, ашиглахад бэлэн мөнгөнүүд, энэ юмнуудаа оруулж ирээд энэ ажлуудаа хийгээд явахыг 100 хувь дэмжиж байгаа.

Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа тодорхой төслүүд дээр очиж ажилласан. Ер нь бас нэг анхаармаар зүйлүүд байна лээ. Үүн дээр гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа ажлууд дээр жишээ нь төсөвт өртөг өндөр ажлууд байна.

Яагаад гэхээр Монгол Улсын барилга, бүтээн байгуулалтын норм, дүрэм, стандарт, төсөвт захирагддаггүй, зөвхөн өөрсдөө төсвөө хийдэг, тэндээ гүйцэтгэгчээр шалгаруулдаг ийм зүйлүүд байна лээ. Мөн Монгол Улсын НӨАТ-ын татвар, гаалийн албан татвараас, гаднаас бараа, материал оруулж ирэхдээ чөлөөлөгддөг ийм төслүүд байна лээ.

Энэ болгонд чинь мэдээж нөгөө дотоодын бүтээн байгуулалт хийж байгаа компани, хувийн аж ахуйн нэгжүүдтэй ялгаатай л байна гэж ойлгогдож байгаа.

Тийм учраас гадаадын зээл, тусламжаар хийгдэж байгаа ажлууд бүгдээрээ НӨАТ, гаалийн татвараас чөлөөлөгддөг юм уу? Ер нь Монгол Улсын барилгын салбар, замын салбарын норм дүрэм, стандартад нийцсэн тэр төсөв юмаар өртөг юмаа тооцож болдоггүй юм уу гэдэг ийм нэг асуулт байна.

Мөн зүгээр нэг жишээ хэлэхэд Солонгосын ЭКЗИМ банкны 500.0 сая долларын 110 хэдэн сая доллароор хэрэгжиж байгаа 10 аймгийн дулааны станцын төсөл гэхэд дампуурсан юм байдаг. Олон жил үргэлжилж байгаа. Гэтэл тэр 500.0 саяын үлдсэн буюу 300 хэдэн сая доллароор хэрэгжиж байгаа “Солонго-1, 2” хороолол, тэр Баянголын аманд орон сууц барих төсөл болохоор амжилттай сайн яваад байдаг. Тэгээд яагаад жишээлбэл нэг ийм 500 сая долларыг 2 ийм төсөлд хийхэд л нэг нь амжилттай, нэг нь амжилтгүй болоод байна.

Ер нь манай талаас шалтгаалж байгаа юмнууд байгаа байгаа юм биш биз дээ. Тэр 10 аймгийн станцын төсөл дээр дампуурсан компани чинь зарим талаар манай төр, захиргааны байгууллагын буруутай шийдвэр, бас алдаатай юмнуудыг яриад явна гэсэн. Тэгээд ийм алдаа завхралуудыг ер нь засаад явах уу? Ер нь цаашдаа зээл, тусламжаа авна гэснийгээ аваад, өртөг юман дээр нь анхаарах шаардлагатай шүү л гэж... /минут дуусав/

Г.Тэмүүлэн: Г.Хосбаяр гишүүний асуултад хариулъя. 5 номер. Ж.Дэлгэржаргал. 6. Номер

Ж.Дэлгэржаргал: Г.Хосбаяр гишүүний асуултад хариулъя. Сангийн яам. Ж.Дэлгэржаргал.

Гадаад зээл, тусламжийн төслүүдийн хувьд гэрээ хэлэлцээр дээр байгаа нөхцөлүүдийн дагуу ихэнх нь ТЭЗҮ хийгдээд, ТЭЗҮ-ийнхээ дараа зураг, төсөл нь хийгддэг. Зураг төсөл дээр манай дотоодын Барилгын хөгжлийн төв, Зам тээврийн хөгжлийн төв, Эрчим хүчний хөгжлийн төвүүд магадлал хийж байгаа.

Зээл, тусламжийн төслүүдийн хувьд улсын төсвийн хөрөнгө оруулалтаас ялгаатай асуудал хоёр талын хяналт хийгддэг.

Санхүүжүүлэгч тал, Монголын тал гээд.

Нөгөө талдаа тухайн хэлэлцээрүүд дээр тусгасан нөхцөлөөрөө худалдан авах ажиллагаа нь Азийн хөгжлийн банкны худалдан авах ажиллагааны журам, Дэлхийн банк, Солонгосын ЭКЗИМ бол яг ЭКЗИМ банкны худалдан авах ажиллагааны журам, гүйцэтгэгчийг Улсын Их Хурлаар батлагдсан хэлэлцээр дээрээ аль талын гүйцэтгэгч байх вэ гэдгээ бүр тодорхой заасан ийм нөхцөлүүд байдаг.

Таны тухайлан асуусан 10 аймгийн хувьд 2018 оноос хэлэлцээрүүд нь байгуулагдаад, яах вэ санхүүгийн хүндрэлийн хувьд дунд нь ковидын үе таарсан гэдэг асуудал байгаа. Энэ дээр цаашдаа нэгэнт гүйцэтгэгч дампуураад. Солонгосын талын гүйцэтгэгч байгаа. Дампуурлаа зарласан учраас дараагийн үлдэгдэл зээлийн ашиглалт дээрээ дараагийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, хэрхэн энэ төслийг үргэлжлүүлэх вэ гэдэг хэлэлцээрийг Солонгосын Санхүү, эдийн засгийн яам, Солонгосын ЭКСИМ банк, Эрчим хүчний яам, Сангийн яам гээд хамтран хэлэлцээр явж байгаа.

Энэ 10 аймгийн төсөл дээр ЭКСИМ банк өөрийнхөө санхүүжилтээр төслийн хэрэгжилтийг дэмжих зөвлөх компани шалгаруулаад, одоо яг хэрэгжиж аймгууд дээр хоёр талаас ажлын хэсэг гараад ажиллаад явж байгаа.

Энэ тайлан 11 сарын 15-нд дуусна. Энэ тайлан дээр яг энэ төслийг үлдэгдэл санхүүжилтээрээ бид үргэлжлүүлэхэд одоо байгаа бодит гүйцэтгэл, тэнд байгаа тоног төхөөрөмжүүд, цааш нь хэрэгжүүлэхэд үлдсэн зээлийн ашиглалт хүрэлцэх, үгүй, энэ дээр Монголын талаас ямар оролцоотой байх вэ гэдэг бүх асуудлууд тодорхой болоод, энэ дээр хоёр тал хэлэлцээрийнхээ үндсэн дээр хэрвээ санхүүжилтийн хэлэлцээрт бид бүтэц дотор нь зарим зардлуудыг, магадгүй төслийг дуусгахын тулд маргашгүй ажлыг хэрвээ ашиглах шаардлагатай бол хэрхэн хуваарилах вэ гэх мэт асуудал Засгийн газрын

тогтоолоор санхүүжилтийн хэлэлцээрт өөрчлөлт оруулаад 01 сарын 01-нээс бид дараагийн гүйцэтгэгч буюу энэ дээр Солонгосын заавал компани байх уу, эсвэл Монгол талын туслан гүйцэтгэгч ажиллаж байгаа гүйцэтгэгч байх уу гэдэг дээр Эрчим хүчний яам бас илүү шийдвэртэйгээр зохион байгуулалт хийгээд ажиллахаар хэлэлцээрүүд явж байна.

Төсөвт өртгийн хувьд одоо яг хийгдсэн ТЭЗҮ дээр үндэслээд Барилгын хөгжлийн төв магадлал хийгээд явж байгаа учраас яг энэ илүү төсөвт өртөг болон энэ үнэ өртөг дээр Барилгын хөгжлийн төв, Барилга, хот байгуулалтын яамнаас дэлгэрэнгүй мэдээлэл авбал зүйтэй байна.

Г.Тэмүүлэн: Г.Хосбаяр гишүүн нэмж тодруулъя.

Г.Хосбаяр: Тэр Улаанбаатарт хэрэгжиж байгаа цэвэрлэх байгууламжийн төсөл дээр очсон. Энэ Ганзориг дарга цуг очсон доо.

Төсөв нь Монголын тэр барилгын хөгжлийн төвөөр ороогүй л юм байна лээ. “Солонго-1, 2” хорооллын төсөл дээр бас л очсон. Бас л ороогүй л байсан даа. Тэгээд ордог бололтой. Бүгдийг нь ингэж ярьж болохгүй байх.

Тэгэхээр яг аль аль нь орсныг тэрийгээ ялгана биз.

Тэгээд би Сангийн сайдаас асуух гээд байгаа нь. Тэр НӨАТ, гаалийн татвараас чөлөөлөгддөг юм байна лээ. Тэд нар ер нь бүх энэ төслүүд ингэж НӨАТ, гаалийн татвараас чөлөөлөгддөг юм уу? Энэ нь эргээд хувийн хэвшлийн дотоодын аж ахуйн нэгжүүд адилхан бүтээн байгуулалт хийж байхад тэд нар гааль НӨАТ-аас чөлөөлөгддөггүй шүү дээ.

Тэгэхээр үүнээс чинь болоод л бас өртөг энэ адилхан ажил хийж байгаа газруудын ялгаа зааг гараад байгаа. Энэ дээр Та нэг хариулт өгөөч.

Г.Тэмүүлэн: Г.Хосбаяр гишүүний асуултад хариулъя. 8 номер.

С.Тулга: С.Тулга. Сангийн яам. Гишүүний асуултад хариулъя.

Тэр гаалийн албан татвар болон нэмэгдсэн өртгийн албан татварыг гадаадын зээл, тусламж аль алинаас нь ерөнхийдөө чөлөөлж байгаа. Тусламжаас яагаад чөлөөлдөг вэ гэхээр донор орны татвар төлөгчдийн мөнгөөр манай улсад үзүүлж байгаа тусламж учраас үүнээс Монгол Улсын Засгийн газар давхардуулан татвар авахгүй байх зарчмын дагуу ер нь тусламжийг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлж байгаа.

Зээлийн хувьд зээлийн хөрөнгөөр орж ирж байгаа бараа, бүтээгдэхүүн. Түүн дээр гааль болон нэмэгдсэн өртгийн албан татварыг авахаар нөгөө зээлийнх нь зардлыг л нэмэгдүүлнэ гэсэн үг л дээ. Зээлээр авч байгаа

юмнаасаа татвар авах нь өөрөө логикгүй болоод байгаа учраас, буцаагаад төлөх юман дээрээ татвар авч байгаа нь логикгүй байгаа учраас зээл дээр гааль болон нэмэгдсэн өртгийн албан татварыг нийтлэгээр чөлөөлж явж байгаа. Энэ зээлийн бүх ерөнхий хэлэлцээрүүд дээр тусгагдаад явдаг.

Г.Тэмүүлэн: Ж.Дэлгэржаргал нэмж хариулъя. 6 номер.

Ж.Дэлгэржаргал: Солонгосын ЭКСИМ банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж байгаа “Солонго-1” хорооллын хувьд 2022 оны 1172/2022 гэсэн магадлалын ерөнхий дүгнэлтээр Барилгын хөгжлийн төв магадлал хийгдсэн байгаа.

Төв цэвэрлэх байгууламжийн хувьд Хятадын ЭКСИМ банкны хөнгөлөлттэй зээл, түлхүүр гардуулах буюу EPC[Engineering, Procurement, Construction] нөхцөлтэй учраас зураг, төслөө гүйцэтгэгч өөрөө хийгээд, түүнийхээ дагуу гүйцэтгэх нөхцөлтэй учраас яг энэ төв цэвэрлэх.

Нөгөө талдаа ТЭЗҮ нь батлагдсан технологийн байгууламж учраас Барилгын хөгжлийн төв дээр магадлал хийгдээгүй юм байна.

Г.Тэмүүлэн: Болсон уу? Г.Хосбаяр гишүүн. Д.Ганбат гишүүн асуулт асууна.

Д.Ганбат: Яах вэ, юу юм шиг байна. Тийм ээ.

Та бүхэн энэ улсын нийт гадаад өрийн өнөөгийн нөхцөл байдал гээд тэгсэн мөртлөө 2024 оноор л яриад байх шиг байна л даа. Одоо ингээд 2025 он дуусаж байна.

Тэгээд 2025 оны дүнгээр яг ямар байна вэ? Миний ойлгож байгаагаар

- Монгол Улсын нийт өр **39 тэрбум доллар**, бараг **40 тэрбум доллар** дээр очсон байна гэж ойлгоод байгаа.
- Засгийн газрын өр **9 тэрбум доллар** дээр очсон байна гэж ойлгоод байна.

Тэгээд бид 10 жилийн өмнө ямар байсан. Зээлжих зэрэглэл. Түүндээ бараг арай хүрээ ч үгүй. Энэ 10 жилийн хугацаанд бид нарын байгаа байдал ийм л байгаа байхгүй юу.

Ер нь Засгийн газар зээл аваад ажиллахдаа хувийн хэвшлийн хийж чаддаг ажил дээр зээл авч оруулаад байх шаардлага байхгүй. Хувийн хэвшлийнхэн өөрсдөө аваад хийх тэр нөхцөлийг нь л бүрдүүлж өгмөөр байгаа юм. Тэгж л ажиллавал зүгээр байх шиг байна.

Та бүхэн Засгийн газрын зээл аваад хийсэн ажлууддаа аудит оруулсан уу? Дотоодын аудитыг оруулсан уу? Гаднын нэр хүндтэй байгууллага аудитыг оруулж аудит хийлгэсэн үү, үгүй юу?

Яг одоо тэр зээл авах тэр газартаа зээл авч чадаж байгаа юу? Хэрэв чадаж байгаа юм бол эрчим хүчний өнөөгийн нөхцөл байдал яахаараа ийм байдалд хүрсэн байдаг юм. Гэрэл гэгээ тасраад л, дулаан авч чадахгүй ийм газрууд олон л байгаа шүү дээ.

Тэгээд Дарханы зам байна. Тэрийг хэдэн жил хэрэгжүүллээ. 7, 8 жил хэрэгжүүлсэн. Үр дүн нь ямар байгаа билээ. Одоо болтол дуусаагүй л байна.

Нөгөө талаар нисэх онгоцны буудал байна. 600.0 сая доллар зарцуулсан. Харьцуулаад харахаар зүгээр нэг Америкийн нэг Аляскийн жижиг хотын 300, 400 сая доллар зарцуулаад хийсэн тэр онгоцны буудлаас доор байна шүү дээ. Одоо өргөтгөх шаардлагатай болсон. Сая 500 мянган хүнтэй хотын онгоцны буудал гэж байгаа. 3 сая 500. Далайд гарцгүй орны.

Иймэрхүү маягтай зарцуулж байна.

Сая манай Г.Хосбаяр гишүүн хэлж л байна. Тэр дулааны станц байхгүй. Үүний үр дүн энэ тэр юмыг нь үздэг хардаг юм байдаг юм уу, үгүй юм уу?

Одоо тэр бараг тэрбум шахуу доллар билүү. 2, 3-хан тэрбумыг нь солино гээд байгаа. Тэрний зураг төслийг нь болохоор 20 сая доллароор хийлгэж байна гэж байгаа.

Иймэрхүү маягтай явбал болж байгаа юм уу, үгүй юм уу гэсэн ийм асуудлуудыг асууж байна.

Хэр зэрэг үр дүнтэй байна вэ? Хувийн хэвшил нь болохоор нэг их зээл аваад байж чадахгүй байна. Яагаад гэвэл нөхцөл байдал, тэр үр дүн, энэ юм нь 10 жилийн өмнөх байдал дээр өнөөдөр арай гэж хүрэх гээд л явж... /минут дуусав/

Г.Тэмүүлэн: Д.Ганбат гишүүний асуултад хариулъя. 8 номер.

С.Тулга: С.Тулга Сангийн яам. Д.Ганбат гишүүний асуултад хариулъя.

Засгийн газрын өрийн хувьд энэ оны хагас жилийн байдлаар л гүйцэтгэл гарсан байгаа. Д.Ганбат гишүүн ээ.

Одоо 39.5 хувьтай тэнцүү байгаа. Дотоодын нийт бүтээгдэхүүний. Номинал дүнгээр 35.5 их наяд байгаа.

Таны ярьсан улсын нийт гадаад өрийн хувьд таны тоо зөв байна. Одоо энэ дотоодын нийт бүтээгдэхүүний 151.0 хувьтай тэнцэж байна.

Оны сүүлээр бид Засгийн газрын өр дотоодын нийт бүтээгдэхүүнтэй харьцахад 43.0 хувьд хүрнэ гэж тооцож байгаа. Энэ нь Засгийн газрын баталгаа энэ жил Их Хурлаас авсан зөвшөөрлийн хүрээнд баталгаагаа бүрэн дайчлах юм бол 43.0 хувьд гарна гэж бодож байгаа. Хэрвээ баталгаа гарахгүй бол 40.6 хувьтай байгаа.

Ингээд тогтмол цаашаа буураад явахаар байгаа.

Төсөвт үзүүлэх нөлөөлөл нь хүүгийн төлбөр байгаа. Хүүгийн төлбөр 2017 онд 1.2 их наяд байсан бол одоо ч гэсэн ерөнхийдөө энэ түвшиндээ 1.3 их наяд хадгалаад явж байгаа.

Хувийн хэвшилд Засгийн газрын зүгээс гадаад бондын дахин санхүүжилтийг хийж, тэр YIELD CURVE буюу “өгөөжийн муруй”-г зохистой түвшинд хамгийн боломжит бага түвшинд гаргаж өгснөөр одоо манай арилжааны банкууд бүгд гадаад улсад хөрөнгө босгож байгаа.

Голомт, Худалдаа хөгжил, ХААН, хамгийн сүүлд сая Төрийн банк гадаадын зах зээлээс хөрөнгө босголоо.

Зээлжих зэрэглэлийн хувьд бид өнгөрсөн 2024 онд 10 жилийн өмнөх түвшиндээ бүрэн хүрч чадсан.

- S&P, Moody's дээр B+ байгаа.
- S&P, Fitch дээр B+ байгаа.
- Moody's дээр B2 түвшинд.

Ингээд 10 жилийн хугацаатай бүрэн хүрсэн байгаа. Ингээд улам цаашаа цаашруулахээр ажиллаж байгаа.

Нөгөө нэг төслүүдийн хэрэгжилтийн талаар.

Г.Тэмүүлэн: 5 номер, 6 номер.

Ж.Дэлгэржаргал: Д.Ганбат гишүүний асуултад хариулъя. Сангийн яам. Ж.Дэлгэржаргал.

Аудитын хувьд 2 төрлийн аудит хийгддэг.

Яг тухайлсан төсөл дээр санхүүжүүлэгч талаас санхүүжилт гаргаад тусгайлсан аудит хийгдээд, үүнийг нь Үндэсний аудитын газар дээр нэгтгээд нэгдсэн тайлан явдаг.

Үндэсний аудитын газраас төсвийн нэгдсэн гүйцэтгэлд хийж байгаа аудитынхаа хүрээнд бас энэ зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төслүүд дээр аудит хийгдээд явдаг.

Яг хэрэгжиж байгаа төслүүдийн бодит үр дүн, үр дүнд хүрч байгаа байдал талаас Та тухайн хэрэгжүүлэгч яамдаас дэлгэрэнгүй мэдээллийг авах шаардлагатай гэж бодож байна.

10 аймагт үүссэн асуудалд Монголын талаас хийж байгаа оролцоо, өнөөдрийг хүртэл дуусах хугацаандаа дуусаагүй асуудал гээд олон тал дээр бид Эрчим хүчний яам, хэрэгжүүлж байгаа байгууллагууд дээр шаардлагууд тавиад явж байгаа.

Мэдээж дундаж гүйцэтгэл нь 45 хувьд хүрсэн байгаа учраас цаашаа бид үргэлжлүүлээд дуусах дээр яг энэ зээлийнхээ ашиглагдаагүй дүнд нь багтаагаад төслийг дуусгах дээр хамгийн хэрэгжих боломжтой хувилбар. Хэлэлцээр дээр Сангийн яам оролцоод энэ дээр Солонгосын бас Сангийн яам оролцоод ингээд хоёр талаасаа хэлэлцээр хийгээд явж байгаа.

Г.Тэмүүлэн: Аудит энэ дээр нэмэлт мэдээлэл өгөх үү? Ц.Наранчимэг дарга байна.

Угаасаа Төсвийн байнгын хорооноос чиглэл өгөөд нөгөө гүйцэтгэлийн аудит гүйцэтгэсэн шүү дээ. 2024 онд байна уу. Тийм ээ. 2023-2025 оных дээр. Энэ оных дээр хийсэн байх. Тийм ээ. 5 номер.

Ц.Наранчимэг: Д.Ганбат гишүүний асуултад хариулъя. Үндэсний аудитын газар. Ц.Наранчимэг.

Манай Үндэсний аудитын газар санхүүгийн тайлангийн баталгаажуулах аудитаар гадаадын зээл, тусламжийн тоо, дүнг баталгаажуулах аудитыг Төсвийн тухай хуулийн хүрээнд цаглаварт хугацаанд хийж гүйцэтгэж байгаа.

Хөдөө аж ахуйн салбарт хэрэгжиж байгаа гадаадын зээл, тусламжийн үр дүн, үр нөлөө гэсэн аудитыг 2023 онд гүйцэтгэлийн аудитыг хийсэн. Энэ жил бид Төсвийн байнгын хорооны баталж өгсөн сэдвийн хүрээнд Хөдөө аж ахуйн салбараас бусад салбарт хэрэгжиж байгаа гадаадын зээл, тусламжийн аудитыг хийж байгаа. 12 сарын сүүлээр тайланг нь хүргэнэ.

Г.Тэмүүлэн: Д.Ганбат гишүүн нэмж тодруулъя.

Д.Ганбат: Аудит маань тэгээд энэ оны сүүлээр л гарах юм байна шүү дээ. Тэр дүгнэлт чинь. Тийм ээ.

Тэгээд гаднын зээл, тусламжуудын хэрэгжилт энэ байж байгаа юм, хум дээр гаднын нэр хүндтэй хүлээн зөвшөөрөгдсөн аудитын байгууллагыг оруулах шаардлагатай гэж үзэж байна. Үзэж байна уу? Ямар байна та нар. Тэр дээр Та бүхэн юу гэж бодож байна вэ гэдгийг нэг асуумаар байгаа юм.

Тэгээд энэ 14 мега хулгай боллоо гэж байна. Би яриагүй л дээ. Их Хурлын гишүүн байсан хүмүүс яриад байна. Би ч бас түүнтэй бараг санал нэг болж, нэг байна.

Нөгөө талаар Засгийн газраас зээл авч хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрөөс амжилттай болсон нь юу юу байгаа юм? Амжилтгүй байгаа нь ямар ямар юм байна вэ гэдэг дээр Та бүхнийг араас нь хяналт тавьдаг л байлгүй дээ. Мөнгө төгрөгт.

Г.Тэмүүлэн: Ц.Наранчимэг дарга. Энэ юуг та нар мэдэж байгаа биз. Ц.Наранчимэг дарга аа, аудитаас бид нарт хүргүүлсэн байгаа.

Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилт гээд. Энэ дээр гүйцэтгэлийн аудитын тайлан гаргаад бид нарт хүргүүлсэн. Байнгын хорооны гишүүдэд хүргүүлсэн байгаа.

Нэмж хариулах уу? 5 номер. Дараагийнх нь Сангийн яам.

Ц.Наранчимэг: Д.Ганбат гишүүний асуултад нэмж хариулъя.

Олон улсын эрхтэй аудитын байгууллагаар аудит хийлгэвэл эд нар олон улсын стандартаараа баталгаажуулах аудитыг хийж гүйцэтгэдэг.

Манай Үндэсний аудитын газар 3 төрлийн аудит хийж байгаа.

- Гүйцэтгэлийн,
- Нийцлийн,
- Санхүүгийн тайлангийн аудит.

Гүйцэтгэлийн аудит бол маш чухал аудит байгаа. Яагаад гэвэл үр дүн, үр нөлөө, арвилан хэмнэлтийг үздэг аудит байгаа.

Гүйцэтгэлийн аудитын үр дүн нь юу байдаг юм бэ гэхээр гүйцэтгэлийн аудитаар гарсан асуудлууд иргэдийн амьдралд өгч байгаа зөвлөмжид хэр зэрэг нөлөөлж вэ гэсэн үр дүн байдаг.

Монгол Улсын ерөнхий аудиторын шинээр баримталж байгаа бодлого чиглэл бол бид томоохон хэрэгжиж байгаа мега төслүүд болон шаардлагатай тохиолдолд Төсвийн байнгын хорооноос сэдвийг нь батлаад өгөх юм бол

урьдчилсан буюу зэрэгцээ аудитыг хийгээд тухай бүрд нь алдаа зөрчлийг нь илрүүлээд засаад явбал... /минут дуусав/

Г.Тэмүүлэн: 6 номер. Ж.Дэлгэржаргал.

Ж.Дэлгэржаргал: Д.Ганбат гишүүний асуултад хариулъя. Сангийн яам. Ж.Дэлгэржаргал.

Гадаад зээлд нэгэнт гэрээ хэлэлцээр нь байгуулагдсан төслүүддээ хэрэгжүүлэх дээр сүүлийн 2 жил Сангийн яамнаас нэгдүгээрт, хэмнэлт хийх.

Хоёрдугаарт, техник үйл ажиллагаануудыг бууруулах. Тухайн төслийн бүтэц дотор нь зөвлөх үйлчилгээ, судалгаа, сургалт гээд урсгал зардлын шинж чанартай ажлуудыг бүхэлд нь хойшлуулах, зогсоох ийм арга хэмжээнүүд хийж байгаа.

Тэгээд илүү яг тухайн төслийн хүрээнд эцсийн яг ямар үр дүн гарах тэр ажлыг нь илүү чиглүүлэх дээр донорууд болон хөгжлийн санхүүжилтийн байгууллагуудтайгаа бид хэлэлцээр хийгээд, энэ жилийн хувьд 173.0 тэрбумыг яг ийм зардлуудаас гаргаж аваад, одоо 14 мега төслийн 2-т нь байгаа, 2 нь явж байгаа газрын тос, Эрдэнэбүрэн дээр хуваарилах ийм зохицуулалтуудыг хийсэн.

Ирэх онуудад ч гэсэн яг энэ ажлуудыг хийгээд явж байгаа.

Дээрээс нь гадаад зээлийн төслүүд дээр нэг онцлог нь улирал тутам тухайн донор байгууллагуудаас ажлын хэсэг ирээд хяналтууд хийгдээд энэ төсөл дээр ямар алдаа дутагдлууд байна, хэрэгжилт дээр юун дээр анхаарах вэ гэдэг дээрээ зөвлөмж өгөөд хэрэгжилтийг нь хангаад явдаг.

Г.Тэмүүлэн: Х.Жангабыл гишүүн асуулт асууна.

Х.Жангабыл: Та бүхэнд өдрийн мэндийг хүргэе.

Засгийн газрын өрийн удирдлага, гадаад зээл, нөхцөл байдлын талаар танилцуулга дээр бичигдсэн байна. Бид Улсын Их Хурлаас соёрхон баталсан одоогийн байдлаар Засгийн газрын хэрэгжүүлж байгаа 17.9 их наяд төгрөгөөс 5.3 их наяд төгрөгийг л ашиглаж байгаа.

Үлдсэн 12.6 их наяд төгрөгийг одоогоор ашиглагдаагүй байна гээд. Энэ бол их хортой л доо. Ашиглаагүй мөртлөө хүү төлдөг. Хавар бас хэдэн гишүүн энэ талаар нэг хууль санаачлах гээд явж байгаад чимээгүй болсон.

Тэгэхээр миний асуулт болбол ер нь энэ тал дээр арга хэмжээ авч байгаа юу? Зээлээ бид соёрхон батлаад сайхан бэлдээд өгдөг. 100 хувь ашиглаж

чаддаггүй. Үүнийг төсвийн реформ хийх замаар ч юм уу, ер нь Сангийн сайдын авч байгаа арга хэмжээ байна уу? Нэгдүгээр асуулт.

Хоёрдугаарт, Баян-Өлгий аймагт тухайлбал гадаад зээл, тусламжаар 2025 онд хэрэгжиж байгаа төслүүд байна уу?

Гуравдугаар асуулт. Түрүүн Оюу Толгойн талаар яригдаж байна. Сүүлийн үед Үндэсний баялгийн сангийн Ирээдүйн өв санд байгаа 1.2 тэрбум долларын талаар яригдаад байна. Гадаадын нэг банканд аваачаад 3 хувийн хүүтэй жилийн хатгалуулсан гээд. Үүнийг арвижуулах хууль дээр заасан байгаа шүү дээ. Өдөр болгон өндөр хүүтэй хадгалуулах ч юм уу, олон улсын зах зээл дээр үнэт цаас гаргах ч юм уу.

Тэгэхээр надад нэг санаа байгаа юм. Оюу Толгой чинь 11.1 хувийн жилийн тийм хүүтэй манай улсад зээл аваад өгөөд байгаа юм байна шүү дээ. Тэд нарт өгөөд 11.1 хувийн тийм хүүтэй тэд нараас зээл аваад тэнд тийм зохион байгуулалт хийж болохгүй юу.

Тэгвэл үүний зөрүүнөөс миний тооцсоноор 300.0 тэрбум төгрөгийн орлого тал дээр бичигдэх бүрэн бололцоо гараад байна шүү дээ. Түүгээрээ хэл ам болоод байгаа багш нарын цалин, энэ тэтгэвэр, тэтгэмжийг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлэх бололцоо байна шүү дээ. Бид зөндөө л юм яриад байна.

Өрийн удирдлагын тухай хуулийн янз бүрийн тусгай шаардлагыг хангахгүй байна, энэ тэрээ гээд. Тэрнийг зохицуулъя гэхээр орлого байхгүй гээд... /минут дуусав/

Г.Тэмүүлэн: 7 номер. Сангийн сайд.

Б.Жавхлан: Х.Жангабыл гишүүний асуултад хариулъя.

Ямар ч байсан бид гадаад талдаа зээлжих зэрэглэлээ нэмэгдүүлж чадсан. Энд нөлөөлсөн бас нэг том хүчин зүйл, параметр бол энэ Ирээдүй өв сан байгаа юм шүү.

Ирээдүй өв сан 2021 онд зөвхөн хуулган дээр байсан. Төрийн сангийн хуулган дээр 1.3 их наяд. Эх үүсвэр, мөнгөн хөрөнгө нь Төрийн санд ороод эргэлдээд явж байсан.

Үүнийг бид 2023 оноос шат дараатай бэлэн мөнгөжүүлээд, 2024 оны эцэс гэхэд 100 хувь бэлэн мөнгөжүүлсэн.

Ингээд бид ирээдүйдээ 1.3 тэрбум долларын Ирээдүй санг бэлэн мөнгөөр нь хадгалуулж өгч байгаа юм. Тэгээд ямар ч байсан олон улсын өмнө энэ

дансыг дүүрэн болгоод бид валютын гадаад нөөцдөө оруулж тооцдог хэмжээнд болгосон.

Одоо үүнийгээ хамгийн найдвартай Франц, Англи, Люксембургийн төв банканд 4.3-аас 4.6 хувийн хүүтэй. Энэ жил гэхэд 96.0 тэрбум төгрөгийн өгөөж аваад байгаа. 96.0 тэрбум бол бага мөнгө биш.

Олон хүмүүс хэлж байгаа. Үүнийг өндөр өгөөжтэй хувьцаа ч гэдэг юм уу, өөр хөрөнгө оруулалтад хий гээд. Тэгэх юм бол энэ 1.3 тэрбум доллар чинь манай нөөцөөс гараад явна. Нөөцөд тооцогдохгүй. Ингээд буцаад бид зээлжих зэрэглэлээ унагана.

Зээлжих зэрэглэл унана гэдэг чинь манай бүх өртгүүд нэмэгдэнэ. Хувийн хэвшлийнхний хөрөнгө оруулалтын хувийн CORPORATE BOND-үүдийн бүх өртөг нэмэгдэнэ. Гадаад зах зээл дээр манай боломжууд муудаад, дахиад л буцаад уруудаад л хумигдана.

12 жилийн дараа арайхийж олж авсан энэ боломжуудаа дахиж алдаад, магадгүй 12-оос урт жил ч бид буцаад энэ нүхнээсээ гарч чадахгүй байж магадгүй.

Тийм учраас энэ дээр хэдүүлээ алдаа гаргаж дахиж хэрхэвч болохгүй.

Ер нь таны ярьж байгаа тэр өгөөж Монгол Улсын валютын нөөцийн хэмжээ хоёр яг урвуу хамааралтай байдаг. Нөөцөө нэмэгдүүлээд найдвартай байлга гэвэл тэр хэмжээгээр өгөөж багасаж ирнэ. Хэрвээ өгөөжөө нэмэгдүүлье гэх юм бол нөөц маань эрсдэлд орж эхэлнэ. Дэлхий дээр байгаа, энэ ертөнц дээр байгаа валютын нөөцийн өөр онол, өөр хэрэгжилт гэж байхгүй.

Тэгэхээр бид нэгдүгээрт, Монгол Улсын валютын нөөцийг найдвартай л байлгах ёстой. Найдвартай байлгаж чадаж байвал найдвартай бага ч гэлтгүй өгөөж аваад явж байх нь л бид нарын хамгийн чухал тогтвортой бодлого байх ёстой гэж манай үндсэн чиглэлд байгаа.

Гадаад зээлийн ашиглалт дээр би түрүүн хэллээ. Ер нь цаашдаа бид хоёр л арга зам байна. Ерөөсөө дахиж нэг төгрөгийн ч зээл авахаа больё.

Тийм учраас нэмж ачаалал ирэхгүйгээр жил бүр 20 хувийн ашиглалт дотроо байгаа нэгэнт гэрээлсэн зээлүүдээ ашиглаад 5 жил явъя. Тэгж байж нэлээн шингэрэх байх.

Эсвэл бид ACCRUAL суурь луугаа тодорхой хэмжээнд шилжих хэрэгтэй. Би тодорхой хэмжээнд тэгж байгаа юм шүү. Өөрөөр хэлбэл тодорхой хэмжээнд гэдэг нь тодорхой өндөр үр өгөөжтэй төслүүдийг Их Хурлаар шалгууртай нь оруулаад, тэр нь болж байна гэх юм бол үүнийгээ ACCRUAL суурьтайгаар

төсвийн бодлого дотроо төсвийнхөө хууль дотроо тусгаад явдаг болъё. Тэгэх юм бол зээлийн ашиглалт арай өндөр болж ирнэ. ACCRUAL суурьтай гэдэг маань өгөөжтэй зээлийг зээлийнх нь эх үүсвэрээр нь тодорхой хэмжээнд ашиглалтаа орж ирж байвал тэрийгээ хоёр талдаа зэрэг бичдэг. Валютынхаа энэ орж ирж байгаа эх үүсвэрийн орлого талд нь ашиглалтаа зардал талдаа бичээд явдаг. Өөрөөр хэлбэл алдагдал нэмэгдэхгүйгээр. Гэхдээ нийт гадаад зээлийнхээ Засгийн газрын өрийнхөө хэмжээн дотор хязгаар дотроо оруулж тооцоод явдаг.

Иймэрхүү байдлаар ч юм уу ийм богино, урт, дунд хугацааны хувилбарууд байна.

Тэгээд бид удахгүй энэ намартаа багтааж ямар ч байсан Их Хуралтай мөн зөвшилцөж. Гол нь Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороон дээр л зөвшилцөнө.

Г.Тэмүүлэн: Ж.Дэлгэржаргал нэмж хариулъя. 6 номер.

Ж.Дэлгэржаргал: 2025 онд хэрэгжиж байгаа ирэх онуудад хэрэгжих төсөл дээр Баян-Өлгий аймагт 3 төсөл явж байна.

Нэгдүгээрт, нь Польшийн нэн хөнгөлөлттэй зээлээр аймгийн төвийн бохир усны цэвэрлэх байгууламж 14.2 тэрбум төгрөгөөр энэ онд ашиглалтад орно. Эдийн засгийн хөгжлийн яаман дээр аймаг, сумын хөтөлбөр гээд 10 жилийн хугацаатай 735.0 сая ам.долларын төсөл өнгөрсөн онд эхэлсэн.

Энэ төслийн хүрээнд Баян-Өлгий аймгийн 14 сумд дэд бүтцүүд, зарим чиглэл нь боловсролын салбар, зарим нь Хөдөө аж ахуйн салбарт хэрэгжих төсөл хэрэгжиж эхэлнэ.

Мөн Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр Хөдөө аж ахуйн яаман дээр усалгаатай газар тариалан гээд төсөл хэрэгжиж байгаа. Энэ хүрээнд Баян-Өлгий аймгийн газар тариалан хөгжсөн сумдад дээр 616 га талбайд услалтын систем байгуулах төсөл хэрэгжиж байна.

Г.Тэмүүлэн: Болсон уу? Х.Жангабыл гишүүний асуулт асууж дууслаа.

Би нэг хэд хэдэн асуудлаар тодруулж асуух зүйлүүд байгаа.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороогоор гадаад зээл, тусламж, гэрээ хэлэлцээрүүд орж батлагддаг. Үүнтэй холбоотойгоор Байнгын хорооны гишүүдийн зүгээс хүсэлт гаргаж, өнөөгийн гадаад зээл, тусламжийн нөхцөл байдалтай холбоотой, хэрэгжилттэй холбоотой мэдээллийг ер нь томхон зургаар нь нэг сонсъё гэдэг хүсэлтийг тавьсан байгаа. Энэ дагуу өнөөдөр бид мэдээллийг сонсож байна.

Үүнтэй холбогдуулаад би нэг хэд хэдэн асуух асуудал нөхцөл байдал бид нарт гадаад өр зээлтэй холбоотой хүндрэл бэрхшээлүүд байна гэдэг асуудал яригдаад байгаа юм.

Тэгэхээр энэ өөрөө юу вэ гэхээр Та бүхний ирүүлсэн, бид ч гэсэн бас дэлгэрэнгүй мэдээллүүдийг Сангийн яамнаас ирүүлсэн байна. Энэ дотроос аваад үзэхээр жилийн жилд л ерөөсөө нийт өрийн үйлчилгээ маань нэмэгдээд байна.

Тэгэхээр бид бүхний хувьд энэ бол дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээ нь ч нэмэгдэж байна. Мөн дээрээс нь төсөвт ачаалал болж байгаа, дарамт болж байгаа өрийн үйлчилгээний зардал ч өөрөө нэмэгдэж байгаа гэдэг асуудал байгаа.

Тэгэхээр энэ дээр манай Тогтвортой байдлын зөвлөл ч яг эрсдэлтэй нөхцөл байдал, эргэн төлөлттэй холбоотой, тухайн тэр төсөв, санхүүгийн эрсдэлтэй төсөвт дарамт үзүүлэх нөлөөлөл, өрийн эрсдэл хүнд байна гэдэг асуудлыг гаргаж ирж сая тавьсан байна лээ. Тогтвортой зөвлөлөөс гаргасан.

Аудитаас ч гэсэн гаргасан 2023-2025 оны Засгийн газрын өрийн удирдлагын стратегийн баримт бичгийн хэрэгжилт дээр хийсэн аудитын тайлан дээр бас мөн санхүүжилтийн эрсдэл буюу эргэн төлөлтийн асуудлууд нэлээн хүндрэлтэй байна гэдэг асуудлыг тавьж байгаа.

Тэгэхээр энэ дээр бид ер нь нөхцөл байдал ер нь ямар байна вэ? Үүнийг сонсьё гэдэг асуудал байгаа юм л даа. Тэгээд үндсэндээ би зүгээр тоон мэдээллүүдийг аваад, сая Та бүхнээс ч гэсэн танилцуулсан. Бид бүхэнд Байнгын хорооны гишүүдийн ирүүлсэн мэдээллээс аваад үзэхээр үндсэндээ 2016-2026 оны хооронд улсын төсвөөс хийсэн нийт өрийн үйлчилгээний зардал 30.3 их наяд төгрөг болоод байгаа юм. 30.3 их наяд төгрөг.

Тухайн үед бид нарын улсын төсвийн зардал маань 10, 15 их наяд байсан. Одоо 32 их наяд төгрөг. Ингээд ирэх жилүүдэд яах нь вэ гээд аваад үзэхээр 2024 онд дахиад 3 их наяд. Ингээд 2024, 2025, 2026 оныхыг нийлүүлээд аваад үзэхээр 9.5 их наяд төгрөг болоод байгаа байхгүй юу.

Тэгэхээр үндсэндээ бид 3 жилд нийт төсвийнхөө гурваныхаа нэгийг зарцуулж байна гэдэг ийм дүр зураг гарч ирээд байгаа юм. Энэ дээр бид өрийн зөв удирдлага, менежмент хийхгүй бол бас болохгүй болоод байгаа юм биш үү. Жилээс жилд хуучин төсөвт үзүүлдэг өрийн үйлчилгээний зардал өөрөө харьцангуй бага байсан бол одоо бараг 10 хувьд хүрэх хэмжээний ийм ачаалал дарамт болоод байна.

2026 онд нэрлэсэн үнээр 51.2 их наяд төгрөг буюу үндсэндээ дотоодынхоо нийт бүтээгдэхүүнд харьцуулаад аваад үзэх юм бол 43.8 хувийг гадаад өр, зээлийн асуудал эзлэх гээд байна гэдэг асуудал гарч ирээд байгаа юм.

Тэгэхээр би энэ дээр төсвийн хүрээний мэдэгдэл дээрээс ч гэсэн аваад үзэхээр 2026 онд 51.8 их наяд, 2028 онд 59.5 их наяд төгрөг гээд нэмэгдээд явах эрсдэлүүд байгаа. Өр, зээл нэмэгдэхийн хэрээр дахиад нөгөө өрийн үйлчилгээний зардал өөрөө нэмэгдээд, ингээд төсөв дээр үзүүлэх дарамт, ачаалал нэмэгдэх энэ бодит хүчин зүйл байна гэдэг энэ зүйлийг ер нь та хэд маань яг яаж харж, төсөв дээр юу гэдэг юм 10 хувь үндсэндээ бид бүхэн магадгүй өөр бусад салбаруудад, нийгмийн салбаруудад, боловсрол, эрүүл мэнддээ зарцуулж байх зардал маань энэ байдлаар гараад байвал нэг талдаа харамсалтай байна гэдэг зүйлийг хэлэх гээд байгаа юм.

Тэгэхээр бид энэ төсөл, хөтөлбөрүүд эдийн засгийн үр ашгийг нарийвчилж тооцож, эргэж оруулж ирдэг байх гэдэг юм уу, энэ дээр тодорхой хэмжээний үнэлгээ дүгнэлтүүдийг хийдэг байх шаардлага байна гэж үзээд байгаа юм.

Асуух асуулттай холбогдуулаад дахиад нэг зүйл нь 2017-2024 оны хооронд Засгийн газар өрийн баталгаа гаргаж байгаагүй. Засгийн газрын өр дотор эзлэх хувь хэмжээ дотор бусад өр буюу бонд өрийн баталгаа нэмэгдэж байна. 2017-2024 онд Засгийн газрын өрийн баталгаа гаргаж байгаагүй. 2024 оноос хойш яагаад өрийн баталгаа гаргах асуудлууд дээр тавьсан юм бэ?

Тэгэхээр бид нарын хувьд санаа зовж байгаа зүйл эдийн засгийн бодит эрсдэлээс сэргийлэхээс сэргийлэх үүднээс, эдийн засгийнх нь тогтвортой байдлыг хангах үүднээс, төсөв, санхүүгийн тогтвортой байдал, өрийн удирдлагын зөв менежмент хэрэгжүүлэх үүднээс тодруулж байгаа, асууж байгаа мэдээллүүдийг авах гэж оролдож байгаа зүйлүүд байна гэдэг зүйл байгаа.

Энэ дээр та хэд маань тодорхой байр сууриа илэрхийлээд яваач ээ гэдэг зүйлийг хэлэх гэсэн юм.

Аудитын дүгнэлт дээр бас яг саяын өрийн үйлчилгээтэй холбоотой дүгнэлт хийсэн байгаа юм. Зургаа дээр нь Засгийн газраас 2025-2028 онд төлөх өрийн үйлчилгээний зардалд нийт 16.4 тэрбум төлөх байгаагаас үндсэн төлбөр нь 12.1 их наяд байгаа нь дахин санхүүжилт эрсдэл хэвээр байгааг хүүгийн төлбөр 4.2 их наяд төгрөг байгаа нь дунд хугацаанд төсөвт үргэлжлүүлэн ачаалал, дарамт, хүндрэл учруулахаар байгааг тус тус харуулж байна гэсэн ийм зүйл байгаа. Үүнтэй та хэд маань ер нь ямар байр суурьтай байна? Энэ дээр нэг тайлбар мэдээлэл өгөөч. 8 номер.

С.Тулга: С.Тулга. Сангийн яам. Г.Тэмүүлэн гишүүний асуултад хариулъя.

Өрийн үйлчилгээ гэдэг дээр хүүгийн төлбөр болон үндсэн төлбөр хамт байгаа.

Хүүгийн төлбөрийн хувьд энэ нэмэгдээд байгаа зүйл байхгүй байгаа. 2017 онд бид хүүгийн төлбөрт 1 их наяд 156.0 тэрбум төлдөг байсан бол 2024 онд 1 их наяд 165.0 тэрбум төгрөг төлж байгаа.

2025 онд энэ 1 их наяд 290.0. Ингээд цаашаа 1.3 их наяд дотор 28 хүртэл явах юм байна.

Юу нэмэгдэж байгаа вэ гэхээр үндсэн төлбөр нэмэгдэж байгаа. Үндсэн төлбөр яагаад нэмэгдэж байгаа гэхээр бид өмнө гаргасан гадаад бондын бүрэн санхүүжүүлэхгүй тодорхой хэмжээнд үүнийг буулгаж, тодорхой хэмжээнд үнэтэй гадаад бондынхоо хэмжээг буулгана гэдэг энэ агуулгаар үндсэн төлбөрийн тодорхой хэмжээг бид жил болгон төсвөөсөө төлөөд явж байгаа.

Тухайлбал, ирэх онд бид 3 сард “Номад” бондын үлдэгдэл 176.0 сая ам.долларыг бид төлөөд энэ хэмжээгээр манай үнэтэй эх үүсвэр буюу гадаад бондын хэмжээ буурна.

Энэ дүнгээр үндсэн төлбөр ерөнхийдөө нэмэгдээд явж байгаа. Түүнээс яг хүүгийн зардлаар 2017 оноос хойш ингэж аймаар сүртэй нэмэгдээд байгаа юм бас байхгүй байгаа.

Баталгааны хувьд яг одоогийн байгаа гүйцэтгэлээр Хөгжлийн банкны Чойбалсангийн цахилгаан станцад гаргасан 50 сая ам.долларын баталгааны үлдэгдэлтэй л байгаа. Гүйцэтгэлээр.

Энэ дээр 2023-2025 оны өрийн удирдлагын стратеги дээр томоохон эдийн засагт үр нөлөөтэй төслүүд дээр Засгийн газар баталгаа гарга гэж Их Хурлаас баталсан баримт бичигт заасны дагуу бид Өрийн удирдлагын хууль дээр заасан шалгуур хангасан Монгол Улсад байгуулагдсан аж ахуйн нэгжид баталгаа гаргах боломжтой.

Баталгаан дээр дээд хэмжээг бид төсвөө батлуулах үед Их Хурлаас зөвшөөрөл авдаг. Зөвшөөрөл авсных нь дараа тухайн төсөл болгон дээр Их Хурлаас дахиж орж ирж зөвшөөрөл авч. Ингэсний дараа Засгийн газар тухайн аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан Засгийн газрын баталгааг олгодог байгаа.

Баталгааны гүйцэтгэл маань зээлийн ашиглалттайгаа шууд уялдаж гардаг учраас яг төсөөлөөд байгаа 1 тэрбум долларын баталгаа гэдэг маань яг гүйцэтгэлээр ингэж гарах албагүй байгаа.

Баталгаа гаргагч болон төсөл 2 дээр Өрийн удирдлагын хууль дээр тус тусад нь шалгуур байж байдаг. Тэгээд энэ шалгуурыг хангасан дотоодын аж ахуйн нэгжид баталгаа гаргах асуудлыг хүсэлт ирүүлбэл Засгийн газар судалж үздэг асуудал байгаа.

Г.Тэмүүлэн: С.Тулга аа, ийм зүйл байгаа шүү дээ. Би бодит тоо хэлээд л байгаа зүйл.

→ 2025 онд өрийн үйлчилгээний зардал 2.8 их наяд төгрөг.

→ 2026 онд 3.7 их наяд болох гээд байгаа.

Бид төсөв оруулж ирж байгаагаар 32 их наядын зарлагатай байхаар орж ирж байгаа.

Гэтэл нийт төсвийнхөө зардлын 10 хувиас дээш хэтэрсэн Засгийн газрын өр үйлчилгээ буюу хүүгийн зардал төлөх гээд байна. Энэ дотор чинь л үндсэн зээлийн төлбөр болоод бондын үндсэн өр, бондын хүүгийн төлбөр, зээлийн хүүгийн төлбөр гээд аваад үзэх юм нийлээд ийм болоод байгаа юм.

Тэгэхээр зөвхөн бонд, зээлийн хүүгийн төлбөр чинь өөрөө 1.2 их наяд төгрөг буюу буцаагаад юу гэдэг юм, зөвхөн би зүгээр энэ дээр нь тооцоод үзэхэд энгийнээр энэ чинь өөрөө том дүн шүү дээ. Бид хуучин нийт өрийн үйлчилгээний зардал бараг 1.2 их наяд л багтдаг байсан зүйл маань 2, 3 дахин нэмэгдээд байгаа зүйл байна.

Зүгээр энгийнээр шилжүүлээд үзэх юм бол 1.2 наядыг чинь 365 хоногтоо хуваагаад үзэх юм бол бараг 3.4 тэрбум төгрөг буюу нэг цэцэрлэгийн мөнгийг бид бараг өдөрт өрийн үйлчилгээний төлбөр төлөөд байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ өөрөө буруу байна л гэдэг асуудал дээр бид бодит дүгнэлт хийх хэрэгтэй байгаа юм.

Тэгэхээр ийм нөхцөл байдалд бид тодорхой хэмжээнд өрийн удирдлагын зөв менежмент хийгээд, кардан татаад, төсвийнхөө сахилга батыг бариад явах нь зарчмын хувьд урт хугацаандаа болоод дунд хугацаандаа зөв юм шүү. Тэгэхгүй бол бид нарын хувьд магадгүй юу гэдэг юм энэ 10, 12 хувьд ирж байгаа юм чинь 15, 16 хувь руу хүрвэл яах вэ гэсэн нэг ийм болгоомжлол байгаа.

Түрүүн өрийн баталгаа уг нь 2017-2024 оны хооронд бид Төсвийн байнгын хороо орж ирэхэд Сангийн яам болоод Засгийн газар ямар нэг өрийн баталгаа гаргахгүй гэдэг бодлогыг баримталдаг байсан юм. Тэгээд дахиад нөхцөл байдал өрийн баталгаа гаргадаг бодлого эхэлсэн байгаа.

Тэгэхээр бодлого яагаад өөрчлөгдөв. Нөхцөл байдал тэгж их мундаг сайжирсан юм уу, яасан юм бэ гэдэг асуудал байгаа.

Хоёрдугаарт нь, бид төрийн өмчит компаниуд болоод орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдээр үүссэн өр, зээл, авлага, орон нутаг дээр үүссэн өр, зээл, авлагууд дээр дүн шинжилгээ хийж чадаж байна уу?

Яг өнгөрсөн онд төсөв батлахад бид 2025 оны нэгдүгээр улиралд багтаагаад энэ дүн шинжилгээ хийгээд тайланг нь танилцуулаач ээ гээд байгаа юм. Одоо энэ төрийн өмчийн компаниуд дээр чинь өр нь ямар хэмжээний өр зээл, орон нутаг дээр өр нь ямар хэмжээний өр зээл үүсээд байгаа юм бэ, энэ чинь нөхцөл байдал хэр байна вэ гэдэг асуудал байгаа юм.

Оюу Толгойтой холбоотой асуудал мэдээж яах вэ энэ улсын төсөв дээр дарамт болохгүй. Оюу Толгой компаниас төлөгдөх асуудал. Гэтэл эсрэгээрээ төрийн өмчийн компаниуд буюу яг цэвэр 100 хувь гэдэг юм уу, 50-иас дээш хувийн Монголын төрийн оролцоотой компаниудын өр зээлийн асуудлууд бид нарт хүндрэл үүснэ л дээ.

Тэгэхээр энэ дээр та хэд дүгнэлт, шинжилгээ хийж чадаж байна уу, үгүй юу? Зүнийг нэг хараач ээ. Одоо өр нь дахиад бид хэрэв зээл, тусламж, дэмжлэг авах юм үр ашгийн эрэмбийг нь хэрэглэж харддаг байх, дахиад юу гэдэг юм хэрэгцээгүй томоохон төсөл гэдэг юм уу, төсөв дээр ачаалал дарамт болохгүй байх зүйлүүд дээр анхаарах шаардлага байна. Энэ дээр нэг мэдээлэл өгөөч гэдэг зүйлийг хэлэх гэж байгаа юм.

Сангийн сайд Б.Жавхлан. 7 номер.

Б.Жавхлан: Г.Тэмүүлэн даргатай санал нийлж байна.

Бид өр нь 90 оноос хойш 34, 35 жил гадаад зээлийн өр бодлого дээрээ одоо нэг update хийгээд урагшаа явах ийм цаг үе нь ирж байна.

Яагаад гэхээр цаашаагаа дотоодын нийт бүтээгдэхүүн маань энэ өсөлт бол нэг саарахгүй. Саарахгүй. Цаашаагаа нэмэгдэхийн хэрээр одоо байгаа төсвийн дүрмээр манай гадаад зээлийн ашиглаагүй нөөц орон зай улам тэлээд явна. Тэрийгээ бид ашиглаж чадахгүй. Уг нь мөчлөг сөрсөн бодлого гэхээр бид үүнийгээ аягүй зөв ашиглаад явах хэрэгтэй.

Нэгдүгээрт, үүнийг том зургаар харах хэрэгтэй.

Хоёрдугаарт, одоо яг зээлийн ашиглалтаа кардан татаад нэг хэсэгтээ одоо байгаа төслүүдээ явуулах уу, үгүй юу. Бас үүнийг харах өнцөг. Нөгөө талаар зээлийн ашиглалтын үр өгөөжийг нь сайжруулах хамгийн том зорилго одоо эхэлсэн байгаа төслүүдээ яаралтай дуусгах ёстой... /минут дуусав/

Г.Тэмүүлэн: Сангийн сайд. 7 номер нэмж гүйцээж хариулъя.

Б.Жавхлан: 5 минут өгвөл. Одоо жишээ нь нефть боловсруулах үйлдвэрийг бид 2027 он, 2028 он гэхэд хугацаанд нь дуусгах хэрэгтэй.

Тэгээд жил бүр бид 2 тэрбум доллароо авч үлддэг болох юм бол одоо үүнээс илүү үр өгөөж гэж юу байх вэ. Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцыг яаралтай оруулах хэрэгтэй. Улаанбаатарын хэрэгжиж байгаа энэ хэдэн төслүүдийг яаралтай оруулах хэрэгтэй.

Тэгэх юм бол энэ чинь өгөөж нь эргээд ороод ирэхээр төсөв дээрх дарамт нь хамаагүй багасаад явна.

Дээрээс нь би нэг бүртгэлийн асуудал хэлье.

2024 онд бид яг энэ ирээдүйд учирч болзошгүй гадаад өрийн менежментийг зөөлрүүлэх, төсөв зэрэг дарамтыг нь бууруулах зорилгоор жил бүр дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ 2 хувьтай тэнцэх нөөцийг тусад нь гадаад өрийнхөө төлбөрт зориулж авч үлддэг дүрэмтэй болсон. Үүнийг гишүүд маань их нарийн түвэгтэй тийм бүртгэлийн асуудал учраас сайн хүлээж авахгүй байх шиг байгаа юм. Яах вэ, тэр ч албагүй л дээ. Гэхдээ... /минут дуусав/

Г.Тэмүүлэн: Нэмээд гүйцээж хариулъя. Сангийн сайд.

Б.Жавхлан: Манай оператор болдог надад 5 минут өгчхөөрэй.

Суурь тэнцэл буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувьтай тэнцэх нэмэх тэнцэлтэй байна гээд. Өөрөөр хэлбэл татвараар бүрдэж байгаа төсвийн орлогоороо бүх цалин, тэтгэвэр, тэтгэмж, хүүхдийн мөнгөө тавьж дуусаад цаана нь 2 хувьтай тэнцэх нэмэх нөөцтэй гараад, түүгээрээ тухайн жилийнхээ хуримтлагдсан төлөх ёстой зээлийн хүү, үндсэн өрөө төлөөд явах ёстой шүү гэдэг ийм хуультай болсон.

Тэгэхээр таны ярьж байгаа жил бүр нэмэгдэж байгаа зээлийн өрийн үйлчилгээний зардал маань энэ хэмжээгээрээ бүрэн төлөгдөөд, нөхөгдөөд яваад байх боломжтой болж ирсэн гэсэн үг. Өөрөөр хэлбэл тэр хэмжээгээр бид төсөв дээр авах ачааллаа яг төсвийн тусгай шаардлагын хуулиараа багасгаад байгаа юм.

Тэгэхээр одоо ойрын хугацааны хамгийн том зорилго бол энэ зээлүүдээ бушуухан ашиглалтад оруулж үр өгөөждөө хүрэх л бид нарын хамгийн том зорилго байгаа.

Бүртгэлийн хувьд бид дараагийн олон улсын систем, олон улсын практикууд ямар байна тэр систем рүү бид шилжих хэрэгтэй. Одоо хэсэгчлэн

яаралтай ACCRUAL¹ суурьтай шилжих үү. Эсвэл GFS² /Government Finance Statistics/ рүүгээ шилжих үү гээд ийм бодлогын шилжилтүүдийг бид Засгийн газраас ойрын хугацаанд танилцуулна гэж ингэж харж байгаа.

Орон нутгийн өрийн зохицуулалтыг Улсын Их Хурал дээрээс санаачилж нэмж хийсэн ийм зохицуулалтууд шүү. Ийм зохицуулалтууд орж ирсэн байгаа.

Энэ дээр үе үеийн Сангийн яам маш их болгоомжтой, энэ дээр нэлээн бюрократ гэж шүүмжлүүлж ирсэн байгаа. Бид аль болох л нэгдсэн өрийн удирдлагаар явахыг хичээдэг. Гэсэн хэдий ч Улаанбаатар нийслэл хотоос эхлээд, хойтон Өмнөговь аймгаас эхлээд шинээр бид аймгуудын, орон нутгийн ийм өрийн түүх эхлэх гэж байна.

Өмнөговийг жишээ нь бид сүүлийн 2 жил бэлдлээ. 2 жил бэлдээд ирэх жилээс цахилгаан станцыг өөрсдийн бонд гаргаж шийдэхээр болж ирж байна.

Тэгэхээр энэ дээр аль болох хамгийн бага эрсдэлтэйгээр тооцож. Одоо хөдөө орон нутгаас анхны аймаг гараандаа гарах гэж байна. Нийслэл Улаанбаатар хот бол гараанаасаа гарсан.

Эхний бондоо амжилттай гаргасан.

- ▶ Бонд гаргах амжилт нэг хэрэг.
- ▶ Тэрийг ашиглах дараагийн хэрэг.
- ▶ Ашиглалтад оруулаад өгөөжийг нь хүртэх дараагийн хэрэг байгаа.

Ингээд яг бондын явц яг явж байна.

Төрийн өмчит компаниудын өр. Харин тийм ээ. Энэ төрийн өмчит компаниудын өрийг Монгол Улсын өрөнд тооцдог. Засгийн газрын өрөнд тооцдоггүй. 2012 оноос хойш ингээд яваад ирсэн юм билээ. Үүнийг одоо шууд огцом Засгийн газрын өрөнд оруулна гэвэл бид дийлэхгүй.

Тэгэхээр үүнийг харин нэгдсэн эрсдэлийнхээ бодлого, систем дотроо оруулж, үүнийг гол нь мөн л яг оновчтой өгөөжтэй ийм хөрөнгө оруулалт дээр чиглүүлэх энэ нарийн хяналт, энэ юмнуудаа л Засгийн газар, Улсын Их Хурал хяналтаа сайн тавьж, гол нь өгөөжид нь л яаралтай хүргэх л бодлого дээрээ явна даа.

Г.Тэмүүлэн: Энэ дээр бид өрийн удирдлагын тухай хуулиар 2023 онд Төсвийн тухай хууль дээр оруулсан өөрчлөлтийн хүрээнд зээл, тусламжийн үр өгөөж, үр ашгийг эрэмбэлж, яг үр ашигтай салбарт хөрөнгө оруулалт хийдэг

¹ Нягтлан бодох бүртгэлийн бодит гүйлгээн дээр үндэслэсэн бүртгэлийн арга.

² Төсвийн статистикийн олон улсын стандарт, IMF-ийн гаргасан нэгдсэн аргачлал.

байх үүднээс нэг талдаа зээлийн ил тод, нээлттэй байдлыг хангах асуудлыг гаргаж ирж тавьж байсан.

Тэгэхээр энэ дээр нэг талдаа шинээр зээл авах бол, шинэ зээлийн хэлэлцээр орж ирж байгаа бол нийт зээлийн хэмжээ эргэн төлөх хуваарь, хүү, зээлийн зориулалт зэрэг нэгтгэсэн мэдээллийг нийтэд мэдээлдэг байна гэдэг хуулийн зохицуулалт орж ирсэн байгаа.

Энэ заалт маань ер нь хэр хэрэгжиж байгаа юм бэ? Энэ заалт.

Дээрээс нь ер нь яг жишээ нь шинээр оруулж ирж байгаа зээлүүдийнхээ үр нөлөөгөөр нь эрэмбэлэх аргачлал байна уу, эсвэл юу гэдэг юм эдийн засаг, тооцоо судалгаа, шинжилгээг нь хийж чадаж байна уу? Энэ Эдийн засаг, хөгжлийн яаман дээрээ байна уу, Сангийн яаман дээр байна уу?

Нөгөө талдаа өрийн удирдлагын баталгаа гаргаж байгаа зээл, тусламжаар хэрэгжиж байгаа энэ төслүүд дээр эрсдэлийн үнэлгээ хийж чадаж байна уу, үгүй юу? Одоо яг энэ эрсдэлийн үнэлгээний зохицуулалтыг хууль журамдаа тусгаагүй байдаг. Тэгээд олон улсын байгууллагууд болохоор энэ зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна гэдэг асуудлыг тавиад байдаг. Тэгээд Монгол Улс нэг талдаа юу гэдэг юм эрсдэлийн үнэлгээ энэ хэрэгжиж байгаа зээл, тусламжууд дээр хэрэгжихгүй байна гэдэг асуудлыг гаргаж тавиад байгаа юм.

Тэгэхээр бид үндсэндээ энэ шалгуур үзүүлэлт болоод эдийн засгийн тооцоо судалгаа, шинжилгээг ч гэсэн яг энэ зээл, тусламжийнхаа асуудал дээр нарийвчилж хийдэг байх ёстой л гэдэг асуудлыг ярих гээд байгаа юм.

Та хэд маань үндсэндээ энд 96 төслийн мэдээллийг манай Байнгын хорооны гишүүд ирүүлсэн байгаа. Аваад үзэхээр үндсэндээ 20 их наяд төгрөгийн зээл, тусламжийн асуудал орж ирээд мэдээллүүд нь явж байна гэдэг мэдээллийг өгөх ёстой.

Гэтэл энэ дотроос чинь эхнээсээ фэйлдээд, магадгүй эрсдэлийн үнэлгээ хийгээгүйгээсээ болоод хэрэгжихгүй байгаа асуудлууд гарч ирж байна шүү дээ. Жишээ нь, 10 аймгийн дулааны цахилгаан станц гээд асуудал байна. Сая Солонгосын компани дампуурсан. Нэг аймгийнх нь дулааны станц нь эхлээгүй байж байтал үндсэндээ нийт зээл, тусламжийнх нь бараг 40, 50 хувийнх нь санхүүжилт нь гарсан. Түүн дээр нь бид Засгийн газар мэдээж хүү төлж байгаа байх.

Тэгэхээр одоо ийм нөхцөл байдал, ийм эрсдэлтэй, ийм дампуурсан компанийг сонгон шалгаруулаад, эргээгээд улсынхаа төсвөөс бид үүнийх нь хор хохирлыг нь барагдуулж байгаа асуудлууд дээр хэн хариуцлага хүлээх ёстой юм бэ?

Тэгэхээр би хэлээд байгаа зүйл нь ерөөсөө бид ямар ч төсөл, хөтөлбөрүүд дээрээ эрсдэлийн үнэлгээ хийж, нарийвчилж тооцоо судалгаа, шинжилгээгээ хийдэг байхгүй бол нөхцөл байдал ийм байгаад байна. Өнөөдөр Улаанбаатар хотод бас нэг бухимдалтай, манай амьдарч байгаа хорооллын урд ч гэсэн энэ Хүннү-22-ын хороолол руу болоод наад талын тэр нэг Номингийн хорооллууд руу татаж байгаа Дэлхийн банкны санхүүжилтээр хийж байгаа зээлийн асуудал.

Гэтэл магадгүй хариуцлагагүй барилгын компаниудын тэр 20, 30 ширхгээр нь 20, 30 давхар байшин барьж байхын төлөө улсын төсвөөс татвар төлөгчид дулааных нь шугам сүлжээг өргөтгөх ажлыг гаднын зээл, тусламжаар хийж байгаа нь өөрөө зөв юм уу гэдэг асуудал байгаа юм. Бараг хувийн хөрөнгө оруулалт руу хийж байгаа хөрөнгө оруулагч болчихоод байгаа байхгүй юу. Алдаатай. Магадгүй тэр хотын дүрэм стандартыг түгжрэлээс тогтоосон энэ асуудлууд дээр ингэж байгаа нь зөв юм уу?

Тэгэхээр би хэлээд байгаа зүйл нь төсөв гадаад зээл, тусламж дотор чинь эргэж харах, үнэлж дүгнэж үзэх энэ алдаатай оноотой зүйлүүд байгаа юм шүү гэдэг зүйлийг хэлэх гээд байгаа юм. Үүнийг ч аудитын байгууллага, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, Олон Улсын Валютын Сангууд ч гэсэн гаргаж ирж Монгол Улс энэ дээрээ дүн шинжилгээ хийгээч ээ. Хэрэв ямар нэг томоохон төсөл, хөтөлбөр зээл, тусламж авах гэж байгаа бол яг өөрсдийнхөө санхүүжилтийнхээ олдоц болоод төсвийнхөө цар хүрээндээ нийцүүлж эргээд нэг эрэмбэ зүй харуулж хийдэг байгаач ээ. Гадаад зээлийнхээ хамаарлыг багасгаач ээ гэсэн дүгнэлтийг гаргаж ирээд байгаа шүү.

Тэгэхээр би энэ нөхцөл байдлыг эцэст нь дүгнээд нэг саналаа хэлье. Тэгээд эдийн засгийн нөхцөл байдлаас хамаараад бид бодит эрсдэлээс сэргийлэх зайлшгүй шаардлагатай байгаа.

Тэгэхээр зарчмын өнцгөөс хандаж манай Байнгын хорооны гишүүд энэ саналыг гаргаж мэдээллийг сонсьё гэсэн байгаа.

Тэгэхээр бид нэг талдаа төсөв, санхүүгийн эрсдэлтэй энэ асуудлууд дээр хариуцлагатай хандах ёстой. Мэдээж тодорхой хэмжээнд тодорхойгүй байгаа нөхцөл байдлууд дээр төсөв ч учирч болзошгүй эрсдэлүүдийг бууруулах зайлшгүй шаардлагатай байгаа. Тэгээд энэ үүднээс энэ мэдээллүүдийг сонсож байна.

Тэгэхээр Та бүхэн дараа дараадаа Улсын Их Хурал дээр энэ явцтай холбоотой мэдээллүүдийг тогтмол өгч байгаарай. Төслүүдийнхээ үр ашгийн эрэмбийг тодорхой зөв гаргаж дүгнэдэг байх асуудлуудыг яагаарай. Бид бас өмнөх төсөв батлах үед ч гэсэн гадаадын зээл, санхүүжилтийг цэвэр эдийн засгийн өсөлтийг дэмжих шууд үр өгөөж авчрах энэ томоохон дэд бүтцийн

болоод ийм төсөл, хөтөлбөрүүд дээр хийгээч ээ гэдэг чиглэлийг гаргаж ирж байсан.

Дээрээс нь хувийн хэвшлийн хийх боломжтой төслүүдийг гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэхгүй байх гэдэг асуудлыг гаргаж ирж тавьсан байгаа.

Дээрээс нь саяын тэр төрийн болон орон нутгийн өмчтэй компаниуд энэ хуулийн этгээдүүд дээр үүссэн өр авлага, зээлийн асуудлууд дээр бодит дүн шинжилгээг хийгээд Улсын Их Хурал дээр танилцуулаарай. Хугацаатай үүрэг даалгавар өгсөн. Энэ хугацаа нь өнгөрөөд явж байгаа гэдэг зүйлийг дүгнээд хэлэх гэсэн юм. Баярлалаа.

Мэдээлэлтэй холбогдуулаад нэмж үг хэлэх гишүүд байна уу? Гишүүд асуулт асууж дууссан байгаа.

Н.Батсүмбэрэл гишүүнээр тасаллаа.

Н.Батсүмбэрэл: Бид энэ асуудлыг нэлээн анхаарах ёстой юм шиг байгаа юм.

Тэгээд Байнгын хорооны даргад санал хэлэхэд Монгол Улсын өр, зээлтэй холбоотой асуудлаар энэ оны үед төсөв батлагдсаны дараа 12 сард ч байдаг юм уу, эсвэл он гарч байгаад дахиж нэг мэдээлэл сонсьё. Тэр үед энэ өөрчлөлтүүд яаж гарах вэ? Энэ дээр гишүүд нэлээн мэдээлэлтэй болж авах нь зөв байна. Ингээд харж байхад, мэдээллүүдийг уншиж байхад төсөв өөрөө улсын төсөв өөрөө тэлж байгаа учраас, томорч байгаа учраас төсөвт эзэлж байгаа зээлийн хэмжээ багасаад байгаа юм шиг харагдаад байгаа. Мэдээж бас энэ холбогдох хүмүүс ажиллаж байгаа байх. Тэгээд үүнийг дахиад нэлээн нягталж үзэх асуудлууд байна.

Тэр мэдээлэл дотор байгаа 3.6 хувь нь дотоод өр гэж байгаа. Өнөөдөр бид дотоод өр сонссонгүй шүү дээ.

Тэгэхээр энэ

- 3.6 хувь дотоод өрийн зээлдүүлэгч нар хэн бэ.
- Тэр зээл юунд зориулж авагдсан бэ.
- Ямар байдалтай байгаа вэ гэдгийг сонсох хэрэгтэй.

Дээрээс нь 0.5 хувийг эзэлж байгаа өрийн баталгааны асуудал. 2024 оны сүүлийн дүнгээр шүү дээ.

- Энэ өрийн баталгаанууд хаана гарав, ямар үр дүн гарав гэдгийг мэдэж авах шаардлагатай байна.

Засгийн газрын өрөнд орж тооцогддоггүй өөрийн мэдээллүүдийг авах шаардлагатай байна. Энэ дотор саяын яриад байгаа Хөгжлийн банкнаас эхлээд маш олон асуудлууд байна шүү дээ. Нэг харахад Хөгжлийн банк нь өөрөө байх байхгүй дээрээ тулсан байдалтай очсон байсан байдалтай байгаа.

Тэгэхээр энэ мэдээллүүдийг дэлгэрэнгүй авмаар байна.

Тэгээд энэ саяын өгсөн мэдээллүүдийг Сангийн яам албан бичгээр албан ажлын байдлаар өгөөч ээ. Энэ тэмдэглэлд оруулъя.

Тэгээд Байнгын хороон дарга түрүүн хэлсэн. Энэ зээлтэй холбоотой мэдээллийг дахиад сонсьё. Энэ бол бид нэг удаа сонсоод орхиж болохгүй. Хугацааны хувьд оны эцэст төсөв баталсны дараа, эсвэл он гаргаж байгаа бид сонсох ёстой. Тэгж байж илүү дэлгэрэнгүй мэдээллүүдээ авна.

Нөгөө Оюу Толгойтой холбоотой өрийн асуудал чинь 90 орчим хоног үлдээд байгаа.

Бид багш, ажилчдынхаа цалинг нэмэгдүүлж чадахгүй байж байж өдөрт 10 тэрбум төгрөгийн зээлийн хүү төлж байгаа. Энэ зээл яаж шийдэгдсэн бэ гэдгийг сонсох ёстой. Сая Сангийн сайд байр сууриа хэлсэн.

Тэгэхээр үүний үр дүнг бид сонсох ёстой гэж үзэж байна.

Аудит байдаг. Үндэсний аудит. Энэ эрсдэлийн үнэлгээ, үр дүнд нь хариуцлага тооцсон байдал гээд сая Г.Тэмүүлэн гишүүний яриад байгаатай санал нэг. Үүнтэй холбоотой Монгол Улсын өр, гадаад өр, дотоод өр, өрийн баталгаа, Засгийн газрын өрд ногддоггүй төрийн өмчит компаниудын өрүүд дээр та хэд дүн шинжилгээ хийсэн юм байна уу? Үүнийгээ байгаа бол ажил хэргийн шугамаар албан бичгээр ирүүлээч ээ.

Энэ дээр дараагийн удаа Үндэсний аудитын мэдээллийг сонсмоор байна. Энэ аудит гэдэг байгууллага маань өөрөө нүдээ хаагаад, чихээ таглаад, амаа хумиад сууж болохгүй шүү дээ. Энэ асуудал дээр.

Улс орны эдийн засгийн асуудал, энэ өрийн асуудлаа бид нэлээн өргөн хүрээтэй дахиад ярих хэрэгтэй гэдэг ийм саналыг гаргаж байна.

Г.Тэмүүлэн: Н.Батсүмбэрэл гишүүнд баярлалаа.

Тэгэхээр гишүүдээс гаргасан саналын дагуу оны төгсгөлд байна уу, дараа оны эхэнд төсөв батлагдсаны дараагаар яг дэлгэрэнгүй мэдээллүүдийг сонсьё. Тэр дундаа аудитын байгууллагын сая өрийн удирдлагын менежменттэй холбоотойгоор гаргасан, хэрэгжилттэй холбоотойгоор гаргасан тайланг сонсоод ингээд бүгдээрээ нэгдсэн нэг байр сууринд хүрэх энэ асуудал байна. Энэ бол

нэг талдаа Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо энэ бүх зээл, тусламжуудыг, гэрээ хэлэлцээрүүдийг баталдаг мөртлөө одоо нөхцөл байдал дээр бид бас нэг тодорхой дүн шинжилгээ хийж, одоогийн нөхцөл байдал дээр нэг эрүүлээр харах энэ шаардлага байна гэдэг зүйл байгаа. Тэгээд үүнийг гишүүд онцолж хэлж байна гэж хэлэх байна.

Ингээд мэдээлэлтэй холбогдуулаад гишүүд үг хэлж дууслаа. /алх цохив/

Гадаад зээл, тусламжийн хэрэгжилт, нөхцөл байдлын хяналт гаргах Сангийн сайдын мэдээллийг сонсож дууслаа. /алх цохив/

Тэгээд ажлын хэсгийнхэнд баярлалаа.

Манай Байнгын хорооны өнөөдрийн дангаар хэлэлцэх асуудал дуусаж байна.

Одоо Төсвийн байнгын хороо болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хамтарсан хуралдааны бэлтгэлийг хангая.

Ингээд ирцийг дахиж авахаар байгаа. Хамтарсан хуралдаанаар зээлийн хэлэлцээрийг хэлэлцэх асуудал байна. Ингээд хамтарсан хуралдааны бэлтгэл ажлыг хангая.

Хуралдаан 3 цаг 11 минут үргэлжилж, 15 цаг 26 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД